



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 12 ДУГААР САРЫН 21-НИЙ ӨДӨР, ПҮРЭВ ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр, Пүрэв гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-12
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	13-91

1. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	16-43
2. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	43-49
3. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	49-57
4. “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	58-59
5. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	59-64
6. Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	64-84
7. Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	хойшлуулав
8. “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл	84-90

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
12 дугаар сарын 21-ний өдөр /Пүрэв гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 12 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Д.Батлут, Г.Мөнхцэцэг, Ч.Ундрэм, Л.Энх-Амгалан;

Чөлөөтэй: Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Б.Энхбаяр;

Эмнэлгийн чөлөөтэй: П.Анужин, Ц.Мөнхцэцэг;

Тасалсан: Ц.Анандбазар, Б.Дэлгэрсайхан, Б.Жавхлан, Ж.Сүхбаатар;

Хоцорсон: Ш.Адьяаа- 04 минут, С.Батболд- 1 цаг 25 минут, Б.Баярсайхан- 14 минут, С.Бямбацогт- 03 минут, С.Ганбаатар- 17 минут, Д.Ганбат- 45 минут, Н.Ганибал- 11 минут, С.Одонтуяа- 01 минут, Д.Өнөрболор- 38 минут, Ш.Раднаасэд- 22 минут, Г.Тэмүүлэн- 11 минут, Н.Учрал- 1 цаг 49 минут, Д.Цогтбаатар- 1 цаг 27 минут, Ж.Чинбүрэн- 03 минут, Б.Чойжилсүрэн- 04 минут, Б.Энх-Амгалан- 12 минут, Ж.Эрдэнэбат- 11 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяаа, Б.Пүрэвдорж, Ж.Батсуурь нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ш.Адьяаа, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Нэг. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт А.Банзрагчдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 11 цаг 02 минутаас хуралдааныг даргалав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж, Б.Баярсайхан, Б.Бейсен, Н.Ганибал, Ж.Батсуурь, Ц.Туваан, Ч.Хүрэлбаатар, Ш.Адьяаа, Г.Дамдинням, М.Оюунчимэг, Б.Баттөмөр, Ш.Раднаасэд, Д.Өнөрболор,

А.Адъяасүрэн, Т.Доржханд нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Сонгуулийн ерөнхий хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 12 цаг 06 минутаас хуралдааныг даргалж, үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 34
Татгалзсан: 13
Бүгд: 47
72.3 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./12:22/

Уг асуудлыг 12 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт А.Банзрагчдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Туваан нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн асуудлаар Улсын Их

Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 3 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 1 өдрийн завсарлага өгөв./12:47/

Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт А.Банзрагчдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Батлут, Н.Ганибал, Ж.Батсуурь, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт А.Банзрагчдорж, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нар хариулж, тайлбар хийв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	25
Татгалзсан:	20
Бүгд:	45

55.6 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа./13:22/

Уг асуудлыг 13 цаг 22 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв. “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Д.Сүнжид, мөн Комиссын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн Комиссын гишүүн Я.Цэлмэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Л.Хурцбилэг, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 11 минут үргэлжилж, 13 цаг 23 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 01 минутад эхлэв.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар хууль санаачлагч байхгүй тул уг асуудлыг хэлэлцэхийг хойшлуулав./14:20/

Тав.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.28-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрүүл мэндийн яамны Нийтийн эрүүл мэндийн газрын дарга Д.Баярболд, мөн яамны Халдварт бус өвчний хэлтсийн дарга Г.Ганхуяг, Хуулийн хэлтсийн мэргэжилтэн Э.Цэрэнчунт, Бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч Б.Нинж, Нийтийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Э.Баяртулга, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн захирал С.Өнөрсайхан, мөн төвийн Стратеги удирдлагын албаны дарга У.Эрхэмбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, референт Г.Нямсүрэн, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Ж.Чинбүрэн нар үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 14 цаг 27 минутаас хуралдааныг даргалав.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

С.Одонтуяа: 1. Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “Үйл ажиллагаанд баримтлах” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүн, нотолгоонд” гэж тус тус өөрчилж, 4.1.1 дэх заалтын “, тэгш хүртээмжтэй, чанартай” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4.1.8.чанар, үр ашигтай байх;

4.1.9.тэгш хүртээмжтэй байх;

4.1.10.жендэрийн эрх тэгш байдлыг хангах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 21

Бүгд: 40

47.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18

Бүгд: 40

55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Одонтуяа: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

Бүгд: 42

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 5.2.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.2.1.халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тандан судлах, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны судалгааны үр дүн, нотолгоонд суурилан зохион байгуулах;

5.2.2.нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25

Татгалзсан: 17

Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “байгууллагын” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 17
Бүгд: 42
59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 14 цаг 43 минутад хэлэлцэж дуусав.

Зургаа.Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.10.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, мөн яамны Хуулийн хэлтсийн дарга Д.Ренчиндорж, Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн Ж.Азжаргал, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын шинжээч Г.Оюунболд, Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга Б.Батсайхан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, мөн яамны шинжээч Б.Дуламсүрэн, Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Наранцэцэг, Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга А.Өнөржаргал, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга Л.Нямдорж, мэргэжилтэн Э.Оюун-Эрдэнэ, Харилцаа холбооны зохицуулах хорооны Зохицуулалтын бодлогын хэрэгжүүлэх газрын дарга Т.Батболд, мөн хорооны ахлах мэргэжилтэн А.Уранчимэг, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга П.Болормаа, Үндэсний аудитын газрын Санхүү-нийцлийн аудитын газрын аудитын ахлах менежер С.Бат-Эрдэнэ, мөн газрын менежер Ч.Болд, аудитын менежер Г.Мөнхчимэг, Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны үндэсний хүрээлэнгийн тэргүүн, судлаач, доктор Б.Жавзанхүү нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, референт Г.Нямсүрэн, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, М.Отгон, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, А.Адьяасүрэн, Д.Сарангэрэл, С.Одонтуяа нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг нар хариулж, тайлбар хийв.

Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёолоор санал хураалт явуулав.

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, П.Анужин, Б.Баярсайхан, Б.Бейсен, Б.Жаргалмаа нарын /цаашид “Ажлын хэсэг” гэх/ гаргасан 1.Төслийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 21
Бүгд: 41
48.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 17
Бүгд: 40
57.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Одонтуяа: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 1.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын “учруулахуйц үл хайхрах” гэснийг “учруулах” гэж өөрчилж, мөн заалтын “сэтгэл санаа,” гэсний дараа “эдийн засаг” гэж, мөн зүйлийн 1.12 дахь заалтын “кейс менежмент” гэсний өмнө “тохиолдлын зохицуулалт” гэж тус тус нэмж, 1.11 дэх заалтын “хүүхдийн эцэг, эх болон хүүхдийн эцэг, эхтэй гэрлэсэн хүн ороогүй, түүнчлэн” гэснийг, мөн зүйлийн 2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 1 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 1.6, 1.15, 1.16 дахь заалтыг тус тус нэмэх:

“1.6.“хүүхдийг үл хайхрах” гэж хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, үүрэг хүлээсэн бусад этгээд хүүхдийн аюулгүй байдал, бие махбод,

эрүүл мэнд, сэтгэл санаа, боловсрол, хөгжлийн хэрэгцээг гачигдуулсан, асран хамгаалах үүргээ биелүүлээгүйн улмаас хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсныг;

1.15.“хориотой агуулга” гэж хуулиар хориглосон контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг;

1.16.“хүүхдэд хортой агуулга” гэж хуулиар хориглоогүй боловч хүүхдийн эрүүл мэнд, нас, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн 1.5 дугаар зүйлийн 1.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “хүүхдэд зааж сургахдаа” гэснийг “хүүхэдтэй харилцахдаа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Төслийн “ХОЁРДУГААР БҮЛЭГ” гэснийг “ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ” гэж өөрчилж, 2.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх:

“5.Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил, үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Төслийн 2.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 1.4 дэх заалтын “этгээдийг” гэснийг “этгээдэд тавигдах шаардлага,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Төслийн 2.4 дүгээр зүйлийн 1.5, 1.6 дахь заалтыг 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шилжүүлж, 1.16, 1.17 дахь заалт болгох гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Төслийн 2.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “мэргэжлээр дээд боловсролтой,” гэснийг “, эсхүл боловсрол, нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшиж” гэж өөрчилж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын “үнэлгээ хийх,” гэсний дараа “дүгнэлт гаргах,” гэж, мөн зүйлийн “кейс” гэсний өмнө “тохиолдол” гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.9 дэх заалт нэмэх:

“2.9.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцох;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 20
Татгалзсан: 20
Бүгд: 40
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

С.Одонтуяа: Горимын санал дэмжигдсэн тул дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 2.7 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.Сум, хорооны 3000 хүртэлх хүн амд нэг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан байхаар тооцож сум, хороо бүрд ажиллуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Д.Цогтбаатар, Ц.Мөнх-Оргил, Д.Өнөрболор, Б.Баярсайхан нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 19

Татгалзсан: 21
Бүгд: 40
47.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсенгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 19
Бүгд: 40
52.5 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Хуралдаан даргалагч дээрх асуудлаар гүйцээн боловсруулах чиглэл өгөв.

С.Одонтуяа: 9.Төслийн 2.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1.Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина.

2.Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл улирал тутам хуралдаж, хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад хуулийн этгээдэд зөвлөмж өгч, хүүхэд хамгааллын бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад талуудын оролцоог хангаж, санал, дүгнэлт гаргана.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал, Ц.Идэрбат, Ж.Батсуурь нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 15
Татгалзсан: 22
Бүгд: 37
40.5 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Төслийн 2.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.2 дахь заалт нэмэх:

“1.2.Төсвийн тухай хуулийн 8.5.1-д заасны дагуу тухайн шатны жилийн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ хүүхэд хамгааллын үйлчилгээ, хамтарсан баг болон хууль зүйн хорооны үйл ажиллагааны зардлыг тусгах;

2.2.Төсвийн тухай хуулийн 8.5.3-т заасны дагуу тухайн шатны жилийн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ хүүхэд хамгааллын үйлчилгээ, хамтарсан баг болон хууль зүйн хорооны үйл ажиллагааны зардлыг тусгах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 17
Татгалзсан: 21
Бүгд: 38
44.7 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан үг хэлэв.

Хүүхэд хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дэд дарга Н.Ганибал ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 5 өдрийн завсарлага өгөв./16:15/

Долоо.Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.11.29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.Есөн-Эрдэнэ, мөн газрын ахлах мэргэжилтэн Б.Уранчимэг, Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Хөрс, ургамал хамгаалал, үр сортын хэлтсийн дарга Н.Оюунсүвд нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Б.Баярсайхан нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа хууль санаачлагч байхгүй тул уг асуудлыг хэлэлцэхийг түр хойшлуулав./16:22/

Найм.“Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Нийгмийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Цогзолбаяр, Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг нар байлцав.

Төслийн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Хянан шалгах түр хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэл, Х.Булгантуяа, Б.Бейсен нарын тавьсан асуултад Хянан шалгах түр хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу Баасан гарагийн чуулганы нэгдсэн хуралдаанаар санал хураалтыг явуулах талаар мэдэгдэв./16:45/

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэхийг үргэлжлүүлэв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа хууль санаачлагч байхгүй тул дээрх асуудлыг хэлэлцэхийг дахин хойшлуулав./16:50/

Бусад. Улсын Их Хурлын гишүүн Ж.Ганбаатарын урилгаар Баянгол дүүргийн цэцэрлэгийн эрхлэгч нар, Улсын Их Хурлын гишүүн Н.Учралын урилгаар Социал демократ Монголын залуучуудын холбооны сайн дурын ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын урилгаар Хустайн байгалийн цогцолборт газрын ажилтнууд, Улсын Их Хурлын гишүүн Д.Сарангэрэлийн урилгаар Хан-Уул дүүргийн хороодын Засаг дарга нар, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хүндэт харуулын ротын хугацаат цэргийн албан хаагчид, Өмнөговь аймгийн Говийн байгаль түүхийн музейн ажилтнууд, Шихихутуг Их сургуулийн бизнесийн эрх зүйн 2в ангийн оюутнууд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 7 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 6 цаг 00 минут үргэлжилж, 72 гишүүнээс 57 гишүүн хүрэлцэн ирж, 79.2 хувийн ирцтэйгээр 16 цаг 50 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр,
Пүрэв гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 12 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 12 дугаар сарын 21-ний өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 8 асуудал хэлэлцэнэ.

1 дүгээрт, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

2 дугаарт, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

3 дугаарт, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

4 дүгээрт, “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл,

5.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлэг,

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

7-д, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

8-д, “Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулж, энэ хэлэлцэхээр тогтсон асуудлын тов дарааллыг өөрчлөх, асуудал нэмэх, горимын санал гаргах бол чуулган эхлэхээс өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ширнэнбаньдын Адьшаа, Бөхчулууны Пүрэвдорж, Жамбын Батсуурь нараас албан бичиг ирүүлсэн байна. Ингээд Ширнэнбаньдын Адьшаа гишүүн. Ширнэнбаньдын Адьшаа гишүүн алга байна.

Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Энэ хаврын Нийгмийн даатгалын ерөнхий хуулийг батлах явцад энэ миний өргөн барьсан 7 жилийг 5 жил болгож, нөхөн бодох хуулийг хэлэлцэж баталсан. Тэгээд энэ хуулийн дагуу 01 сарын 01-нээс 5 жилээр ахмадууд маань тэтгэврээ бодуулж эхэлнэ. Тэгээд ахмадууд нийгмийн даатгалын харьяа хэлтэс, байгууллагууд дээр очиж байна. Очингуут нь өргөдөл бөглүүлчхээж байна. Тэгэнгүүт өргөдөл бөглөнгүүт нь танай юу чинь, хариу чинь и-монголиа-аар очно гээд явуулчихдаг. Тэгээд очоод буцаж ирээд харахаар 1000

төгрөгөөр л тэтгэвэр нэмэгдэж байна. Зарим хүмүүсийнх 100 мянган төгрөгөөр буурч байна. Тэгээд ийм гомдлууд маш их гараад байна.

Тэгэхээр энэ би энэ программ дээр тодорхой асуудал байна гэж би харж байгаа, хардаж байгаа. Яагаад гэвэл 100 мянган төгрөгөөр тэтгэвэр буух ямар ч үндэс байхгүй. Тэгэхээр энэ юу илэрхийлж байна вэ гэвэл түүн дотор, надад 1 ахмад хэлсэн. Энэ программ дотор нь байна шүү дээ, тийм ээ, ингээд бүгдийг нь ингээд бодохоор бүгд зөв. Яг нөгөө цалингийн хувьд 45 хувиар энэ тэр бодохоор яг зөв гараад байна. Энэ программ дотор юу 2022 оны 02 сарын 01-ний тэтгэврийн нэмэгдлийг тооцохгүйгээр зөвхөн 2023 оны 07 сарын 01-ний тэтгэврийн нэмэгдлийг 10 хувиар нэмсэн нэмэгдлийг тооцоод ингэж гаргаад байна. Тийм учраас энэ программ дотор асуудал байна аа гэж хүмүүс яриад байгаа юм. Тэгэхдээ ер нь нийтдээ Сангийн сайд яг энэ төсөв баталж байх үед 140 тэрбум төгрөг энэ чиний хуулийн чинь, 2 хуулийн чинь хүрээнд ард иргэд дээр очиж байгаа гэж ярьсан. Яг ингээд төсөв батлахад 20,9 тэрбум төгрөг очихоор батлагдсан байж байгаа. Яг энэ нөхөн бодох хуулийн хүрээнд. Тэгэхээр энэ дээр энэ программ дээр бас тодорхой асуудлууд байна. Яг энэ бодолт дээр, төр мэдээж аль болох л бага мөнгө өгөхийг хүсдэг. Түүнийхээ хүрээнд л энэ программыг хийсэн юм шиг байна.

Тийм учраас би энэ ажлын хэсэг гаргана. Ялангуяа Ардчилсан намын үед ажиллаж, нийгмийн даатгалын байгууллагаар ажиллаж байсан туршилагатай хүмүүсийг ажлын хэсэг болгоод тэгээд дээрээс нь тэтгэвэрээ бодуулж, асуудалтай байгаа тэр хүмүүсийн бүгдийнх нь өргөдлийг хүлээж авч байгаад, тэгээд энэ яаж бодогдсон, ямар асуудал гарсан, ийм асуудлуудыг бүгдийг нь шийдвэрлэх зорилготой ажиллана.

Тэгэхээр ер нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын

удирдлагуудтай өчигдөр ярьсан. Энэ хүрээнд тайлбарлахдаа нийтдээ 58 мянган ахмадуудын ойролцоогоор 42, 3 мянга нь бол нэмэгдэж байгаа. Нийтдээ нэг ахмад дунджаар бодоход нэг ахмадад 55 мянган төгрөг очиж байгаа гэдэг ийм мэдээллийг надад өгсөн, сар болгон. Тэгэхээр энэ хангалттай биш. Яагаад гэвэл дунджаар 120 мянган төгрөг гарах ёстой, 120 мянган төгрөг гарах ёстой. Тийм учраас энэ нийгмийн даатгалын хэлтсүүд дээр очиж ажиллаж, бас тодорхой хэмжээгээр энэ зарим нэгэн очерлож байгаа тэр ахмадуудын тэтгэвэр яаж нэмэгдэж байгаа талаар бас ажиллах болно. Тэгээд хэд хэдэн ажлын хэсэг гаргаж, энэ Улаанбаатар хотын нийгмийн даатгалын хэлтсүүд дээр ажиллана. Тэгээд манай АН-д ажиллаж байсан, нийгмийн даатгалын байгууллагад ажиллаж байсан туршилагатай хүмүүс, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга байсан Уртнасантай холбогдоорой гэж хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Эрхэм гишүүдийнхээ өнөөдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Засгийн газраас өчигдөр Эрдэнэс тавантолгойн 1072 хувьцааг Монгол Улсынхаа иргэдэд өмчлүүлэх тухай ийм шийдвэр гаргалаа. Миний бие Монгол Улсын Их Хурлын гишүүнийхээ хууль санаачлах бүрэн эрхийн хүрээнд иргэдээс худалдаж авсан 1072 хувьцааг буцаан эзэмшүүлэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл өргөн бариад Төсвийн байнгын хороогоор хэлэлцээд, дөрвөн 7 хонож байна. Үүнийг энэ Улсын Их Хурлын даргын зөвлөл энэ хуулийн төслийг хэлэлцүүлж өгмөөр байна. Сонгууль бүрийн өмнө ард иргэдээ хуурч авсан энэ 1072 хувьцааг иргэн бүртэй буцааж эзэмшүүлж олгох нь шударга ёсонд нийцнэ. Мэдээлэлгүй, дээр нь хөрөнгө мөнгөний чадваргүй хүмүүсийг далимдуулаад сонгууль бүрийн өмнө Ардчилсан нам, Ардын нам хоёулаа нийлж энэ иргэдийнхээ сая гаруй хүний

хувьцааг буцааж худалдаж авсан байдаг. Үүнийг үнэ төлбөр авъя гээгүй, ноогдол ашгаас нь суутгах зарчмаар авъя гэсэн ийм үзэл баримтлалтай байгаа юм.

2 дахь асуудал. Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын нөлөөллийн бүсэд байгаа иргэн бүрд 30 сая төгрөгийн нөхөн олговор олгох тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Чимэдийн Хүрэлбаатартай хамт өргөн мэдүүлж, жил гаруй хугацаа өнгөрч байна. Энэ хуулийн төслийг оруулж ир ээ. Одоо Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцын хөрөнгө оруулалт ажил хавар эхэлнэ. Ингэж тэнд бүсэд амьдарч байгаа ард иргэдийн амьдрах нөхцөл, тэр ахуй амьдралаа авч явах хөрөнгө мөнгөний асуудлыг Монголын төр шийдэж байж тэрэнд төсөл хэрэгжих нь ач холбогдолтой гэдэг ийм саналыг оруулж байна. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Одоо санал оруулахгүй л дээ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хэлчихсэн тийм ээ. Жамбын Батсуурь гишүүн. Одоо Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Улаанбаатар хотод нүүрсний сонсгол гээд нэг жүжиг, түгжрэл, утаа, сонгуулийн тойрог гээд нийгмийг халж байхад хөдөөд ард иргэд хөр цасандаа дарагдаад, зудад боогдоод, байдал хүндэрлээ. Тэгээд энэ талаар олон удаа чуулган дээр үг хэлж, Засгийн газарт чиглэл өгсөн боловч арга хэмжээнүүд авагдахгүй байна. Зүүн бүс нутаг бүхэлдээ зудын байдалд орж, Хэнтий, Дорнод, Сүхбаатарын мал, бод мал уруудаж, Мэнэнгийн тал, Матад орчимд тэнд хэдэн 100 мянгаар, хэдэн мянгаараа 30, 40, 50 мянгаараа бод мал очсон байна. Тийм учраас би Засгийн газрыг, онцгой байдлын газрыг ойрын хугацаанд отрын бүс нутаг байгуулаач гэж хэлэх гэж байна. Адьшаа гишүүн ээ, сайдыг чагнуулаадхаач, хөөе Адьшаа, сайдыг чагнуулаадхаач. Отрын бүс нутаг байгуулаач гэж хүсэж байна. Хөдөөд,

Адьшаа, Адьшаа би сайдад юм яриад байна. Минутаа авъя аа, дарга.

Тийм учраас Мэнэнгийн тал нутагт 40, 50 мянган балл бий боллоо. Гэр орноосоо 200-300км-т байна. Тэнд онцгой байдлын газар, аймгийн ХААЯ бусад газрууд нийлж отрын штаб байгуулмаар байна. Холбоо барих газартай болгемоор байна. Эмч домч очмоор байна. Татах чирэх машинуудыг тэнд аваачмаар байна. Мэнэнгийн отрядыг түшиглээд, зүүн 3 аймгийн онцгой байдлын газар хамтраад отрын штаб байгуулах ийм саналтай байна. Үүнийг Засгийн газраар шийдүүлж өгмөөр байна. 1 дүгээр асуудал.

2 дугаар асуудал. Зам, тээврийн сайдад уламжлахад энэ хот хоорондын замын арчилгаа маллагаа муу байна. Дөнгөж л нэг хөр цасыг нь авсан төдий халтиргаа гулгаанаас нь салгаж чадахгүй байна. Замын ухмал дахин нэг дээгүүр машин зөрөх боломжгүй байж байна, машин зөрөх боломжгүй байж байна. Тэгээд энд нөгөө давс, аймгуудынхаа авто замыг арчилгааны газрыг ажиллуулах хэрэгтэй байна.

Дээр нь ХААЯ малын тэжээл, өвсийг хилээр гаргах асуудлыг бүрэн зогсоох шаардлагатай байж байна. Мөн мах боловсруулах үйлдвэрүүдэд төрөөс дэмжлэг олгож, малчдын гар дээр байгаа мал, махыг худалдан авах ажиллагааг эртхэн зохион байгуулахгүй бол удахгүй урин цаг ирж тэнд ч нэг мах ялзарч, энд ч нэг мах өмхийрч нөхцөл байдал хүндэрнэ шүү гэдгийг бас эртхэн сануулж байя гэж ингэж бодож байна. Тэгээд ингээд арай чүү нэг үг хэлэнгүүт хуралдааны дарга аа, ерөөсөө үг сонсохгүйгээр энд тэнд очиж юм яриад энэ сайд нарын анхаарал хандуулахгүй байна. Үнэхээр ач холбогдол өгөхгүй байна. Тийм учраас энэ ажил чинь явахгүй байна шүү дээ. 2 сарын өмнө хэлж байсан зүйлүүд өнөөдрийг ортол бий болохгүй байна.

Хөдөөд бензиний хомсдол хэвээрээ байж байна. Эндээс 800, 1000 км-т түли 7 мянга хүрчхээд байгаа нь тодорхой

болж байна. Төвөөсөө мэдээж шийдэгдэж л байгаа байх. Тэгээд энэ олон асуудлуудыг Засгийн газарт чиглэл өгч, Их Хурлаас ажлын хэсэг гаргаж хяналтдаа авахгүй бол энэ нөхцөл байдалд энд хэлээд, хэлээд, чарлаад чарлаад яг бодит ажил болохгүй байна. Тэгээд энэ дээр Улсын Их Хурлын дарга анхаарч хяналтын юм уу, үүрэг даалгавар өгсөн ажлын хэсэг гаргаж өгмөөр байна.

Г.Занданшатар: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн суудалдаа суу. Та яагаад энэ Батсуурь гишүүнийг үг хэлж байхад хандаж байгаа сайд болгон дээр нь очоод ингээд үймүүлээд яваад байдаг юм. Хөдөө аж ахуйн асуудал ярихаар Хөдөө аж ахуйн сайд дээр, шатахууны асуудал ярихаар Ганбаатар сайд дээр. Зориуд санаатай үймүүлээд байдаг юм уу та ер нь.

Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Жамбалын Ганбаатарын урилгаар БГД-ийн цэцэрлэгийн эрхлэгч нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхныг хүсэн ерөөе. Сурган хүмүүжилдүүлэх үйлсэд нь их өндөр амжилт хүсье.

Энэ өвөлжилтийн байдал онцгой хүндэрч байгаа. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэр, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо энэ малчдын энэ өвөлжилтийн нөхцөл байдалтай холбогдуулж арга хэмжээ авч хэд хэдэн удаа хэлэлцсэн. Байнгын хорооноос ажлын хэсэг гарсан байгаа. Батжаргал гишүүн ээ, Батжаргал дарга аа, Байнгын хорооноос ер нь энэ шаардлагатай бол орон нутагт ажиллаж энэ хагас, бүтэн сайн өдөр ажиллаж, хөдөөгөөс сонгогдсон гишүүд тойрогтоо ажиллах үүрэг чиглэл болгосон. Үүнийгээ нэг авч хэлэлцэж нэг Батсуурь гишүүн, олон гишүүд яриад байгаа. Энэ өвөлжилттэй холбоотой асуудлаар шаардлагатай арга хэмжээ

Улсын Их Хурлаас болон Засгийн газраас авах арга хэмжээний талаар бас малчдын санал сэтгэгдэл дээр үндэслэж арга хэмжээ авах нь зүйтэй байх шүү. Тийм ээ, ажлын хэсгээ эргэж нэг нягталж хуралдуулъя. Өвөл урт сунаж байна шүү.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд танилцуулна.

Н.Энхболд: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу Улсын Их Хурал ээлжит сонгуулийн жилийн 2 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө сонгуулийн тойрог байгуулах бөгөөд ийнхүү тойрог байгуулахдаа тойрогт ноогдох мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоохоор заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хорооноос “Монгол Улсын Их Хурлын 24 оны ээлжит сонгуулийг тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2023 оны 12 сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурал 2023 оны 05 сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт оруулсан өөрчлөлтөд нийцүүлж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг 2023 оны 06 сарын 16-ны өдөр баталсан. Монгол Улсын Их Хурлын

сонгуулийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно. Монгол Улсын Үндсэн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Улсын Их Хурлын 78 гишүүнийг энэ хуульд заасны дагуу байгуулагдсан сонгуулийн тойргоос олныг төлөөлөх мажоритар аргаар, Улсын Их Хурлын 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх пропорциональ аргаар сонгоно гэж тус тус заасан.

Сонгуулийн тойргийг байгуулахдаа бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг хангах, аймаг, дүүргийн хүн амын тоо, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, газар нутгийн хэмжээ, байриил, Улсын Их Хуралд суудалтай болон улс төрийн бусад намуудтай зөвшилцсөн байдал, сонгуулийн тойрогт хамаарах засаг захиргаа нэгж нь нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл, хилийн цэсийн хувьд зэргэлдээ байх зэрэг хуулийн зохицуулалтуудыг харгалзан түүнчлэн УБЕГ-аас 2023 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаарх улсын хэмжээний хүн ам, сонгуулийн насны иргэдийн тоог аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороогоор нэгтгэж ирүүлснийг үндэслэн “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан болно.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойргийг орон нутагт бүсчилсэн 7, нийслэл Улаанбаатарт 6, нийт 13 байхаар тусгалаа. Үүнд: Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгуудыг нэгтгэн 1 дүгээр тойрог, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгуудыг нэгтгэн 2 дугаар тойрог, Баян-Өлгий аймаг 3 дугаар тойрог, Булган, Орхон, Хөвсгөл аймгуудыг нэгтгэн 4 дүгээр тойрог, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудыг нэгтгэн 5 дугаар

тойрог, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг нэгтгэн 6 дугаар тойрог, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудыг нэгтгэн 7 дугаар тойрог, БЗД 8 дугаар тойрог, БГД 9 дүгээр тойрог, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийг нэгтгэн 10 дугаар тойрог, СХД 11 дүгээр тойрог, Хан-Уул дүүрэг 12 дугаар тойрог, Багануур, Багахангай, Налайх дүүргүүдийг нэгтгэн 13 дугаар тойрог байхаар тооцлоо.

2019, 2023 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг нэг мөр хэрэгжүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах бодит суурийг тавих, хэт төвлөрлийг бууруулах, эдийн засгийн нөөц боломжийг дунд, урт хугацааны хөгжлийн зорилтуудтай уялдуулан зохистой хуваарилж ашиглах, хөгжлийн томоохон төвүүдийг бий болгож улмаар улс орны эдийн засгийн бие даасан чадавх, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгааг дээшлүүлэх зорилтыг үндэслэл болгосон болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүн Занданшатар Сонгуулийн ерөнхий хорооноос иргэдийн улс төрийн оролцоо, сонгогчдын боловсролыг нэмэгдүүлэх талаар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Батсуурь сонгуулийн тойргийн төвийг хэрхэн тогтоосон, санал тоолох төхөөрөмжөөс хүчингүй саналын хуудас гарах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Доржханд Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойргийг байгуулахдаа нийслэлийг 1 тойрог болгох боломжийн талаар ярилцсан эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Занданшатар Улсын Их Хурлын сонгуулийн тойргийг бүсчлэх байдлаар тогтоох нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын зорилго, зорилтыг хангах, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан

өөрчлөлтийг амьдралд хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийн нутаг дэвсгэрийн тэнцвэргүй байдлыг бууруулах, бүсчилсэн хөгжлийг бэхжүүлэх ач холбогдолтой талаар, мөн Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улс төрийн байгууламжийн хувьд нэгдмэл учир сонгуулийн 3 дугаар тойрог буюу Баян-Өлгий аймаг нь тусдаа бүс нутаг биш харин хөгжлийн Баруун бүсийн бүрэлдэхүүн хэсэг дангаар тойрог болгон хуваарилсан нь үндэсний цөөнхийн сонгох сонгогдох эрхийг хүндэтгэж буйн илэрхийлэл болох талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь Улсын Их Хурлын ээлжит сонгуульд хөгжлийн бэрхшээлтэй иргэд санал өгөх боломжийг бүрэн хангахад Сонгуулийн ерөнхий хороо анхаарч ажиллах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Доржханд парламентын ардчиллыг бэхжүүлэх, улс төрийн намуудыг төлөвшүүлэх, аль нэг намын биш улс орны нийтлэг эрх ашгийг хангахын тулд сонгуулийн тойргийг томсгож, Улсын Их Хурлын сонгуулийг зохион байгуулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Амарсайхан тойргийг бүсчилсэн хэлбэрээр тогтоох нь зүйтэй бөгөөд нийслэлийн Багануур, Багахангай Налайх дүүргүүдийг нэгтгэж сонгуулийн 1 тойрог болгож байгаа нь бүс нутгийн онцлогтой эдийн засгийг хөгжүүлэх боломжийг бүрдүүлэх ач холбогдолтой талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж батлуулах нь зүйтэй гэсэн саналыг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг

дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Энхболд даргад баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя Сонгуулийн ерөнхий хорооны дарга Пүрэвээгийн Дэлгэрнаран, УБЕГ-ын дарга Лхагвадоржийн Дэлгэрсайхан, Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга Дугардоржийн Баяндүүрэн, Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт Алтанцэцэгийн Банзрагчдорж.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Алга байна.

Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүнээр тасаллаа. Тийм, орох нь орчихсон л байна. Батсуурь, Туваан, Болорчулуун, Мөнхөөгийн Оюунчимэг, Баттөмөр гишүүн, Чинзориг гишүүн, Жигжидийн Батжаргал, Сандагийн Бямбацогт, Нанзадын Наранбаатар, Гонгорын Дамдинням, Жамбын Батсуурь хэлчихсэн шүү дээ. Түүрүүн. Салдангийн Одонтуяа, Ширнэнбаньдын Адьшаа гишүүн. Нэрсээ, энэ чинь өнөөдөр.

Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Гишүүдэд өглөөний мэнд хүргэе. Үндсэн хууль болоод сонгуулийн хуулийг дагалдаад л орж ирж байгаа энэ тойрогтой холбоотой тогтоол хэдийгээр тогтоол ч гэсэн энэ асар чухал тийм үр дагавар бүхий тогтоол бас орж ирж байна. Урьд өмнө

нь явж үзээгүй зам учраас өөрөө бас тийм олон талтай. Мэдээж төгс төгөлдөр зүйл гэж байхгүй, сайн тал ч бий бас, муу тал ч бий. Сайн тал гэвэл мэдээж улс орны эрх ашиг, бүс нутгийн эрх ашиг гээд ингээд олон зүйлүүд энэ дээр бас яригдана. Мэдээж ийм учраас намын бүлгүүд бас, намын бүлгүүд болоод Улсын Их Хурлын төлөөллүүд бас тал талаасаа ярилцаад зарчмын хувьд энэ шийдвэрийг ингээд дэмжээд явж байгаа.

Бас энэ ажлын хэсгээс бас нэг тодруулж асуух бас зарим зүйлүүд бас байгаа. Төгс төгөлдөр зүйл биш учраас бас энэ дотор анхаарах зүйл, сул талууд бас энэ дээр мэдээж бас гарч таарна. Тэгэхээр бид нар Үндсэн хууль болоод Сонгуулийн хууль дээр гарсан зарчмын өөрчлөлтийн зүйлүүд нь ер нь санал гээгдэхгүй байх гэдэг том зорилгыг тавьсан. Иргэдийн санал гээгдэхгүй байх, 1 дүгээрт нь.

2 дугаарт нь, ер нь 1 нэр дэвшигчээс гарах зардлыг бууруулна. Зардал бууруулснаар шинэ хүмүүс, залуучууд, эмэгтэйчүүдэд илүү боломж олгох ёстой гэдэг зүйлүүдийг бас ярьж байсан. Мөн олон намын төлөөлөл орох боломжийн тухай ярьж байсан. Тэгэхээр яг энэ томсгосон тойргийн тогтолцоогоор 1 нэр дэвшигчээс гарах зардлыг юу гэж тооцож байгаа вэ? Энэ нөгөө шинэ хүмүүс, залуучууд, эмэгтэйчүүдэд нөгөө боломжийн тухай би тодруулж хэлж өгөөсэй гэж хүсэж байна л даа.

2 дугаарт нь, энэ санал гээгдэх вий гэдэг өмнөх тогтолцооны сул талыг бид нар санал гээгддэг тогтолцоо гэж бас ярьдаг. Тэгэхээр энэ олон мандаттай тохиолдолд мандатын тоотой тэнцүү дугуйлах тохиолдолд олон санал хүчингүй болох вий. Үүнийг бид нар хэрхэн яаж сэргийлэх билээ? Энэ дээр бас нэг тодорхой байр сууриуд, арга замуудын тухай бас хэлээч ээ.

Ер нь тэгээд эцсийн дүндээ энэ өөрөө бас Монгол Улсад урьд өмнө олон жил бараг гучаад жил хийгдэж чадаагүй засаг захиргааны хуваарьтай холбоотой томоохон өөрчлөлтийг улс төрийн арга замаар бас ингээд түрүүлж, улс төр нь урдаа гарч, эдийн засаг нийгмийн асуудлаасаа түрүүлж гарч шийдэх гэж байгаа нь өөрөө их том чухал ач холбогдолтой болов уу гэж бодож байгаа. Зүгээр миний хувьд яг энэ асуудал дээр аль болох нэгэнт шийдэж байгаа бол бүр том тойргоор Монгол Улс 1 тойргоор байх, бүр болохгүй Улаанбаатар хот дараа нь 1 тойргоор байх. Улаанбаатар хот 2-оос илүү тойргоор байх ийм боломжийг энэ хуульд суулгаж ашиглая, энэ тогтоолын төсөл дээр ашиглая гэдэг санал гаргаж байсан ч гэсэн бас олонхоороо ингээд яг энэ байдлаар тодорхой хэмжээний бүсчлэлтэйгээр багцлаад явж байгаа болохоор энэ зарчмыг нэгэнт олонхын саналыг бас ингээд дэмжээд явахаас өөр аргагүй ийм нөхцөл байдалтай. Тэгэхээр түрүүний тэр давуу талаас гадна гол нь сул талуудыг хаах ямар боломж байгаа дээр бас нэг мэдээлэл судалгаа дүгнэлтээ бас танилцуулаач.

Г.Занданшатар: Ажлын хэсэг Бат-Эрдэнэ дарга хариулах уу? Дэлгэрнараран дарга уу. 83. Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ.

Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ.

Сонгуулийн зардлын тухайд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд нэр дэвшигчээс гарах зардлыг бууруулах талаар маш олон дэвшилттэй зохицуулалтыг хийсэн. Тухайлах юм бол сонгуулийн сурталчилгааны арга хэлбэр түүнд ноогдох тоо хэмжээг 50 хүртэл хувиар бууруулсан. Мөн дээрээс нь төрийн аудитын байгууллага зардлын дээд хэмжээг тогтоохдоо өмнөх оны гүйцэтгэл болон хэрэглээний үнийн индекстэй уялдуулж бодитой тогтоож

байх энэ боломжийг бас бүрдүүлж өгсөн байж байгаа. Хэдийгээр сонгуулийн зардлыг бууруулах эрх зүйн орчин бүрдсэн боловч тойрог томорч байгаатай холбоотойгоор зардлын хэмжээ өмнөх сонгуулиудтай харьцуулах юм бол тойрог томорсонтой холбоотойгоор тодорхой хэмжээнд нэмэгдэж тогтоох байх. Хуульд зааснаар 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө Үндэсний аудитын байгууллага зардлын дээд хэмжээг тогтоохоор ийм зохицуулалттай байгаа.

Г.Занданишатар: 85 Баяндүүрэн дарга хариулах юм уу. Дугардоржийн Баяндүүрэн 85 гүйцээж хариулсугай.

Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн, Ажлын албаны дарга Баяндүүрэн. Сонгуулийн хууль тогтоомжид заасны дагуу тухайн мандатын тоотой тэнцүү хэмжээний саналыг сонгогч тэмдэглэж, санал тоолох төхөөрөмжид уншуулах ёстой байгаа. Үүний дагуу.

Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга Баяндүүрэн Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Г.Занданишатар: Гишүүн суудалдаа сууя. Энэ асуулт хариулт явж байхад энэ.

Д.Баяндүүрэн: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын сонгуулийн хууль тогтоомжид заасны дагуу сонгогч тухайн тойрогт байгаа мандатын тоотой тэнцүү хэмжээний саналыг тэмдэглэж, санал тоолох төхөөрөмжид уншуулах ёстой байгаа. Санал тоолох төхөөрөмжид илүү буюу дутуу тэмдэглэгдсэн санал уншигдахгүй. Яг тэнцүү тооны санал уншигдах учраас санал гээгдэх асуудал гарахгүй гэдгийг танд хэлмээр байна.

Энэ мандатын тоо нэмэгдэж байгаатай холбогдуулаад Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс сургалт сурталчилгааны ажлыг нэлээн сайн

зохион байгуулах шаардлагатай. Саналын хуудсан дээр бүх сонгогчдод санал тэмдэглэх заавар очдог байгаа. Мөн хэсгийн хороодод бас хэсгийн хороодын үүдэнд сурталчилгааны санал тэмдэглэхтэй холбоотой зааварчилга өгдөг. Мөн дээрээс нь айл өрхүүдэд “сонгогч танаа” гэсэн саналаа хэрхэн өгөх вэ, саналаа хэрхэн тэмдэглэх вэ гэсэн энэ хэдэн саналыг тэмдэглэвэл таны санал хүчинтэй байх вэ, илүү дутуу тэмдэглэвэл таны санал хүчингүй болно шүү гэсэн энэ сургалт сурталчилгааны ажлууд цаасан хэлбэрээр очдог.

Мөн дээрээс нь контент хэлбэрээр нийгмийн сүлжээ болон радио телевизээр сурталчилгааны ажлыг зохион байгуулдаг. Энэ удаа тухайн өнгөрсөн 20 оны сонгуулиар явагдаж байсан мандатын тооноос сонгогчдын санал өгөх мандатын тоо нэмэгдэж байгаа учраас энэ ажил дээр Сонгуулийн ерөнхий хорооны зүгээс онцгойлон анхаарч ажиллах ийм шаардлага байгаа гэдгийг танд хэлмээр байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг нэг явж байгаа.

Б.Пүрэвдорж: Миний хувьд, ер нь яах вэ, 2020 онд МАН гарч ирчхээд улс нэг тойрог болно гэж нэлээн хэсэг ярьсан л даа. Тэгээд үүнийх нь хүрээнд нийтдээ 20 аймгийн 60 гаруй сумаар явсан байгаа. Тэгэхдээ миний хувьд энэ бүр улс нэг тойрог болох нь маш сайн. Үгүй ядаж бүсчилсэн хөгжлийнхөө дагуу 4 бүстэй сонгуулиа хийх энэ хувилбарыг дэмжсэн бол илүү дээр байх байсан. Гэвч манай намын шийдвэр энэ бүсчилсэн тойргийн асуудлыг дэмжсэн учраас сахилга баттай гишүүнийхээ хувьд энэ асуудлыг дэмжиж байгаа. Тэгэхээр 2016, 2020 оны сонгуулийг манай эрх баригч нар сонгогчдыг худалдаж авах замаар нэлээн өндөр хувьтай гарцаасан. Өнөөдөр бас энэ томсгосон байна гэдэг бол энэ АН-ын болон бусад намын нөхдийн санхүүгийн асуудлыг л хэмжиж байгаа тийм л зүйл гэж үзэж байгаа.

Өнгөрсөн 7 жилийн хугацаанд маш их хулгайнууд гарсан. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Олон хулгай гарсан. Энэ болгоноос янз янзын байдлаар хүртсэн нөхөд өнөөдөр томсгосонд энэ бүсчилсэн тойрог дээр нэлээн бяртай үзнэ гэж бодож байх шиг байна. Энэ дээр нэг асуудал гарч ирж байгаа юм. АН нам нь нам шиг байх ёстой, дарга нь дарга шиг байх ёстой, гишүүд нь гишүүд шиг байх ёстой тийм цаг ирж байна. Энэ сонгууль бол үнэхээр хүч тэнцвэргүй сонгууль болно. Энэ сонгуульд хамгийн их эв нэгдэлтэй байсан, хамгийн их нэг зорилгын төлөө нэгдсэн тэр хүмүүс л амжилтад гарах ийм сонгууль болох юм. Энэ сонгууль бол намын бүтцийг бүрэн дүүрэн ашиглах, ажиллуулах тэр зүйлсийнхээ төлөө бүгдээрээ нэгэн зэрэг алхах ийм л сонгууль болно.

Тэгээд өнөөдрөөс эхлээд манай нам бас нэг тодорхой хугацаанд бас жоохон асуудалтай явж ирсэн. Өнөөдрөөс эхлээд бид нар нэг тийм асар том зорилгын төлөө нэгдэхээс өөр аргагүй. Тэр зүйлийнхээ төлөө зүтгэхээс өөр аргагүй. Тэр зүйлдээ зүтгэж байж энэ Монгол Улсыг өнгөрсөн 7 жил энэ ард иргэдийг ядууруулж, үнийн өсөлтийг бий болгож, янз янзын хулгай хийсэн энэ эрх баригчдаас салгах ийм цаг бидний өмнө ирж байна гэдгийг хэлье. Асуулт алга.

Г.Занданшатар: Пүрэвдорж гишүүн үг хэллээ. Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Баярсайхан: Баярлалаа. Монгол Улсыг хөгжүүлэх бүсчилсэн хөгжлийн гол зорилго нь хамтдаа хөгжихийн төлөө ийм зорилготой бөгөөд үндэс угсаагаар биш эдийн засгийн болон газар зүйн байрлалаар нь аймаг, дүүргийг бүсчилж байгаа гэж ойлгож байгаа. Хэрвээ Баян-Өлгий аймгийг үндэсний цөөнх гэж нэг тойрог болгох юм бол Монгол Улсын Үндсэн хуулийн үндэстэн угсаатныг үл ялгаварлах тэгш байдлын зарчмыг болон хүний эрхийг ноцтой зөрчсөн зөрчил

болно гэж ингэж үзэж байна. Баруун 5 аймаг баруун бүс гэж байдаг болохоос биш Баян-Өлгий гэдэг бүс байхгүй ээ. Хэрвээ баруун бүсээс Баян-Өлгий аймгийг ингээд гаргаж байгаа бол үүнийг ялгаварлан гадуурхалт гэж харж байна. Баян-Өлгий аймгийн сонгогчид бусад аймгийн сонгогчидтой яг адил Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхээ эдэлж Монгол Улсын хөгжил дэвшилд дуу хоолойгоо өргөх эрхтэй. Бусад аймгийнхаа хөгжил дэвшилд сонгох эрхээ эдлэх ёстой. Яагаад зөвхөн Баян-Өлгий аймгийн сонгогчид аймаг дотроо нэр дэвшиж байгаа хэдхэн хүмүүсээ сонгох ийм эрхийг нь хязгаарласан шийдвэр гаргах гээд байгаа юм бэ гэдэг ийм асуулт байна. Жишээлбэл Сүхбаатар аймгийн иргэд Дорнод, Хэнтий аймгаас нэр дэвшиж байгаа нэр дэвшигчийг сонгох эрхийг эдэлж байна шүү дээ. Тэгээд яагаад энэ ялгавартай ийм шийдвэр гаргах гээд байгаа юм бэ. Хэрвээ нэг аймаг ингэж ганцаараа үлдэх юм бол бүсчилсэн гэдэг концепц загвар маань алдагдах гээд байна гэж харж байна. Монгол Улсын Үндсэн хуулийн 14.2-т хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно хэмээн тунхагласан.

Тийм учраас Улсын Их Хурлын гишүүд та бүхэн Үндсэн хуулиа дээдлэн хүнийг ч ялгаварлахгүй, гадуурхахгүй байх үзэл санаандаа эзэн болж, энэхүү чухал асуудлыг олон талаас нь бодож зөв шийдвэр гаргана гэж найдаж байна. Тэгээд ажлын хэсгээс би энэ асуултыг мөн асууж байна.

2 дугаарт нь, хүн амын тоо тэнцвэргүй аймгуудыг нэгтгэснээрээ хүн ам багатай аймгууд нутгаасаа төлөөлөлгүй болно гэдэг ийм эрсдэл байгаа. Энэ 2 асуултад хариулж өгнө үү.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга ТББХ асуултад хариулъя.

Н.Энхболд: Баярсайхан гишүүний асуултад хариулъя. Тэгээд энэ асуудлыг тойрч бас олон талаар нь олон янзаар тооцоо, судалгаа хийж үзэж Үндсэн хууль бусад эрх зүйн зохицуулалтын заалтуудтай уялдуулж ярьсан. Тал талаас нь ярьсан. 2 талтай л юм билээ.

Өнөөдөр бол Баян-Өлгий аймаг 3 мандаттай байгаа. Баян-Өлгий аймаг бусад аймгуудтай нийлээд бүс болоод, энэ бол бид нар сонгуулийн тойргийн тухай л ярьж байгаа. Мөн хэрэв танилцуулга дотор уншсаныг анхаарсан бол Үндсэн хуулийн заалт Монгол Улс төрийн байгуулалтын хувьд нэгдмэл байх ёстой зарчмыг эндээ бодолцсон. Тогтоолын 4 дүгээр 3 дугаар заалтад байна уу? Энэ салангид тусдаа юу биш зөвхөн сонгуулийн тойргийн хувьд ийм. Бүсийн хөгжлийн хувьд аль бүсэд хамаарагдах ёстой тэр бүс нь өөрөө мэдээж Монгол Улсын бүрэлдэхүүн хэсэг. Тэр бүрэлдэхүүн хэсэг дотроо орж байгаа нэг бүрэлдэхүүн хэсэг нь Баян-Өлгий аймаг шүү гэдгийг нь зааж өгсөн байгаа.

Зүгээр бид нар их олон янзаар тооцоо хийж үзэхэд янз бүрийн дүн гарч байна лээ. Ер нь төлөөлөлтэй байх нь мэдээж шаардлагатай. 3, 4 аймагтай нэгтгэчихээр одоо байгаагаасаа илүү ч гарах боломжтой тооцоо гардаг. Хүмүүсийн үзэж байгаагаар. Ер нь сая Баярсайхан гишүүний хэлж байгаа шиг яг тухайн аймаг төлөөлөлгүй үлдэх ч бас ийм онолын боломжууд байгаа юм байна лээ. Тэгээд ярьж байгаад тал талаас нь ярьж байгаад 1 дүгээрт, энэ нэгдмэл улсын зарчимд нийцэж байх ёстой гэдэг юмыг хуулийнхаа тогтоолынхоо төсөл заалт, хуулийн заалтууддаа тусгаад, 2 дугаарт, ер нь ч бас сүүлийн үед бусад улс орнууд ялангуяа энэ цөөнхөө хүндэтгэж, олонх нь шийдвэр гаргадаг зарчимтай тогтолцоотой улс орнуудын улс төрийн тогтолцоо, төрийн эрх барих байгууллагуудаа сонгож байгаа арга хэлбэрт гарч байгаа хандлагуудыг ажиглаад үзэхэд ийм тодорхой хэмжээний цөөнхийн бүлэг нийгмийн

тодорхой бүлэг давхрын төлөөлөл энэ юмнуудаа сонгуулиар дамжуулж, төрийн эрх барих хууль тогтоох дээд байгууллагадаа оруулж байх нь зүйтэй гэсэн ийм 1 дүгээрт онолын, практикийн зүйлүүд хандлага ингээд энэ тал руу явж байгаа юм байна лээ. Тэгээд энэ бүхнийг бодолцож үзээд сонгуулийн тойргийн хувьд ийм, бүсийн хувьд энэ Монгол Улсын хөгжлийн бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд баруун бүсийн буюу тэр 4, 5 аймгийн нэг бүрэлдэхүүн хэсэг шүү гэдэг агуулгатайгаар тогтоолын төслөө боловсруулж оруулж өгсөн гэдгийг хэлье.

Занданшатар дарга нэмэх үү. Бид нар бас Байнгын хороон дээр ярихад нэлээн тал талын тайлбарууд сонссон. Занданшатар дарга зориуд санал гаргаж байгаад тогтоолын төсөлдөө эрх зүйн зохицуулалтыг нь зөв болгох, ойлголтоо нэгдмэл болгох энэ зүйлүүдийг заавал тусгах ёстой шүү гэж ярьж байсны дагуу Байнгын хороонд орсон төсөл дээрээ нэг заалт нэмж оруулсан байгаа гэдгийг бас хэлье.

Г.Занданшатар: Дараа нь нэгмөсөн л хариулъя. Олон гишүүн ярих байх.

Буланы Бейсен гишүүн үг хэлнэ. Байж байгаарай. 2 дахь асуултад нь, 2 дахь асуултад юу хариулах билээ, хэн хариулах вэ? Нямаагийн Энхболд дарга гүйцээгээд хариулчихъя.

Н.Энхболд: Тогтоолын төсөл асуудлыг шийдэх гарцын талаар ярихдаа бид нар 2 зүйлийг үндэс болгосон гэдгээ хэлсэн. 1 дүгээрт, Монгол Улс төрийн байгуулалтын хувьд нэгдмэл зохион байгуулалттай улс. 2 дугаарт, Монгол Улсын Их Хурлын гишүүн зөвхөн тухайн сонгогдсон тойргийн төлөөлөл биш Монгол Улсын нийт иргэдийг төлөөлдөг ийм элч хүн гэдэг 2 зарчим. Тэгээд аль 2000-аад оны эхэн үеэр Монгол Улсын Их Хурлаас баталчихсан байсан. Одоо болтол бодитой хэрэгжүүлж чадаагүй ирсэн бүсчилсэн хөгжлийн үзэл

баримтлалаа баримтлаад аймгуудыг бүсчилж хуваасан. Тэр үед гарч байсан. Үндсэндээ тэр хуваарилалтын дагуу хийгээд тойргуудаа зоосон байгаа. Баярсайхан гишүүний асууж байгаа энэ санаа зовж байгаа зүйл бол бүх л бүсүүд дээр байгаа.

Г.Занданшатар: Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Энэ “Монгол Улсын Их Хурлын 24 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэрийн төвийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаа юм. Үүнтэй холбоотой Засгийн газрын Монгол төрийн бүсчилж хөгжүүлэх асуудлыг бас дэмжиж байгаа. Цаашидаа ч энэ бүсчилж хөгжүүлэхгүй бол өнөөгийн улс орны хөгжлийн байдал, тулгамдаж байгаа асуудлыг ч бас ойлгож байна л даа. Гэхдээ Баян-Өлгий аймгийг Монгол Улс нэгдмэл 1 улс шүү дээ. Баян-Өлгий аймгийг тусад нь нэг бүс болгоод асуудал тусад нь гаргах асуудал бас энэ Үндсэн хуульд харшилчих юм биш үү? Энэ сонгуулийн юундаа яаж зохицуулсан бол? Үндсэн хуульд зааснаар бас үндэсний цөөнхийн сонгох сонгогдох эрхийг хүндэтгэж байгаа Монгол төрдөө бас баярлаж байгаа юм. Аймгийнхаа нийт ард иргэдийн өмнөөс.

Манай аймагт чинь урианхай, тува, дөрвөд олон үндэстэн ястан байгаа. Гэхдээ цаашидаа энэ Монгол Улсын хөгжилд бүсчилж хөгжүүлэх асуудал дээр Баян-Өлгий аймаг цөөхөн төлөөлөлтэй. Наад талын аймгууд чинь 12-15 төлөөлөлтэй. Бас улсын төсвийн хөрөнгө оруулалтын хуваарилалтын асуудал дээр дутагдалтай болчих юм биш биз? Яагаад гэвэл Баян-Өлгий, Ховд, Увс 3 чинь стратегийн чухал аймгууд. Цаашаагаа дундад Азитай холбох, Орос, Хятад, урагшаа Хятад, цаашаагаа дундад Азийн улсуудтай холбох Казакстаны оронтой холбох худалдаа наймаа хийх гэхэд энэ нэлээн стратегийн чухал аймаг л даа. Энэ талаар бодсон

асуудал байгаа юм болов уу? Энэ цаашидаа энэ нөгөө талаар тэр Баярсайхан гишүүний ярьдгаар бас гадуурхалт биш үү, бас үүнийг бодож үзсэн үү гээд асууж байна.

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга.

Н.Энхболд: Үүнийг олон шатад ярьсан. Намуудын удирдлагуудын хэмжээнд, Их Хурлын удирдлагын хэмжээнд, Байнгын хороо дээр ярьсан. Энэ бүгдэд нь би өөрөө бас оролцож явсан. Тэндээс гарч байгаа, тэнд гарсан ярианууд, шийдэх гэсэн гарцуудын тухай хувилбарууд, ач холбогдол тал талаас нь л ярьсан. Лав надад энд Баян-Өлгий аймгийг гадуурхаж байна гэдэг сэтгэгдэл төрөхөөр тийм сэдэв яриа огт гараагүй, Бейсен гишүүн ээ. Харин ч бид нар Монголын төрөөс Баян-Өлгий аймаг казакуудын талаар явуулж ирсэн олон 10 жилийн түүх, түүний үр дүн, цаашидын ирээдүй, энэ бүгдийг тооцож үзээд, маш энгийн үгээр хэлэхэд хамгийн наад зах нь доод талын түвшиндээ энэ аймгийн төлөөлөл байх хамгийн баталгаатай хувилбар нь юу вэ гэдэг тал дээр бас их тойруулж олон янзаар ярьсан. Мэдээж үүнийг ярихдаа Баян-Өлгий аймаг бол Монгол Улсын нэг аймгийн хувьд мэдээж ганцаараа ингээд байвал бүс нутгийн хөгжлийн асуудлаас хоцрогдох талууд байх гэдэгтэй нь уялдуулаад бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалтай нийцүүлж, энэ тогтоолын 3 дугаар заалт дээр жишээ нь баруун 5 аймаг бол эдийн засгийн хөгжлийн нэг бүс гэдгийг нь зориуд зааж өгсөн. Энэ өөрөө зүгээр санамсаргүй оруулсан заалт биш. Жишээ нь төсөв, хөгжлийн асуудал, бүсийн хөгжил, бусад бүстэй яаж уялдах вэ гэдгээ Баян-Өлгийг тусад нь биш бүхэлд нь аймгийг, бүсийг ярьж, хоорондын уялдаа нь ямар байх юм, бусад бүсүүдтэй ямар байх юм гэдгээ бүх зүйлийг нь хамт ярих ёстой шүү гэдэг санааг оруулж өгч тэр 3 дугаар заалт орсон гэж ингэж бодож байгаа.

Давтаад хэлэхэд надад тийм сэтгэгдэл төрөөгүй. Хэлэлцэн шийдвэр гаргасан Байнгын хорооны гишүүдэд тийм сэтгэгдэл төрөөгүй. Харин ч миний тэр ярианыхаа эхэнд хэлсэн энд бас 1 тэгээд бусад хөгжлийн чиг хандлага бусад улсууд цөөнх бусад юмаа яаж үзэж байна гэдгээ хаашаа яаж харж шийдэж байна гэдэг энэ бүх байдлуудыг харж үзэж байгаад ийм санал оруулж байгаа.

Би таны хэлсэнтэй санал нэг байна. Баян-Өлгий аймаг өөрөө ганц казахуудаас бүрддэг аймаг биш. Тийм ээ. Тэнд урианхай, тува, халхчууд бүгдээрээ л байгаа. Би түрүүн бас эхний тайлбартаа хэлсэн. 4, 5 том аймаг баруун бүсийн аймгууд нийлээд явахад аль аль талаар нь л үр дүн нь гарч болох ийм тооцоонууд хийгдэж байсан шүү гэдгийг. Тийм ээ. Тэгэхээр хамгийн наад зах нь одоогийн төлөөллийг нь бууруулахгүй байх үндэснээс бас үүнийг бодолцсон шүү л гэдгийг хэлэхээр байна. Тийм.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Н.Ганибал: Ер нь зүгээр манай намын хувьд бүс нутгийн хөгжлийг дэмждэг. Тэгэхдээ өнөөдөр энэ бүс нутгийнхаа бүсээр нь хуваасан энэ тойргуудын асуудал дээр нэлээн асуудал байна. Энэ ямар хүмүүс гаргачихсан юм бэ? Энэ дээр зарим нэгэн тойргууд үнэхээр бас ойлгомжгүй тойргууд байна л даа. Үнэхээр бүс нутгаар нь хөгжүүлэх гэж байгаа бол тэнд бүс нутаг байгуулах ямар шалтгаануудын асуудлууд нь, үндэслэлүүд нь тодорхойгүй ийм бүс нутгууд харагдаад байна. Тэр бүс нутгийн хөгжил яг хоорондоо уялдаж байгаа юу, үгүй юү гэдэг бас асуудалтай ийм тойргууд бас харагдаж байна. Жишээ болгоё л доо. Өнөөдөр энэ Багануур, Багахангай, Налайхыг нэг тойрог болгочихсон ингээд яваад байгаа байхгүй юу. Тэгээд 2 мандаттай гэгчихсэн. Энэ чинь Төв аймгийн нутаг дээр үйл ажиллагаа явуулдаг. Нэг нь дунджаар нэг томхон сумын хэмжээтэй.

Нөгөө 2 нь бас нэг нь хотын статустай ийм газрууд байна л даа. Одоо энэ 3 дүүрэг. Уг нь болдог энэ тойргийн систем дээрээ захын дүүрэг гэдэг энэ ойлголтоосоо салах юм бол бас зөв л харагдаад байгаа юм. Төв аймаг, Багануур, Налайх, Багахангай ингээд дөрвүүлээ нийлээд бүс нутаг болоод хөгжлийнхөө асуудлыг 1 талдаа гараад яривал энэ бүс нутгийн хөгжил мөн л дөө. Тэгэхгүй тэнд байгаа хотын статустай хөгжих гэж байгаа Дархантай аваачаад нийлүүлчихсэн. Магадгүй Сэлэнгэ, Төв аймаг 2 яах вэ газар тариалангийн бүс нутаг гэдгээрээ бас бүс нутгийн хөгжлийг ярьж болох байх. Тэгээд ингээд зарим нэгэн асуудал дээр жосоохон асуудалтай харагдаад байна. Өөрсдөдөө тааруулсан тойрог байдлаар зарим юмнууд нь яваад байгаа юм биш биз дээ гэсэн хардалт төрж байна.

Тэгээд Улаанбаатарын 2 том дүүрэг дангаараа явахад асуудал алга. Тэгээд дундын 2 дүүргийг нь нийлүүлчхээд нөгөө 2-ыг нь эргээд дангаар нь явуулаад байгаа байхгүй юу. Яахаараа Хан-Уул, Баянгол 2 нийлээд явж болохгүй байгаа юм. Ингээд энэ асуудлууд нь хэн нэгэн улс төрч нар энэ дээр бүс нутгийн зүгээр хувийн эрх ашгийн төлөө энэ тойргуудыг зураад байгаа бол энэ бүс нутгийн хөгжил гэдэг юм чинь явахгүй ээ. Тэр бүс нутгийн үзэл баримтлал гэдэг юманд та хэд бодлогын бичиг баримтыг юу болгосон л байна л даа, одоо энэ заалтуудыг нь аваад чиглэл болгож авсан байна. Харамсалтай нь ийм үзэл баримтлал байхгүй байгаа байх. Тэгэхээр энэ дээр бас хариулт авмаар байна. Энэ бүс нутгуудаа буруу зөрүү хуваарилаад байх шиг байх юм. Бүс нутаг үнэхээр хөгжиж байгаа бол ямар нэгэн эдийн засгийн, нэг эсвэл газар зүйн, нэг эсвэл тэр давуу тэр иргэдийн сонирхол гээд ингээд олон асуудлууд тэр бүс нутгийг бусдаас нь ялгагдах ёстой л доо. Ингэж байж энэ бүс нутгууд байгуулагдах ёстой гэж бодож байна. Энэ дээр хариулт авъя.

Г.Занданиатар: Нямаагийн Энхболд дарга хариулна.

Н.Энхболд: Юуны өмнө үүнийг би ганцаараа юм уу, эс үгүй бол Төрийн байгуулалтын байнгын хороо ганцаараа шийдчихсэн зүйл биш шүү гэдгийг дахиад давтаад хэлье. Төрийн байгуулалтын байнгын хорооноос энэ саналыг гаргаж хороогоороо хэлэлцүүлэхдээ урьд өмнө гарч ирсэн шийдвэрүүд, түүхэн үйл явцад бүрэлдэж бий болсон засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжүүдийн статусын асуудал. Тэгээд намуудын хэмжээнд, удирдлагуудынх нь хэмжээнд бас санал солилцоод, шийдвэр гаргадаг байгууллагууд нь дэмжээд, орж ирсэн ийм санаануудыг бид нар нэгтгээд тогтоолын төсөл бэлдэж, Байнгын хороогоор хэлэлцүүлсэн гэдгээ хэлэх байна.

2 дугаарт, жишээ нь Төв аймаг яах вэ, тэр жижиг хотын захын дүүргүүд Төв аймгийн нутаг дэвсгэр дээр байдаг гэж байна. Яагаад тэрийг жишээ нь Төв аймагтаа нэгтгэж болдоггүй юм бэ гэж. Хуульд байж байгаа засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжээрээ гэдэг ойлголтоороо нэг нь аймгийн, нөгөөдөх нь нийслэлд багтдаг ийм нэгжүүд, тийм ээ. Тэгэхээр хуульд байгаа заалтаараа ч тэр, хуулийн агуулгаараа ч тэр, аймгийн юмыг нийслэлийн юмтай нэгтгээд бүс байгуулах ийм боломж байхгүй, тийм гэдгийг хэлье. Тэр нийслэлийн алслагдсан дүүргүүд. Тэгээд Төв аймгийн нутаг дээр байрлачихсан, статус нь тодорхой болчихсон энэ үйл явцууд нь бид нараас мэдээж тодорхой хэмжээнд хамаарч ирсэн л байх л даа. Гэхдээ урьд нь нэгэнт тогтчихсон ийм байгаа учраас үүнийг хотынхоо нэг хэсэг гэж үзэж хөгжүүлэхээс өөр юу тооцохоос өөр тойргоо байгуулахаас өөр хуулийн гарц байгаагүй.

3 алслагдсан тойргийнхоо асуудлын хөгжлийн талаарх бас ийм шаардлага байгааг, тэгээд хөгжих ийм боломж байгаа талаар тухайлбал тэр

тойргоос сонгогдсон гишүүд маш тодорхой үндэслэлтэй тийм тайлбарууд хийж байна лээ л гэдгийг хэлэх байна. Шадар сайд Амарсайхан байна. Та заримдаа хүний нэр хэлэх гээд байх шиг байна. Тэр тухайн бүсээс сонгогдсон хүмүүсийн хувийн ашиг сонирхол орчхоогүй байх аа даа гэж. Би үгүй болов уу гэж бодож байна. Тэр бас нөхцөл байдлаа сайн мэддэг хүмүүс. Сонгогдсон тойргийн хүмүүс нь энэ дээр саналаа хэлж, ингэж тайлбарлаж байсан нь Байнгын хорооны гишүүд тогтоолын төслийг дэмжихэд бас үндэслэл болсон болов уу гэж ингэж бодож байна.

С.Одонтуяа: Наянтайн Ганибал гишүүн тодруулга асуулт.

Н.Ганибал: Эндээс бас эргээд гараад харахад түрүүн Бейсен гишүүн тодорхой яриад байна л даа. Баян-Өлгий аймаг 3 гишүүнтэй болчихвол тэр аймаг улсын төсөв тэр хөрөнгө оруулалтын асуудлууд дээр тодорхой хэмжээнд орхигдоно. Зарим аймгууд нь бүсчлээд арваараа нийлж байгаад төсөв мөнгийг илүү тавиулах, бүс нутгийн хөгжлөө илүү хөгжүүлэх энэ асуудал дээрээ анхаарчихна. Энэ захын 3 дүүрэг чинь хоёрхон гишүүнтэй. Тэгээд л эргээд хамгийн хоцрогдсон, хамгийн орхигдсон 3 дүүрэг болоод л үлдэнэ. Төв аймгийн та мэднэ дээ, Багануур дээр тэр Баяндэлгэр, Эрдэнэ сум, Мөнгөнморьт гээд тэр хавийн хүмүүс тэндээс үйлчилгээ авдаг юм шүү дээ. Тэр Багануурын ер нь яг төрийн үйлчилгээний бараг сургууль, цэцэрлэг, ихэнх нь Төв аймгийн иргэд үйлчлүүлдэг байхгүй юу. Тэгээд эд нар чинь 1 нэгдмэл сонирхолтой байна шүү дээ. Үүнийг ингээд нийлүүлээд ойлгож чадахгүй бол бид нар бүс нутаг ярьж яах юм бэ? Бүс нутаг гэдэг чинь нэгдмэл сонирхолтой энэ хүн ... /минут дуусав/

С.Одонтуяа: Тодруулгад хэн, Энхболд дарга хариулах уу? Нямаагийн Энхболд дарга хариулъя.

Н.Энхболд: 1 дүгээрт, одоогийн хүчин төгөлдөр байгаа статусынх нь

талаар би түрүүн үгээ хэлчихсэн. Тэгээд би мэднэ л дээ. Манай Төв аймгийн Мөнгөнморьт, Баяндэлгэр, ойрын сумд гэр бүлийнх нь хуваагдаад 2 газар бүртгэгдчихсэн, тийм. Нэг хэсэг нь Багануурт байж байдаг, нөгөө хэсэг нь сум, сумандаа байж байдаг ийм зүйлүүд бий. Тэгэхээр энэ 2 тэгэхдээ бас тусдаа асуудал юм. 1 дүгээрт, тэр иргэдийн оршин сууж байгаа газраа бүртгэлтэй байгаа эсэх нь өөрөө өнөөдрийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарь, статусыг өөрчлөх боломжгүй учраас тогтоолын төсөл дээр ингэж явж байгаагүй. Ер нь цаашидаа ингээд энэ бүсчилж хөгжүүлж байгаа, бүсчилж тойрог болгож байгаагийн бас нэг хэтийн юу гэдэг юм бэ дээ төлөв нь юу вэ гэхээр үүнийг дагаад хэрэв бид нар бодлогоо зөв явуулж чадвал яваандаа ... /минут дуусав/

С.Одонтуяа: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн байхгүй байна. Жамбын Батсуурь гишүүн асуултаа асууна. Асуулт, үг нэг байгаа.

Ж.Батсуурь: 24 оны ээлжит сонгуулийн тойргийн хуваарилалт орж ирж байна. Өчигдөр Байнгын хороон дээр олон зүйлийг асууж мэдсэн, бас олон ч зүйлийн санааг илэрхийлсэн. Ер нь зүгээр шинэ Үндсэн хуулиар энэ үзэл санааг оруулах гэж ирж байгаа гэж хэлж байгаа. Манай намын дарга тойрог томсохыг л дэмжсэн санамж бичигт орсон болохоос биш тойрог дотор яаж дугуйлахыг тохироогүй гэдгийг та бүхэн мэдэж байгаа. Тийм, тойргийн хуваарилалт бол шог байгаа. Үнэхээр шог. Ингээд харахад энд наймаа явагдаж байна. Хан-Уул дүүргийг шууд Хүн намд Доржхандад өгч байна. Багахангайг Шадар сайддаа өгч байна. Энэ өөрөө 10 мандаттай тойрогт 10 хүн нэр дэвшээд 5, 5 минут үг хэлэхэд 50 минут болно. 2 мандаттай тойрог яах вэ нэг нь 25 минут үг хэлэх нь байна шүү дээ. Зүгээр энгийн логикоор ингэж тойргийг зарж байна.

Дээр нь энэ тойрог томсоно гэдэг өөрөө энэ өнгөрсөн хугацааны нүүрсний, ЖДҮ-ийн, Хөгжлийн банкны бүх хулгай луйварт орчихсон, мөнгөжсөн олигархуудын ийм том зодоон болох нь гэж ингэж харагдаж байгаа юм. Яагаад вэ гэхээр, 14 хоногт нэг намаас 10 хүн дэвшигч, 10 мандат дээр 10 намаас 100 хүн 14 хоногт багтааж, өөрийнхөө бодлого шийдвэрийг намынхаа мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх боломж байхгүй ээ. Үүнээс юу гарч ирэх вэ гэхээр хор хохирол нь юу вэ гэхээр эрчүүд бид нар тойроод тойроод бардаггүй юмыг одоо энэ 4, 5 аймгийг дамжаад бүсгүйчүүд маань явж дийлэх үү. Тэрийг дагасан санхүүг гаргаж чадах уу. Нөгөө эрдэмтэн докторууд маань тэгж явж чадах уу. Тэрийг дагасан мөнгө санхүүг гаргаж чадах уу. Нөгөө залуу үе гэж яриад байдаг, нөгөө шинэ үеийг бий болгоно гээд байдаг энэ асуудлууд өнөөдөр бүрэн орхигдоно оо.

Би мэргэн хүн шиг хэлье. Үндсэн хуулийн өөрчлөлтийг ярьж байхад парламентад суудалгүй бүх намууд орж ирнэ, та нар ёстой янзын гоё болно гээд шилний цаанаас чихэр долоолгосон. Нөгөөдүүл нь та нар шилний цаанаас долоолгож байна шүү гэсэн чинь долоосоор байж байгаад хулхидуулсан. Одоо ийм том тойрогт парламентад суудалгүй намуудаас нэг ч цухуйхгүй, бие даагч нар нэг ч цухуйхгүй. Залуучууд, эмэгтэйчүүд ёстой яаж ч үзээд тамираа тасалсан ийм л сонгууль болно. Хувь хүний бие ч дийлэхгүй шүү дээ, энэ чинь. 14 хоногт Монголын энэ том нутаг дэвсгэрт улс орнуудыг нийлүүлсэн юм шиг ийм том нутаг дэвсгэрт 100 хүн тойрч, тэр ард түмнийг залхаана гэж байх уу. Тэгэхээр энэ нөхцөл байдлуудыг тойрог томсохыг нь хэдийгээр дэмжиж байгаа ч гэсэн, тойрог дотор зурж байгаа энэ хуваарилалтууд үнэхээр шог байгаа. Тэгэхээр энэ нөхцөл байдлыг засаач, засах боломж нь байна. Жишээ нь Улаанбаатар хотыг заавал ингэж 6 мандаттай болгож яах гэж байгаа юм. Хан-Уул, Багахангай, Багануураа нийлүүлээч дээ. Баянгол яахаараа

дангаараа байж байх ёстой юм, нийлүүлээч дээ. Ядаж 2 хувааж чаддаггүй юм аа гэхэд нэг 3 хуваачих. 3 хувааж чаддаггүй юм бол 4 хуваачих. Тэгэхгүй бол зүгээр хүнд зориулсан тойрог зурж байсан түүх бий. Хуучин Увс аймагт хонины арьс шиг, хуучин Дорнод аймагт Базарсадын гутал гэж тойрог байдаг. Энэ шигээ та нар тойргийг зурж байна шүү дээ.

Ер нь эрх баригч нар өнгөрсөн 8 удаагийн сонгуульд өөрсдөө дандаа ялах энэ тойргоо зурж ялж ирж байсан. Тэгэхээр би асуулт асуухгүй, асуулт болгоныг ард түмний толгойг угааж, бүх бүтэхгүй юмнуудаар ... /минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Санал уу. Санал.

Цэвэгдоржийн Туваан гишүүн асуултаа асууж, үг хэлнэ.

Ц.Туваан: Тойргийн асуудал яригдаж байна. Хуулиараа 2 сарын 1-ний дотор гэсэн. Тэгээд он дотроо ингээд яригдаж байгаа юм байна. Энэ бол улс орныхоо том эрх ашгийг харах юм бол нөгөө жалга довын үзлээсээ салах гэдэг утгаараа зөв гэж ингэж харж байгаа юм. Тийм, манайхан үүнийг урьд нь ч гэсэн АН-ынхан, АН-аас нэр дэвшиж сонгогдож гарч байсан Ерөнхийлөгчид хүртэл үүнийг хуучин, 4 аймгийнхаа дагавар байдлаар хойноос урагш байдлаар ингээд бүсчилж хуваая гэдэг ийм саналууд ч гэсэн явж байсан. Тэгээд өнөөдөр бас ингээд тойргийн хуваарилалт дээр биелэл болоод явах гэж байх шиг байна Тэгэхээр энэ дээр хэрвээ бүсчилсэн хөгжлийн бодлого ярих гэж байгаа бол энэ бүсүүдийг чинь дугаарлана гэхээр нэг сонин санагдаад байна. 1 дүгээр бүс, 2 дугаар бүс гээд. Ингээд. Тэгэхээр энэ бодлогын хуваарилалт юм бол бүсүүддээ нэр өгье. Одоо энэ чинь бүсүүд дээр манайх чинь хангайн бүс, говийн бүс, зүүн бүс гээд ингээд ядаж зүг чигээр нь ингээд нэрлэдэг шүү дээ. Тэгээд энэ дээр чинь Төв аймаг, Дархан-Уул аймаг, Сэлэнгэ

аймаг ингээд нэг тойрог бүс болох юм байна. Тэгэхээр энэ дээр юу гэдэг юм. Төвийн бүс ч гэдэг юм уу, эс үгүй бол онцлогтой нь энэ Хөдөө аж ахуйн бүс гэдэг юм уу, иймэрхүү нэр өгч болохгүй юу? Энэ дээр нэг хариулт авмаар байна.

2 дугаарх нь, энэ Улсын Их Хурлын гишүүн гэдэг бол миний хувьд ойлголтоор энэ төр ард түмний хоорондын гүүр болж ажилладаг, ард түмний элч төлөөлөгч болж ажилладаг ийм хүн гэж ингэж ойлгодог. Тэгэхээр би ч гэсэн өөрөө тэгж ажиллахыг хичээдэг. Тэгэхээр энэ дээр нэг аймаг, Төв аймаг, жишээлбэл 27 сумтай. Энд хүрч ажиллахад бас маш их цаг хугацаа. Улаанбаатар хотоос 5 тийшээ 5 засмал замаар гарч явж очдог. Тэгэхээр тэгж ард иргэдтэй уулзах юм. Дээрээс нь энэ 2 том аймагтай Дархан-Уул, Сэлэнгэ аймагтай нийлэхээр энэ яг иргэдтэйгээ очиж уулзах, тэд нарын санаа бодлыг сонсох, тэдний хүсэлтийг шийдвэрлүүлэх, асуудлыг төрдөө хүргэнэ гэдэг асуудал дахиад л 3 дахин хүндэрч байгаа. Тэгэхээр энэ төр, ард түмний элч төлөөллөө хийх, үүргээ гүйцэтгэх энэ ажил бас концентрац нь жоохон сулраад явчих нь гэсэн ийм бодол байгаа.

Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль яригдаж байхад би энэ сурталчилгааны хугацааг битгий буулгаач, 18 хоногийг битгий буулгаач. Ядаж тэр нэг 22 хоног энэ тэрээр нь байлгаач гэдэг ийм болгооч гэдэг саналууд хэлж байсан. Бас л энэ томсгосон, бүсчилсэн тойрог ингээд явахаар 14 хоног дотор энэ 3 аймгийг тойрох ямар ч боломж байхгүй. Зарим яах юм, үлдээсэн хүмүүсийг нь тэгээд юу гэх юм, би очсон шүү намайг төлөөлж тэр очиж байгаа шүү гэж хэлэх юм уу. Бид нарт вертолёттоор нисдэг тэргээр нисээд яваад байх боломж байхгүй. Эдийн засгийн тийм боломж байхгүй. Мөнгөтэй, төгрөгтэй эрх баригчдад боломж байдаг л юм байгаа биз. Тэгэхээр энэ 14 хоногт 3 аймгийн энэ олон сумыг тойрох боломжгүй, үүнийг яаж харсан юм бэ? Сурталчилгаа дээр юу гэж

бодож байна? Бид нар төлөөлөх гэж байгаа ард иргэдтэйгээ уулзаж үгийг нь сонсмоор байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр нэг ажлын хэсэг нэг хариулт өгөөдхөөч.

Тэгээд ер нь энэ бүсчилсэн хөгжлийн бодлогыг дэмжиж байгаа. Манай Төв аймаг, Дархан-Уул, Сэлэнгэ бол хөдөө аж ахуйн гол бүс нутаг, газар тариалангийн гол бүс нутаг, эрчимжсэн фермерийн аж ахуйн гол бүс нутаг болно. Хөгжлөөрөө бусад бүсүүдээ манлайлна. Монголчуудын хоолтой байх уу, хоолгүй байх уу гэдгийг гурилтай байх уу, ногоотой байх уу гэдгийг шийдэх ийм бүс болно оо л гэж ингэж харж байгаа.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Нямаагийн Энхболд дарга хариулъя.

Н.Энхболд: Би чинь бүх юмыг мэддэг хүн шиг л ингээд хариулаад байж болж байна уу, үгүй юу. Байнгын хороон дээр яригдсан зүйлүүдээ л, санал, дүгнэлтээ танилцуулах ёстой л доо. Ер нь зүгээр би ингэж бодож байна. Хэрэв бид нар Үндсэн хуулиараа, Сонгуулийн хуулиараа, намын хуулиараа улс орны хөгжлийг бүхэлд нь томоор нь хардаг ийм Их Хуралтай болох сонгууль явуулна гэж эхнээсээ ярьж тогтсон юм бол дараа дараагийн логик алхмууд нь ямар байх вэ гэдгийг бас тухай тухайн үедээ хүн болгон бодсон, эргэцүүлсэн. Тэгээд шийдвэрээ гаргаад УИХ тэр өөрчлөлтүүдийг хийсэн гэж бодож ойлгож байгаа. Түүнийхээ дагуу энэ томсгосон тойргийн асуудлыг оруулж ирж байна.

Түрүүн бас нэг хариулахдаа хэлсэн. Ер нь Их Хурлын гишүүн бол зөвхөн тухайн тойргийн юм уу гишүүн биш бүх ард түмний элч гэдэг утгаараа аливаа асуудалд хандаж байх нь цаашидаа яг ялангуяа ийм томсгосон тойргоор сонгууль явагдаж байгаа үед улам их ач холбогдолтой ийм асуудал болох байх аа гэж ингэж ярьж байна.

Сонгуульд яах вэ дээ, бүгдээрээ адилхан нөхцөлд л орно, бүгд л адилхан 14, 5 хоногтоо багтаагаад л сурталчилгаагаа хийнэ. Тэгэхээр яг хуучин шигээ бодоод ингээд сонгуулийнхаа ажлыг, сурталчилгааны ажлыг зохион байгуулна гэвэл үнэхээр төвөгтэй. Түүнтэй харьцуулахад хэцүү зүйлүүд гарч ирнэ л дээ. Тэгэхээр яаж сонгуулиа хийх вэ, яаж сурталчилгаагаа хийх вэ, юуг илүү ярих вэ гэдэг асуудал их чухал болох болов уу гэж би зүгээр хувь хүний боддог. Жишээ нь би ийм хүн шүү гэж ярихаасаа илүү нөгөө дэвшүүлсэн намынхаа бид нар ийм бодлого дэвшүүлж байгаа юм. Тэрийг, тэр бодлогыг хэрэгжүүлэхэд би илүү намайг илүү хувь нэмрээ оруулж чадна гэж үзээд намайг дэвшүүлсэн шүү гэдгийг сурталчилгааны шинэ аргууд хэрэглээд ингээд явах л хэрэгтэй болох байх гэж бодож байна.

Юуны хувьд нэрийн хувьд ийм юм. Туваан гишүүн ээ, 2001 онд гарсан нөгөө бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын тухай одоо болтол хүчин төгөлдөр байж байгаа баримт шүү дээ. Түүн дотор Монгол Улсыг баруун, хангайн, төвийн, зүүн гээд ингээд 4 хуваачихсан байж байгаа. Дотор нь Улаанбаатар бас тусдаа байж байгаа. Тэгээд бид нар энэ дотроо өнөөдөр оруулж байгаа тогтоол дотор жишээ нь энэ удаа тогтоож байгаа сонгуулийн аль тойрог тэр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нэр нь заагдсан баруун, төв, хангай, зүүн бүсэд багтаж байгаа юм бэ гэдгийг нь заачихсан юм. Үүнийг Байнгын хороон дээр ярьж байж өчигдөр нэмэлт заалт болгож оруулсан. Тэгэхээр зүгээр тусгайлсан нэр өгөх асуудал бол үгүй ээ, яах вэ байж болно л доо. Одоо бид нар нөгөө өмнө нь баталчихсан байсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан нэр дотроо л тойргууд нь аль нь алиндаа багтаж явах юм гэдгийг нь заачихсан байгаа юм. Жишээ нь төвийн аймгуудын бүсийг юу гэж нэрлэх юм. Тийм тусгайлсан нэр маягийн юм өгвөл би яваандаа болохгүй юм байхгүй л гэж бодож байна.

С.Одонтуяа: Туваан гишүүн тодруулж асууна.

Ц.Туваан: Тийм нэр өгөх, өгчихвөл уг нь бас хөдөөгийн нэг их олон биш тийм ээ, 4 биш ч гэсэн нэг 7 гэдэг чинь баруун нь баруундаа, зүүн нь зүүндээ л байна. Тэгэхээр энэ төвийн говийнх нь говьдоо байна. Тэгэхээр энэ төвийн бүс, хангайн бүсийнхээ асуудлыг л нэг нэр өгөөд явчихвал их зохистой юм даа. Тэд дүгээр бүс гэж ярихаар хүн ойлгохгүй. Монголчууд чинь нэг тийм зүг чигийн баримжаатай ийм улсууд дээр бол. Тэгэхээр энэ асуудал нэгэнт хэлэлцэгдэж байгаа учраас тойрог байгуулах асуудал хэлэлцэгдэж байгаа учраас би энэ дээр Энхболд даргад бас ойлгоод тодорхой санал оруулаад нэршүүлээд явчихъя. Энэ цаашидаа хөгжилдөө ч хэрэгтэй. Жишээлбэл Төв аймаг, Дархан, Сэлэнгэ орсон энэ бүсийг төвийн юм уу, эс үгүй бол хөдөө аж ахуйн юм уу ингээд нэг тийм нэртэй байвал цаашидаа бодлого ярихад их амар болно. Тэгэхээр үүнийг та нэг анхаараад оруулаад шийдээд явчихвал бусад олон газар нь тодорхой юм байна.

С.Одонтуяа: Микрофонд хариулчихъя. Нямаагийн Энхболд дарга.

Н.Энхболд: Юу яая. Өнөөдөр бид нар ерөнхийдөө тойргоо тогтоох тухай асуудлаа юу, яаж байгаа. Саяын Туваан гишүүний яриад байгаа асуудлыг дараа нь жишээ нь сонгууль явсны дараа аль бүсээс ямархуу гишүүд сонгогдов гээд ойлгомжтой болоод ирэх үед нь эргээд үүнийг аваад хэлэлцэхэд би болохгүй гэх зүйлгүй л гэж бодож байна. Илүү ойлгомжтой болгохын тулд.

С.Одонтуяа: Чимэдийн Хүрэлбаатар гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ч.Хүрэлбаатар: Өнөөдөр бид нар энэ Улсын Их Хурлын сонгуулийн тойрог, мандатын асуудлыг ярилцаж байна. Тэгээд Улсын Их Хурлын сонгууль ямар тогтолцоогоор, ямар тойргоор явахаас Монголын улс төр хамаардаг. Монголын

явагдаж байгаа улс төрөөсөө хамаараад нийгмийн, эдийн засгийн бүхий л амьдрал өрнөж байгаа. 76 жижиг тойрогтой явбал илүү одоо жижиг жижиг тийм тасархай байдлаар асуудлууд яригддаг. Улс төр нь тус тусдаа өөр өөрийн гэсэн онцлогтой 76 өнгөтэй ийм улс төр яригдаж явагддаг. Энэ нь эргээд Монголын нийгэмд ямар эрсдэл учруулаад байна вэ гэвэл Монгол Улс улам л хоорондоо хуваагдал нь нэмэгддэг, улам л нэг байр сууринаас нөгөө хэт туйлширсан байр суурь луу шилждэг ийм эрсдэлүүд үүсээд байгаа юм. Тэгэхээр энэ маань цаашидаа Монгол Улсын ирээдүйн хөгжил дэвшилд ер нь эерэг зүйл үү, буруу зүйл үү л гэдгийг бид нар бодох учиртай юм. Тэгээд өнөөдөр УИХ дахь суудалтай намууд байр сууриа илэрхийлчихсэн. Бүсчилсэн тойргоор сонгуулийг явуулъя гэдэг ийм санал намууд гаргачихсан байна.

Манай Улсын Их Хурлын гишүүд бараг дийлэнх нь дэмжиж байна. Би ийм тохиолдлыг урьд өмнө харж байгаагүй. 2016 он гэхэд чинь л жижиг 76-аар явах уу, томсгосон 26 тойргоор явах уу гэхэд л бараг 50, 50 хувиар хоорондоо маргалдаж байсан. Гэтэл одоо дийлэнх нь бүгдээрээ энэ бүсчилсэн тойргоор сонгуулиа явуулъя гэдэг дээр санал нэгдчихсэн байгаа дээр үнэхээр бас сайхан санагдаж байна гэдгийг 1 дүгээрт нь хэлмээр байна.

Улс төр нь өөрөө тогтвортой байж байж Монгол Улс хөгжинө. Тэгэхээр энэ томсгосон тогтолцоогоор явахад улс төрийн нэлээд тогтвортой байдал үүсэх болов уу гэж бодож байгаа юм. Гэв гэнэт унтаж сэрээд гэнэт гэнэтийн цочмог цочмог санаанууд гаргаж бужигнадаг ийм зүйлүүд нь энэ Монголын төрд багасна аа гэж үзэж байна. Тэгэхээр Монгол Улсын улс төрийн байдал нь тогтворжоод эхэлбэл эдийн засгийн бодлого нь ч тэр, нийгмийн салбаруудад гарах шийдвэрүүд нь ч гэсэн ултай, даацтай ийм гарах болов уу гэсэн ийм хүлээлт байгаа. Тийм учраас энэ их

зөв тогтолцоо руугаа явж байна гэдгийг би хэлмээр байна.

Дараагийн нэг асуулт байна. Улаанбаатар хот. Улаанбаатар хотын ирээдүйн хөгжил дэвшил бол энэ Улаанбаатар хотынхоо төлөвлөлттэй, хөгжлийн бодлоготой их хамаарч байх юм. Тэгэхээр дахиад нөгөө яг хуучин хэвээр нь ингээд жижиг, жижгээр хуваачихсан байна л даа. Би бол дотроо Улаанбаатар хотыг баруун бүс, Улаанбаатар хотын баруун, зүүн, хойд, өмнөд гээд л 4 хуваачихмаар санагдаад байгаа юм. Ингэж чадах юм бол Улаанбаатар хотын бүсүүд дээрээ эрчим хүчний хангамж, дулааны хангамж энэ асуудлууд нь шийдэгдэнэ. Үүнийгээ дагаад утааны асуудлууд шийдвэрлэгдэнэ. Метро, тойрог зам гээд энэ Улаанбаатар хотыг томоор нь харсан хөгжлийн асуудлууд өнөөдрийн ард иргэдийн энэ бухимдлын эх үүсвэр болоод байгаа энэ түгжрэл, утаа, ядуурал гэдэг энэ асуудлуудыг бүгдийг нь цогцоор бодлогын хувьд нэг болгож байгаад шийдэх ийм боломжтой учраас Улаанбаатар хотоо зүгээр 4 хуваагаад өмнөд, хойд, баруун, зүүн гээд ингээд 4 хуваагаад явчихвал болох уу гэдэг ийм зүйл байна. Тэгэх юм бол бас энэ Монгол Улс Улаанбаатар хот олон асуудал шийдэгдэх болов уу гэж бодож байна. Ийм учраас асууя.

С.Одонтуяа: Сүүлийн асуултад хэн Энхболд дарга хариулах уу? Маш чухал асуулт шүү. Нийслэлийн хөгжлийн талаар.

Н.Энхболд: Энэ томсгосон тойрог болгоод аль тойрогт ямар засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж багтах нь зүйтэй вэ гэдэг асуудлаар өнөөдөр тухай тухайн тойргоосоо сонгогдсон байгаа гишүүд түүний дотор Улаанбаатар хотоос сонгогдсон гишүүдтэй бүгдээр нь санал солилцсон юм байна лээ. Хамгийн сүүлд 17, 8 хүн жишээ нь Улаанбаатар хотод сонгогдсон 17, 8 хүн хамтарч яриад тэгээд өнөөдрийн байдлаар гаргачихсан

байгаа шийдвэр нь энэ. Ер нь урьд нь дүүргүүд дотроо хуваагдчихсан тойргуудтай байсныг энэ удаагийнхаар дүүрэг дүүргээ бүтнээр нь нэг болгоод оруулчхаж байгаа юм. Өөрөөр хэлбэл дахиад жоохон жоохон томорч байна гэсэн үг.

Дээр нь жишээ нь Сүхбаатар, Чингэлтэй 2-ыг ингээд нийлүүлчихсэн. Төв тэр хойд талын хэсэг ингээд. Гэх мэтчилэн энэ бүсчилсэн хөгжлийн гэдэг юм уу тойргийг томсгохдоо томсгох агуулгатай эхний алхмууд Улаанбаатарын хувьд хийгдчихсэн гэж ойлгож байгаа.

Тэгээд дахиад хэлэхэд, нөгөө хотоос сонгогдсон гишүүд маань үүнийг өнөөдрийн байдлаар эхний алхам болгоод ингээд явна гэж ойлголцоод тэр саналынх нь үндсэн дээр Байнгын хорооны тогтоолын төсөл боловсруулагдсан гэдгийг хэлье.

Ер нь хотын хөгжлийн асуудлаар бүсчлэх үү, тэлэх үү, дагавартай байх уу. Энэ зүйлүүдийг сүүлийн нэлээн олон жил ярьж байгаа. Тэгээд алхам алхмаар зөв гэж үзвэл саяын таны хэлсэн шиг тийм хуваариуд хийгдэж болох байлгүй дээ л гэж бодож байна.

С.Одонтуяа: Хүрэлбаатар гишүүн тодруулж асууя.

Ч.Хүрэлбаатар: Ингээд хөдөө гэхэд чинь өвөлжилт хүндэрч байна гэхэд тэрийг яах аргагүй бид нар энэ бүсчилсэн байдлаар л асуудал яригдаж байж шийдэгдэнэ шүү дээ. Зарим аймаг нь хүнд байна. Зарим аймаг нь өвс тэжээл муу байна гээд хоорондоо шилжих гээд энэ бүсчилсэн асуудал үнэхээр чухал.

Харин Улаанбаатар хот дээр энэ тэр түгжрэл, утаа зэрэг энэ асуудлууд Улаанбаатар хотын төлөвлөлт томоор нь асуудлуудыг шийдвэрлэж байж л энэ шийдэгдэнэ. Улаанбаатар хотын юу гэдэг юм, энэ ганцхан СБД нь учиргүй сайн хөгжөөд бусад нь орхигдоод явлаа

гээд энэ асуудал шийдэгдэхгүй шүү дээ. Тийм учраас уг нь Улаанбаатар хотоо ингээд бүсчлээд зүүн ингээд зүг чигээр нь л авчихсан л даа. Өмнөд, зүүн, баруун, хойд гээд авчхаад тэгээд хөгжлийн бодлогоо түүн дээрээ ярих замаар явбал энэ илүү шийдлүүд нь их хурдан гарч их зөв шийдлүүд гарна. Одоо асуудлаа бүгд мэддэг, шийдэл нь гарч өгөхгүй байгаа учраас л үүнийг дахиж ... /минут дуусав/

С.Одонтуяа: Ширнэнбаньдын Адьшаа гишүүн асуулт асууна.

Ш.Адьяа: Өнөөдөр 2024 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн асуудлыг УИХ хэлэлцэж байна. Монгол Улсын хөгжлийн, улс төрийн хөгжлийн 30 жилийн үйл түүхэнд дүгнэлт хийж, Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан. Пропорциональ буюу мажоритар системээр Монгол Улсад сонгуулийг зохион байгуулна гэж бид Үндсэн хуульд өөрчлөлт оруулсан. Монгол Улсын, пропорционалийн тухайд Монгол Улсын бүх иргэд гадаадад байгаа иргэд пропорциональд оролцох ийм хууль, эрх зүйг бид баталж өгсөн. Монгол Улс уг нь утгаараа яривал нэг тойрог байгаа. Бид өнөөдөр би гарах ёстой, манай нам гарах ёстой гэдэг ийм бодлоор асуудалд хандаж болмооргүй байна. Өнөөдөр тэр жалга довын үзэл, жижиг тойргийн зовлонг Монголын ард түмэн 30 жилийн хугацаанд үзсэн. Бид хаашаа явж байгаа энэ тогтолцоо чинь үр дүнтэй юм уу гэдэг дээр дүгнэлт хэлэхэд үнэхээр хүнд байгаа.

Бид Монгол Улсыг энэ бүсчилсэн хөгжлөөр хөгжүүлэх энэ асуудлыг өнөөдөр шийдэх ёстой. Миний тойрог, миний сум, миний аймаг гэдэгт хөрөнгө оруулалт ч гэдэг юм уу ийм жижиг юм ярьж бид улс орныхоо ирээдүйн хөгжлийн асуудлыг яриааргүй байна. Монгол Улсын Их Хуралд сонгогдох нам, эвсэл, тойргийн гишүүд бол Монголын ард түмний дийлэнх олонхын төлөөлөл болдог. Бүсчилсэн энэ нутаг дэвсгэрээс сонгогдож байгаа энэ хүн бол жинхэнэ

ард түмний төлөөлөл байх болно. Энэ бүсийн, тойргийн энэ зарчмыг бид шийдэж байж, төрийн нэр хүнд, ард түмэн төрд итгэх итгэл, нийт дийлэнхийн олонхын саналыг авч Монголын ард түмний хөгжил дэвшлийн төлөө хууль, эрх зүйн шинэчлэлийн төлөө хийх ийм эрх зүйн орчин бүрдэнэ л гэж ойлгож байгаа.

Парламентад суудалтай улс төрийн намууд зөвшилцөж, Монгол Улсын хөгжлийн төлөө манай нам ялах нь чухал биш танай нам ялах нь чухал биш Монгол Улсын хөгжил, төрийн тогтолцоонд шинэчлэл хийе л гэж бид энэ Үндсэн хуулийг өөрчлөлт хийсэн. Энэ Үндсэн хуулийн үзэл баримтлалын хүрээнд энэ сонгуулийн тойргийн асуудлыг өнөөдөр Монгол Улсын Их Хуралд оруулж ирсэн. Энэ хуулийн тогтоолын төслийг батлахыг би дэмжиж байгаа юм. Энэ Монгол Улсын язгуур эрх ашиг, Монголын төрд олонхын дэмжлэг авсан төрд сонгогдох хүнийг сонгох ийм бас нэг хариуцлагатай ийм зүйл гэж ойлгож байгаа.

Нөгөө талаасаа нам, эвслүүд, жижиг намуудыг сонгох боломжоор хангахгүй байна гэдэг энэ дээр би өөр бодолтой байгаа. Үнэхээр олон түмэнд танигдаж, нийт олонхын санал авах ... /минут дуусав/

С.Одонтуяа: Адьяа гишүүн дэмжиж үг хэллээ.

Содномын Чинзориг гишүүн алга байна. Сандагийн Бямбацогт гишүүн алга байна. Раднаасэд гишүүн алга байна. Дамдинням гишүүн асууя. Гонгорын Дамдинням гишүүн асуултаа асууя.

Г.Дамдинням: Энэ тойрог орж ирж байна. Тойрог, мандатын асуудал орж ирж байна. Зүгээр энэ Улаанбаатарын тойргуудыг л их гайхаад байгаа юм даа. Улаанбаатарын тойргууд дээр бүсчлэлийн энэ том концепт ер нь яаж яваад байгаа юм. Ер

нь цаашидаа энэ Улаанбаатар хотыг нэг төвтэй, тэгээд ийм олон дүүрэгтэй яваад байх нь зөв юм уу? Энэ баруун, зүүн бүс болгоод ингээд явах асуудлыг ер нь яагаад энэ тойргууд дээрээ яриагүй юм бэ? Ингээд харахад үндсэндээ Чингэлтэй, Сүхбаатар 2-оос өөр өөрчлөлт ер нь байхгүй харагдаад байх юм. Тэгээд энэ ямар манай улсын чинь тал хүн нь амьдарч байгаа энэ газар, энэ бүсчилсэн хөгжил, тэгээд энэ бусад хотуудаа уг нь байгуулаад явах энэ чиглэл рүүгээ л хэдүүлээ анхаарчихмаар өөрчлөлтөө оруулчих чиглэл рүү явуулчхаж болохгүй юу гэдэг нэг ийм асуулт. Ярилцаагүй юу? Ажлын хэсэг дээрээ та нар.

2 дугаарт, энэ тойргийн төвүүдтэй холбоотой энэ бас нэг асуулт байна. Одоо миний сонгогдож ажиллаж байгаа тойрог болох Дархан-Уул аймаг маань Сэлэнгэ аймаг, Төв аймгуудтай нийлээд 5 дугаар тойрог болж байна. Тойргийн төв гэхтэй зэрэг та бүхэн маань ямар зарчим барьсан юм бэ? Сонгогчдын тоо олонхоороо явчихсан юм уу, хүн амын тоо олонхоороо явчихсан юм уу, эсвэл газар нутгийн байрлалаараа явчихсан юм уу? Би бол жишээ нь энэ Төв аймгийн урдуур сумдын маань хүмүүс Зуунмодоос жишээ нь гэхэд Сэлэнгэ аймаг ортол давхих нь л дээ. Тойргийн төв дээр очиж асуудал ярихын тулд. Эрдэнэсантаас Сүхбаатар сум хойд хилийн үзүүр хүртэл явах гээд байна шүү дээ. Дэлгэрхаанаас, Төв аймгийн Дэлгэрхаанаас бүр хойшоо Алтанбулаг энэ юу руу Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум руу явна гэдэг их л хол явах гээд байгаа байхгүй юу. Газрын зургийнх нь байрлалаар ингээд харах юм бол уг нь Дархан төв нь юм шиг байгаа юм. Тэгэхээр нэгэнт бид нар энэ тойргийн төвүүдийг шийдэж байгаа бол энэ нөгөө бүсчилсэн хөгжлийнхөө үзэл баримтлалаараа явбал бид нар чинь шийдэцгээчихсэн шүү дээ. Энд бас дахиад дараачийнх нь энэ Орхон байна. Тийм ээ. Хөвсгөл аймагт аваачаад хийчихсэн байгаа юм. Хөвсгөл аймгийн Мөрөн сум бол сумын аймгийн ЗДТГ тойргийн төв гээд хийчихсэн байгаа байхгүй юу.

Тэгэнгүүт энд чинь Хөвсгөл аймаг, Булган аймаг, Орхон аймаг 3 байгаад байгаа юм. Хөгжлийн бодлогоороо бид нар Орхон аймгийг төв нь гээд үзчихсэн. Бас хөгжлийн бодлогын бичиг баримтаараа Дархан, Сэлэнгэ, Төв аймгаас Дархан-Уул аймаг төв нь гээд үзчихсэн. Тэгэхээр ямар зарчмаар та хэд маань энэ тойргийн төвөө тавьсан юм бэ гэдэг дээр асуулт байна. Тийм.

С.Одонтуяа: Төрийн орд маань бас эрчим хүчний хязгаарлалтад ороод байгаа юм байх даа. Хэн хариулах вэ? Нямаагийн Энхболд дарга хариулъя.

Н.Энхболд: Аливаа сонгуулиар тойрог тогтоох, мандатын тоо тогтоох бол өөрөө их олон талын сонирхлын огтлолцол дээр хийгддэг асуудал. Үүнийг манай УИХ-д сонгогдсон гишүүн болгон мэдэж байгаа. Түүний дотор тухайлбал ний нуугүй хэлэхэд тухай тухайн тойргоос сонгогдсон гишүүдийн сонирхол ч бас энэ дээр байдаг юм. Үүнийг нууж хаагаад байх юм байхгүй. Тэгээд би үүнийг яагаад хэлж байна гэхээр жишээ нь Улаанбаатар хотыг өнөөдрийн тогтоолын төсөлд орж ирсэн маягаар эхний ээлжид тойрог болгоё, мандатынхаа тоог хуваарилъя гэдэг дээр бас хотоос сонгогдсон гишүүдийнхээ санал онолыг нэлээн тал талаас нь сонсож байж, хоорондоо зөвшилцөөд, зөвшилцөж байсан хэсгүүдэд саналаа хүргүүлээд тэр нь Байнгын хороонд орж ирээд хийгдсэн ажил гэж ойлгож байгаа.

Ер нь өнгөрсөн сонгуулиар Улаанбаатар хот 9 тойрогтой байсан. Энэ удаа 6 болж байгаа. Тэгээд би түрүүн хэлсэн. Энэ бас одоо гишүүдийн яриад байгаа шиг Улаанбаатарыг яваандаа томсгосон хэсгүүд болгоод хуваарилж байх энэ чиглэл рүү хийгдэж байгаа алхам гэж бодож байна. Ер нь энэ хотын түгжрэл элдэв юмтай холбогдоод сая Улаанбаатар хоттой холбогдсон шинэ удирдлагатайгаар баахан хуулиуд оруулж ирж яригдах үеэр бас гишүүдийн дунд өрнөж байсан нэг

сэдэв юу вэ гэхээр бас яг саяын Дамдинням гишүүний хэлж байгаа шиг томсгоё, дүүргүүдийг ер нь хотын статустай болгоё. Тийм ээ, нэгтгэе. Ийм зүйлүүд яригдаж байсан. Тэгэхээр нэгэнт ингээд яригдаад эхэлсэн зүйл бол би чиг хандлага тийшээ явж байгаа л гэж харж байгаа. Тэгээд алхам алхмаар энэ тал руугаа хийгдэх байх аа гэж бодож байна. Олон сонирхлуудын дотроос тэр гишүүдийн юм бас энэ дээр тодорхой хэмжээгээр тусаад санал нь нэгдээд ийм яг одоогоор 9 байсан 6 болж ирээд орсон гэдгээ хэлчихье.

Тойргийн төвийн хувьд бид нар бас анхнаасаа тэгж бодож л байсан. Яг жишээ болгоод түрүүн ярьсан. Хөвсгөл, Орхон, Булганы хувьд гэвэл Орхон төв нь байх юм уу, газарзүйн байрилынхаа хувьд ч гэсэн гэсэн маягаар Төв аймаг, Сэлэнгэ, Дархан гэхэд Дархан ч байдаг юм уу тийм ээ. Гэтэл бид нарын бас бүгдээрээ хамт сууж байгаад баталчихсан Сонгуулийн тухай хууль дээр 14.7-д хэрэв 2 ба түүнээс дээш аймаг нэгдэж, сонгуулийн тойрог байгуулбал хамгийн олон сонгогчтой аймагт төв нь байрлана гээд заачихсан юм байна лээ. Та бид 2 гараа өргөж байгаад батлаад заачихсан. Яг түүнийхээ дагуу л явж байгаа. Өчигдөр бас Байнгын хороон дээр жосоохон шүүмжлүүлсэн л дээ бид нар. Та нар үүнийг яагаад ингэчихэв гээд. Тэгээд би ийм хуультай юм байна лээ гэдгийг нь хэлсэн. Тэгээд түүгээрээ л явж байгаа.

Урьд нь бид нарын баталчихсан Үндсэн хуулийн дагуу Сонгуулийн тухай хуульд оруулсан тэр хууль дотроо 14.7, 17-д нь тэгээд заачихсан болохоор өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийнхаа дагуу 1 дүгээр тойрог Өвөрхангай, 2 нь Ховд дээр, 3 дахь Баян-Өлгий, 4 дэх нь Хөвсгөлд, 5 дахь нь Сэлэнгэд, 6 дахь нь Дорнодод, 7 дахь нь Өмнөговьд гээд ингээд явчихсан. Ер нь сонгуулийн үеэр яг хувь сонгогч тэр болгон заавал тойргийн төв рүү очоод байх шаардлага байдаггүй л дээ. Ямар нэгэн бүртгэлтэй холбоотой бусад

асуудлууд гарвал тухайн хэсгүүд дээрээ тэр чинь яг ... /минут дуусав/

С.Одонтуяа: Нанзадын Наранбаатар гишүүн алга байна. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Асуулт, үг хамт.

М.Оюунчимэг: Бид нар үнэхээр энэ улс төрчид улсаа бодохгүй бол улс орон маань ер нь ямархуу түвшинд хүрчихсэнийг бид өнөөдөр хотод ч, хөдөө ч харж байгаа. Улаанбаатар хотод гэхэд зөндөө л төсөв мөнгө хуваарилаад байдаг. Гэтэл өнөөдөр түгжрэл нь ч хэвээрээ, утаа нь ч хэвээрээ. Энэ сүүлийн жилүүд биш 30 жилийн төсвийн буруу хуваарилалтын сөрөг үр дагавар гэж би харж байгаа. Бид нар сая энэ нүүрсний нээлттэй сонсгол хийж байна. Өчигдөр л ингээд харж байхад жишээлбэл нүүрс дагасан тэр хуйвалдааны мөнгө, хулгайн мөнгө нь өөрөө хэд хэдэн цахилгаан станц барьчих хэмжээний л асуудал байхад энэ нь өөрөө өнөөдөр баригдаж чадаагүй. ДЦС-аа барьчих мөнгө нь 500 саяар барьчихъя гэтэл 500 сая ам долларын хэмжээний мөнгө буруу замаар урсчихсан байх жишээтэй байгаад байгаа юм. Тийм учраас бүсчилсэн хөгжлөөр хөгжих, тойргийг энэ маягаар хуваарилах энэ зарчмыг би хувьдаа бас дэмжиж байгаа. Жишээ нь хөдөө орон нутагт гэж өнөөдөр харъя. Газар тариалангийн бүс, уулын уурхай, эдийн засгийн бүс, аялал жуулчлалын бүс ч гэдэг юм уу. Яг ингээд бодит утгаар нь бүсчилж яваад төсвийн зөв хуваарилалт, мэдрэмжтэй хуваарилалт хийчихвэл жишээ нь хөдөө орон нутаг өнөөдөр эзгүйрчихсэн, цөлжилт энэ асуудлаа шийдэх бололцоо байгаа.

Хамгийн чухал нь өнөөдөр Улаанбаатар хот байна. Сая 300, 400 мянган хүн амтай. Тэгээд өнөөдөр яаж байна. Нөгөө л түгжрэл, утаа. Энэ нь өөрөө нийслэлийн иргэдийн эрүүл мэндийн эсрэг бараг л гэмт хэрэг үйлдэх хэмжээнд хүрч байгааг бид нар өнөөдөр харж байна л даа. Тийм учраас манай ЧД, СБД-ийн жишээ нь гишүүд бид бас

манлайлал үзүүлээд хотдоо ямар ч байсан нэг тойрог болж орёе. Ингэснээрээ Сэлбэ дэд төвийг ашиглаад ЧД, СБД-ийн жишээ нь гэр хорооллийг орон сууцжуулах, дэд бүтэцжүүлэх бүрэн бололцоо жишээлбэл бий болно гэж бид нар харж байгаа. Одоо жишээлбэл 2024-26 оны хооронд Сэлбэ дэд төвийг ашиглаад Чингэлтэй, Сүхбаатарын 16 мянган айл өрх дэд бүтэц орон сууцад орох энэ төсөл хэрэгжиж эхлэх гэж байна. Төсвийг нь бид сая нийслэлийн төсөв дээр суулгасан. Газар чөлөөлөлт явагдах гэж байна. Тэгэхээр энэ 2 ЧД, СБД нэг бүс болж, нэг тойрог болж орсноороо бид нийслэл Улаанбаатар хотын гэр хороололд үлгэр жишээ болох ийм бололцоо бүрдэнэ гэж харж байгаа учраас бас дэмжиж байгаа.

Энэ нь өөрөө ганц гэр хорооллын асуудал биш, үүнийгээ дагаад утаа, түгжрэл, хөрсний бохирдол арилна гэж харж байгаа. Одоо жишээ нь нийслэлийн гэр хорооллын 85 хувь нь жорлонгийн буюу энэ бохирос болсон. Тэр нь ундны ус худаг руугаа орчихсон. Өнөөдөр энэ ямар байсныг өнгөрсөн зун болсон нөгөө үерийн үеэр бид бодитоор харсан. Тийм л учраас СБД-ийн гишүүд, манай ЧД-ийн гишүүд бас манлайлал үзүүлээд бид нэг бүс болоод орёе. Энэ 2 дүүргийг үлгэр жишээ болоод хөгжүүлэе гээд манай Учрал дарга, Цогтбаатар гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Сүхбаатар гишүүн маань гээд бид нар бас ямар ч байсан нийслэлийн тойрог дотроо манлайлал үзүүлээд ингээд орж байгаа. Энэ нь өөрөө манай энэ 2 дүүргийн иргэдэд эерэг үр дүн авчирна. Бид төсөв батлах үед яг энэ рүүгээ чиглэсэн том том төслүүдийг хэрэгжүүлээд, хойгуураа том замууд тавих, яг урдуураа болохоор бид нар энэ орон сууцжуулах ажлуудыг хийчих гээд ийм бололцоо жишээлбэл бүрдэнэ.

Нөгөө талаасаа нөгөө жижиг, дунд үйлдвэрлэл, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүд нэлээд үлгэр жишээ байдаг. Тэгвэл энэ нь бас энэ хөгжөөд инкубатор маягаараа хөгжиж явах энэ нь өөрөө бас энэ хүмүүс эргээд жижиг дундаасаа том

бизнес рүү, том ААН рүү орох бас энэ бололцоо бүрдэнэ гэж ингэж харж байгаа. Тийм учраас бүсчилсэн хөгжлийн үр дүн нийслэл Улаанбаатар хот дээр жишээ нь энэ 2 дүүрэг үлгэр жишээ болох бололцоо байгаа учраас бид нар бас үүнийг ингэж дэмжиж орж ирж байгаа.

Тэгээд ер нь ингээд хувь хувиа бодох биш иргэдээ, улс орноо бодох цаг үнэхээр болсон байна. Бид үнэхээр хяналтаа ч тавьж, улс орноо бодохгүй бол өнөөдөр би сая хэлж байна. Бид энд 1,1 их наяд өчигдөр жишээ нь бид нар зүгээр нэг баяжуулах үйлдвэр барина гэдгээр алдчихсан байна шүү дээ. Гэтэл үүгээр 10 дэд станц барьчихвал өнөөдөр тогийн асуудал гэдэг байхгүй ... /минут дуусав/

С.Одонтуяа: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн 1 минут нэмж авъя. Тодруулга.

М.Оюунчимэг: Тэгэхээр бид ингээд л тог хязгаарлах тухай ярьж байгаа юм. Гэтэл алдагдсан боломжийг аваад үзэхэд зүгээр л 1 их наяд төгрөгийн ганцхан түлшний үйлдвэр дээр гэвэл түүгээр 10, 20 дэд станц барьчихсан, тэр дэд станцаараа өнөөдөр бараг нийслэлийн 230 мянган гэр хорооллын айл өрхийг зүгээр орон сууц, тогжуулах ийм бололцоо байхад л бид ингэж алдаад байгаа. Тийм учраас том утгаараа бүслээд, том тойргоороо явбал энэ хулгайг ч бид бас зогсох бололцоо бүрдэнэ гэж бодож байгаа. Тиймээс бас энэ санаачилгыг гаргаад ингээд бас нэгдсэн. Би МАН-ын дарга Оюун-Эрдэнэ, АН-ын дарга Гантөмөр, Хүн намын дарга Доржханд энэ тэрд бас ингээд энэ зүйл дээр ойлголцоод нэгэнт пропорциональ тойргийн жинхэнэ агуулга утгыг хөрсөн дээр буулгах. Энэ нь өөрөө өнөөдөр энэ бүсчилж хөгжүүлэх энэ гэж харж байгаа учраас ингээд нэгдээд энэ зүг рүү бас харсанд нь бас талархал илэрхийлж байгаа. Тэгээд ер нь улс орноо бодоцгооё, иргэдээ бодъё. Тийм ч учраас энэ бүсчилсэн хөгжлөөр үүнийгээ ... /минут дуусав/

С.Одонтуяа: Мэндчилгээ танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учралын урилгаар Социал демократ Монголын залуучуудын холбооны сайн дурын ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс ажил амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Оюунчимэг гишүүн дэмжиж үг хэллээ гэж ойлгосон.

Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Дараа нь Раднаасэд гишүүн бэлдэж байгаарай.

Б.Баттөмөр: Сонгуулийг бүтэц зохион байгуулах энэ орж ирж байгаа төслийг дэмжиж байна. Энэ ер нь нэлээн эрт хийгдэх ёстой л ажил л даа. Энэ өнгөрсөн үүнийг хийхийн урт мэдээж тооцоо судалгаа хийгээ биз дээ. Өнгөрсөн 30 жилийн хугацаанд чинь бид ер нь ямар түвшинд хүрч хөвж байгаа вэ? Миний үзэж байгаагаар Монголын хүн ам 2 сая байснаа 3,5 сая болж өссөн. Энэ талбай тойрсон хэдэн өндөр байшинг эс тооцвол бидэнд хөгжлийн асуудал үндсэндээ байхгүй дээ. Үүнийг шууд хэлэх ёстой.

Ер нь өнөөдөр 3,5 сая хүний 910 мянга нь ядуу байна. Эдийн засгийн эрх чөлөөгүй байна гээд Дэлхийн банк гаргачихсан, 28 хувь нь. Дахиад 15 хувь нь ядуурах магадлалтай гэж байгаа юм. Энэ бас нэг 4 зуугаад мянган хүн болчхож байгаа юм. Ингээд сая 3 зуугаад мянган хүн ядуу байдаг. Бид мундаг ардчиллын бэлгэ тэмдэг, өлгий гэрэлтэй цэг гэж. Иргэд нь дөчөөд хувь нь ядуурчихсан ардчилалтай улс гэж байхгүй шүү дээ. Тэгээд энэ чинь цаашаа ингээд үзэх юм бол их олон асуудлуудыг ярьж байгаа. 2 хөршийнхөө 2 хөршгүй найрамдал сайхан харилцаатай. Гэхдээ дэндүү их хамааралтай болчихсон. Өнөөдөр болж байгаа үйл явдлуудыг та нар харж байгаа шүү дээ. Эрчим хүч,

түлиний асуудал маш хүнд байдалд орчихсон байна. Бид ашигт малтмалаа, баялгаа үнэ хүргэж зарж чадахгүй. Бас Дэлхийн банкны гаргасан судалгаагаар юу гэхээр худалдаж байгаа ашигт малтмал бол ОХУ зах зээлд худалдаж байгаа үнээс 18 хувиар бага, дэлхийн зах зээлийн үнээс 50 хувиар бага. Иймэрхүү л юм хийгээд л бид нар яваад байгаа байхгүй юу. Тэгээд 2 хөрш 3 дахь хөршүүд бидэнд гараа сунгаж байгаа. Үүнийг хэлэх ёстой. Хамгийн гол нь бид дотооддоо учраа олохгүй л мунгинаад яваад байгаа шүү дээ. Хамгийн их өвчлөлтэй, нэг хүнд ноогдох өрөөр дэлхийд тэргүүлж байгаа. Хамгийн их бохирдолтой, түгжрэлтэй, хамгийн их ядууралтай, хамгийн их баян хоосны ялгаатай, хамгийн муу баялгийн менежменттэй. Энэ юу вэ гэхээр олон хүчин зүйлээс хамаарч байгаа. Тэгэхдээ энэ сонгуулийн өнөөдөр явж ирсэн тогтолцоо бас нөлөөлнө. Буруу тогтолцоо сонгуулийн, жалга довын үзүүлэлттэй, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх асуудал, санал худалдаж авдаг арга гээд маш их олон асуудлууд энд явж байгаа шүү дээ.

Аливаа улс хөгжихийн тулд давуу чанараа барьж хөгждөг. Сингапур улс яагаад дэлхийг манлайлж байна гэхээр газар зүйн байршил нь. Монгол Улс яаж хөгжих вэ гэхээр баялгийнхаа менежментийг зөв хийх ёстой. Монгол Улсад хийгдэж байгаа энэ маш их олон ажлууд хийж байна. Харамсалтай нь амин сүнсгүй. Яагаад гэхээр эдийн засгаар баталгаажсаагүй. Ийм л байгаа.

Тэгээд тэр 2000 оны эхээр бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Үндэсний хөгжлийн цогц бодлого гээд би бас эрдэмтэн хүний хувьд энд оролцож, санал бодлоо оруулж байсан. Нэг нь ч ажил болоогүй. Одоо Алсын хараа 2050 бас хэрэгжилт нь хангалтгүй ийм л байгаа. Тэгээд ер нь энэ томсох ёстой. Энэ бол эхний алхам. Улаанбаатар хотыг ингээд 5, 6 хуваагаад хоёрхон дүүргийг ингэдэг бол буруу. Бас нөгөө л нэг дүүрэг дүүрэг рүүгээ татдаг энэ юм тэгээд л

цаашаа явна. Тийм учраас ер нь Монгол Улс цаашидаа яаж хөгжих вэ гэхээр ер нь 100 хувь пропорциональ болох ёстой юм байна лээ. Намууд нь сонгодог, мөрийн хөтөлбөрөө гаргадаг ийм л тогтолцоо руу явахгүй бол болохгүй байна.

Хамгийн сүүлд гэхэд энэ тойргуудын төвийг бас эргээж үзээрэй. Тэр Сонгуулийн хуульдаа өөрчлөөд хамгийн их гэдгийг хасаад, газар зүйн байршил хамгийн чухал шүү. Газар зүйн байршил их чухал. Хүссэн хүсээгүй тэр сонгуулийнхаа тойрог дээр тэр дэвшсэн хүн очиж таарна ... /минут дуусав/

С.Одонтуяа: Санал хэллээ. Шатарбалын Раднаасэд гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Ш.Раднаасэд: Би энэ ажлын хэсгээс ганц нэг асуулт байна. Ерөнхий том бодлогын хувьд төсвийн хуваарилалт энэ бүх өнгөрсөн хугацаанд явж ирсэн юмнуудыг харахад агуулгын хувьд зөв өө. Би үүнийг дэмжиж байгаа. Гэхдээ нэг бүсчиллээ гэхэд бас арай хэтэрхий жоохон томсгочхов уу гэж харж байна. Говь-Алтай, Завхан, Увс, Ховд 4 аймаг нийт өнгөрсөн сонгуулиар хэчнээн хүн нэр дэвшиж байсан, үүнийг ажлын хэсэг хэлж өгөөч? Одоо энэ сонгогчийн тооноос ингээд харж байхад Говь-Алтайгаас бусад бүх аймгуудад нь дандаа 50-аас дээш мянган сонгогчидтой, нийт 190 мянган сонгогч. Тэгээд энэ орон нутаг төлөөлөлгүй болох магадлал маш өндөр. Мэдээж Монголчууд минийх гэдэг хандлагаар явж ирсэн ард түмэн. Аймгаас гарвал аймаг минийх болдог, Монголоос гарвал Монгол минийх болдог. Тэгээд нам хар гэхгүйгээр хамгийн өндөр их сонгогчтой Увс аймаг ч гэдэг юм уу жишээлбэл, Ховд ч гэдэг юм уу бүх намуудаас дэвшсэн өөрийнхөө хүнийг 10 хүнийг бөөрөнхийлөөд л гарах байх. Тэгээд нөгөө сонгогч цөөтэй, ам бүл цөөтэй, аймгууд чинь эзэнгүйдэх ийм талтай.

Тэгээд бид нарын хувьд газар нутаг болоод хүн ард 2 хүйн холбоотой

явсан төртэй нь холбож байсан энэ холбоос гүүр чинь аймгууд, ялангуяа энэ сонгогчийн тоо цөөтэй аймгууд дээр алдагдах ийм нөхцөл бүрдсэн гэж харагдаж байна. 190 мянган сонгогчийн 70 хувь гэхэд ер нь дундажлаад Сонгуулийн ерөнхий хороо дээр энэ аймгууд дээр хэдэн хувийг нь санал өгдөг юм. 93 мянган сонгогчийн. Түүнээс хэдэн хувь нь хамгийн хэдэн хувь нь хамгийн өндөр санал авч орж ирсэн ч байдаг юм уу, үүгээр ингээд тооцоод харахаар та бүхэнд тоо байгаа байх. Энэ магадлалаар бодохоор ер нь хэдий хэмжээний хүний санал авч байж нэг гишүүн сонгогдож болох талтай байгаа юм. Их Хурлын гишүүн болох талтай байгаа юм. Тэгээд энэ аймгаас сонгогдож байгаа гэдэг чинь тэр аймгийн зовлон нэг аймгийн зовлонгийн асуудал биш л дээ энэ чинь. Тэр багт нь, сум болгонд нь, бодвол өрх болгонд нь хүрч ажиллахын төлөө л гишүүд ажиллаж байгаа. Энэ байдал чинь зарчим чинь алдагдах болов уу гэж.

Бас нэг зүйл бол энэ сонгуулийн тогтолцоог яг ингээд яг энэ тойргийн зарчмыг авч явна гэвэл 2-3 сонгууль дамжуулан авч явах хэрэгтэй байна. 4 жил тутам энэ тойрог хөдөлгөдөг бол өөрөө эзэнгүйдэх талтай. Бид бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал гээд өнөөдөр гишүүд ярьж байна 2005, 2006 оны үед Засгийн газраас баталж байсан, Их Хурлаас. Тухайн үедээ 5, 6 бүсэд хуваагаад ингээд бүсийн тулгуур төв нь аль нь вэ гэдэг дээр маргаад л дараа нь тулгуур төв нь энэ аймаг, тэр аймаг гэдэг дээрээ маргаад, тэгээд тулгуур төв рүүгээ түлхүү хөрөнгө оруулалт тавина гэж явж байгаад, сүүлдээ тэр нь задраад бүр байхгүй болсон. Тэгээд нөгөө тулгуур биш төвүүд нь жишээлбэл хөрөнгө оруулалтаас хоцордог, тулгуур төвүүд нь түлхүү тавигдаад үлддэг. Тэгээд тэр бодлого нь үргэлжилж явалгүй тасарсан учраас ингээд л нэг хэсэг нь хохироод л, нэг хэсэг нь хожоод л явсан. Энэ аймаг хожиж байгаа юм. Үүний цаана хүмүүсийн хөгжлийн асуудал байгаа юм л даа. Тэгэхээр энэ

тойргийг урт удаан хугацаанд нэг 2 ...
/минут дуусав/

С.Одонтуяа: Ажлын хэсэг хариулъя. Байнгын хорооны дарга түр гарсан байгаа. Ажлын хэсэг хариулна. Нөгөө өмнөх сонгуулиудын мандатын талаар бас. 85 Баяндүүрэн Сонгуулийн ерөнхий хорооны ажлын албаны дарга.

Д.Баяндүүрэн: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын 20 оны сонгуулиар Ховд аймагт 3 мандаттай 17 нэр дэвшигчтэй байсан байна. Увс аймагт 3 мандаттай 23 нэр дэвшигчтэй. Говь-Алтай аймагт 2 мандаттай 10 нэр дэвшигчтэй. Завхан аймагт 2 мандаттай 14 нэр дэвшигчтэй. Энэ бүсийн дүнгээрээ 64 нэр дэвшигчтэй нийтдээ 10 мандат байсан байна.

Одоогийн орж ирж байгаа төслөөр энэ мандатын тоо 10 хэвээрээ орж байгаа. Ирцийн хувьд Говь-Алтай аймагт 75,6 хувь, улсын хэмжээгээр 73,6 хувийн ирцтэйгээр санал хураалт явагдсан байна.

С.Одонтуяа: СЕХ-ныхон өшөө сайн дэлгэрэнгүй хариулчих. Хэн, Дэлгэрнарэн дарга хариулах уу? Хэн хариулах вэ? Баяндүүрэн. Юуныхаа, юуг өргөөд 83 дугаар микрофон 83 Бат-Эрдэнэ үү? Сонгуулийн ерөнхий хорооны Хууль, эрх зүйн хэлтэс.

Д.Бат-Эрдэнэ: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. 20 оны Улсын Их Хурлын сонгуулиар Говь-Алтай аймгийн хувьд 75,6 хувийн ирцтэй байсан байна. Завхан аймгийн хувьд болохоор 80 хувийн ирцтэй, дундажлаад үзэх юм бол 73,4 хувийн ирцтэй байсан байдаг. Ер нь сонгуулийн тойрог томорч байгаатай холбоотойгоор Сонгуулийн ерөнхий хорооноос зайлиггүй авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээ бол энэ сонгогчдын ирц, оролцоог нэмэгдүүлэх, мөн саналын хуудсан дээрх тэмдэглэгээг хэрхэн тэмдэглэх талаар өргөн хэмжээнд энэ мэдээллийг түгээх ажлыг

зайлиггүй хийх ийм шаардлага бий гэдэг нь харагдаж байгаа. Баярлалаа.

С.Одонтуяа: Тодруулах юм уу Раднаасэд гишүүн. Раднаасэд гишүүн тодруулъя.

Ш.Раднаасэд: Энэ ер нь өнгөрсөн хугацаанд энэ би түрүүн хэлэх гэж байсан өгүүлбэрийг гүйцээхэд энэ тойргийг их олон өөрчлөөд байх өөрөө бас одоо энэ гишүүдийн яриад байгаа энэ хөгжлийн чинь бас нэг саад болоод байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ энэ өнгөрсөн бүх сонгуулиудын хугацаанд Монгол Улс ер нь тойргийн энэ юуг хэчнээн удаан өөрчилж байсан юм бэ? Сонгууль болгоноор өөрчилж байсан юм уу, эсвэл энэ тогтвортой явж байсан юм бас юунууд байна уу?

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Баяндүүрэн дарга хариулъя.

Д.Баяндүүрэн: Раднаасэд гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын сонгуулийн тойрог энэ одоог хүртэлх 6 удаа өөрчлөгдсөн байна. Хамгийн анх 92 оны 4 сарын 10-ны өдрийн 20 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулагдаж байсан. Дараа нь 96 онд Улсын Их Хурлын сонгуулийн тойрог байгуулагдсан. Энэ тойрог маань 2007 онд бас өөрчлөгдсөн. Ингээд 2011 онд сонгуулийн тойргууд маань өөрчлөгдсөн. 2016 онд бас сонгуулийн тойргийг шинээр Улсын Их Хурлын 41 дүгээр тогтоолоор сонгуулийн тойргийг байгуулсан. 20 оны 01 сарын 30-нд бас Улсын Их Хурлын сонгуулийн тойргийг одоогийн энэ хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа тойргийг байгуулсан байна. Ингээд нийтдээ 8 удаагийн сонгууль явуулахдаа Улсын Их Хурлын 8 удаагийн сонгууль явуулахдаа 6 удаа тойрог өөрчлөгдсөн байна.

С.Одонтуяа: Жигжидийн Батжаргал гишүүн алга байна. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Өнөрболор: Өнөөдрийн мэндийг хүргэе. Ер нь маш чухал түүхэн шийдвэр гэж бид нар хэлэлцэж байна. Энэ шийдвэр үнэхээр өнөөгийн энэ тэгш бус байдал, авлига, хээл хахууль, баян, ядуугийн ялгаа, энэ асуудлуудыг гал унтраах байдлаар өнөөдөр засаж, яг үнэн бодит байдлаас зугтаж ирсэн ийм тогтсон хэв маягийг засах ийм нөхцөл байдал үүсэх юм байна.

Нөгөөтээгүүр улс орны урт хугацааны бодлого хөтөлбөр, тэр дундаа энэ шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх бол улс төрийн том шийдвэр гэж харж байна. Өнгөрсөн хугацаанд энэ жижиг тойргоос ер нь цөөн хэдэн сонгогчдыг худалдаж авах замаар луйвардаж гарч ирэх ч юм уу эсвэл гарч ирсэн гишүүд нь сайд, Ерөнхий сайд, дарга нар болоод тийм ээ, аймагтаа илтэд асар их төсвийн хөрөнгө оруулалт хуваарилах ч юм уу. Ингэж зөвхөн улс орныг бүхэлд нь ингээд харах биш ер нь энэ жалгыг тордох байдлаар явж ирсэн энэ 30 жилийн буруу жишиг энэ туршлага ер нь үндсэндээ халах цаг болсон гэж үзэж байгаа.

Нөгөөтээгүүр энэ тогтоолыг дагаад Сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж ирэх байх. Өмнө нь бас миний бие энэ Улс төрийн намуудын тухай хууль, мөн Сонгуулийн тухай хуульд бас хэлэлцэх үеэр энэ асуудлыг дэвшүүлж байсан. Тухайлах юм бол улс төрийн намууд нэр дэвшигчдэд тавих босгыг өндөрсгөх асуудлын талаар, өөрөөр хэлэх юм бол Улсын Их Хурал энэ ёс зүйгүй нөхдөөс болоод өнөөдөр иргэдийн энэ төрд итгэх итгэл алдарч байгаа ийм байдал газар авсан. Бас нэг Улсын Их Хуралд анзаарагдаад байгаа асуудал энэ санхүүгийн эрх чөлөөнд хүрсэн байх асуудал их чухал юм байна гэж ойлгож байгаа. Ер нь Монгол ардын зүйр үгэнд биеэ засаад гэрээ зас, гэрээ засаад төрөө зас аа гэдэг. Гэхдээ энэ гэрээ байтугай зарим нь биеэ ч засаагүй, засаж чадаагүй энэ нөхөд ёс суртахууны энэ доголдлоосоо болоод бүдэрч байна. Төрөө засна аа гэж орж ирээд гэрээ

засах гээд улайм цайм өлөнтөөд, цөлмөөд тийм ээ, өнөөдөр ч хүртэл одоо энэ ЖДҮ, Боловсролын сан, Хөгжлийн банк, энэ нүүрсний гэх мэт ард иргэдийн боломжийг хулгайлсан асуудлаа өнөөдөр ч бид нар шийдвэрлэж чадаагүй. Ийм л байдалтай байна. Тийм учраас энэ улс төрийн намууд өндөр хариуцлагатай, ёс зүйтэй, төрд итгэх итгэлийг сэргээх хэрэгтэй байна. Улс орон, хүн ардаа хөгжилд хөтлөх ийм хүмүүсийг нэр дэвшүүлэх нь өнөөгийн цагийн зүй ёсны шаардлага болоод байгааг анхаарах нь зүйтэй байна.

Би Энхболд даргаас нэг зүйлийг асууя. Энэ тойргийн энэ жагсаалттай холбоотойгоор асуудлыг нэг мөр шийдэх нь зөв байсан юм биш үү. Энэ жагсаалтын одоо асуудлын цуг энэ тойргийн асуудалдаа оруулж ирэх нь бас зөв байсан юм биш үү? Энэ талаар ер нь ямар ойлголттой асуудал байна. Хариулт авъя.

С.Одонтуяа: Мэндчилгээ дэвшүүлье.

Улсын Их Хурлын гишүүн Нямаагийн Энхболдын урилгаар Хустайн байгалийн цогцолборт газрын ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд ажлын амжилт, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Нямаагийн Энхболд дарга асуултад хариулна.

Н.Энхболд: Энэ өнөөдөр бид нар сонгуулийн тойргийнхоо асуудлыг ярьж байгаа. Тойрогт нэр дэвшүүлэх, жагсаалтаар нэр дэвших асуудал тусдаа. Урьд өмнө яг энэ асуудлыг хэлэлцэж ирсэн Их Хурлын дэг, практик түүхээр өнөөдөр яг жагсаалтад хэнийг яаж оруулах вэ гэдэг асуудал орохгүй. Угаасаа жагсаалтын тухай энд үг ч байхгүй. Тэр нь өөрөө Үндсэн хууль, Сонгуулийн тухай хуулиар тусдаа заалтаар зохицуулагдчихсан учраас энд орохгүй, ордоггүй юм.

Ер нь яаж нам дотор жагсаалтаа хийх вэ, өөрийн чинь хэлдгээр шалгууруудаа яаж тавих вэ, зөв хүмүүсээ яаж сонгох вэ, ямар эрэмбээр жагсаах вэ гэдэг бол Намуудын тухай хууль бусад хуулиудаар яг улс төрийн намуудад хариуцлага болгоод хүлээлгэчихсэн ийм зүйл учраас яг өнөөдрийн энэ асуудалтай хамт холбогдож орж ирээгүй, орж ирдэг ч үгүй юм гэдгийг хэлчихье ээ. Баярлалаа.

С.Одонтуяа: Тогмидын Доржханд гишүүн алга байна. Одоо хэн Болорчулуун гишүүн алга байна. Амгалангийн Адьяасүрэн гишүүн асуултаа асууж, үг хэлнэ.

А.Адьяасүрэн: Баярлалаа. Тойрог томсохоор улсаа аварна гэх ухуулга сүүлийн үед хүчтэй явж байна л даа. Том тойрогт ч үгээгүй ядуу улсууд зөндөө байгаа. Асуудлын гол нь тойргийн хэмжээнд биш төр барьж байгаа хүмүүсийн тархинд байгааг яагаад бид нар ярихгүй байгаа юм бэ. 1990 оноос хойш шинэ тогтолцоогоор явахаар шийдсэнээс хойших хугацааны 90 хувьд нь коммунистууд засагласан. Шинэ нийгмийг хуучин удирдлага, хуучин арга барилаар, үхирсэн сэтгэхүйгээр удирдуулсанд гол алдаа байгаа болохоос биш тойргийн хэмжээ ямар ч хамаагүй. Нарийн ярих юм бол энэ эрх баригчдын дундах дайны илрэл явагдаж байгаа шүү дээ. Нуугаад байгаа болохоос биш дайн явагдаж байгаа шүү дээ. Хуулийн хулгай гэж үүнийг хэлнэ. Эрх баригчид биднээс хулгайлж болох бүгдийг хулгайлсан. Тэд хулгайгаа бусад руу чихэхдээ гарамгай. Үүнийг сүүлийн үед энэ нүүрсний сонсгол яруу тод харуулж байгаа. 8 жил бүх шатад дангаар ноёрхож, засагчлаа хамар доор нь үндэсний баялгийг өм цөм хулгайлж байгааг хараагүй, мэдээгүй дүр үзүүлж, эцэст нь шийдвэр гаргах ямар ч эрх мэдэлгүй, хүний ачаа зөөж амьдардаг хүмүүс рүү хулгайгаа чихэхийг оролдож байгааг ард түмэн хараад сууж байгаа.

Одоо бүр сүүлдээ ард түмний хамгийн сүүлчийн эрхийг сонгох эрхийг хулгайлах хуулиа батлах гээд сууж

байна. Сөрөх ёстой намууд нь эрх баригчдынхаа тулгалтыг алгаа тосоод хүлээж авдаг, арчаагүй улс төр нэгэнт тогтсон байна. Тэд иргэдийн сонголтыг өөрийнхөөрөө хийх ганцхан эрхийг хасаж, төрт улсаа байгуулах эрхийг маань бас хулгайлахаар шийдсэн. Тэгээд МАН яаж ч тогос шиг гоёж, хөхөө шиг донгодоод ард түмэн итгэхгүй болсон шүү дээ. Үүнийг мэдээд эрх баригчид эрх мэдлээ сунгах сүүлийн мэхээ л хийж байна. Тойргийнхоо сонгогчдын итгэлийг алдсанаа мэдэж байгаа. Тэгээд олон намын гишүүд, төрийн албаныхны саналыг өөр дээрээ цуглуулж байгаад ахин сонгогдоно гэдэг санаархал явж байна.

Мөн эрх баригчид Үндсэн хуулиа зөрчиж байна. Үндэс угсаагаар ялгаварлахыг хориглосон. Үндэсний эв нэгдлийг хангах заалтуудыг зөрчсөн хууль бас орж ирж байна. Монголын нийт сонгогчдын эрх ашгийг гэж сүртэй ярьдаг мөртөө яагаад Баян-Өлгий аймгийг дангаар нь нэг тойрог болгож байгаа юм. Энэ чинь ялгаварлал, салан тусгаарлах үзэл биш юм уу? Эсэргүүцэж байна гээд дуугарах гишүүн бас яагаад байхгүй байгаа юм? Бид нар яагаад сонгогдсон иргэдийнхээ сонгох эрхийн төлөө дуугарахгүй байгаа юм бэ? Үүнийг би өнөөдөр Монголын ардчилалд цэг тавьж байгаа өдөр гэж үзэж байна. Гэхдээ бид үүнийг цэг болгохгүй ээ. Тэмцэнэ, сөрнө. Иргэд энэ тойргийн хуваарилалт, энэ завхралыг огтхон ч дэмжихгүй байгаа гэдгийг бас сүүлийн үеийн судалгаануудыг бас олж хараасай гэж бас би эрх баригчдаас хүсэх гэж байна.

Г.Занданшатар: Үг хэллээ. Нямаагийн Энхболд дарга хариулах уу? Сая санал хэлсэн. Энэ улс төрийн намуудын нэгдсэн тохиролцоо гэж санамж бичигт гарын үсэг зураад хэрэгжиж байгаа ажил гэж ойлгож байгаа шүү дээ, тийм ээ.

Тогмидын Доржханд гишүүн ХҮН намын дарга үг хэлнэ. Асуулт асууж, үг хэлнэ.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр би Улсын Их Хурлын гишүүн, ХҮН намын даргын хувиар санамж бичиг дээр гарын үсэг зурсан хүн байна. Тэгээд Ардын нам болон АН-ын дарга Л.Оюун-Эрдэнэ тэгээд Гантөмөр нар хамтдаа зурсан. Тэгээд би энд үүнийг Монгол Улсын ардчиллыг бэхжүүлэх маш том үйл хэрэг дээр гарын үсэг зурлаа гэж үзэж байгаа. Яагаад вэ гээд тэгэхээр өнөөдөр 33 жилийн хугацаанд Монголын эдийн засаг, нийгмийн амьдралд иргэдийн хүсэн хүлээгддэг байсан энэ өөрчлөлт гарч чадсан уу л гэдгийг асуугаарай гэж хүсэж байгаа юм. Дэлхий ертөнц дээр 200 улс байна. 200 улсын тал нь ингээд авторитор дэглэм рүү ингээд халтираад байна. Тал нь ардчилсан дэглэмээ ингээд хамгаалаад яваад байна.

Монгол Улс ардчилсан улс шүү. Ардчилсан улсыг хамгаалдаг зүйл нь юу вэ гэхээр өнөөдөр парламентын ардчилал байгаа юм. Тийм болохоор парламентын ардчиллыг бэхжүүлэхийн тулд бид нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн юм. ХҮН намын даргын хувьд ХҮН намынхаа залуучуудтай Монгол Улсынхаа 21 аймаг, 9 дүүрэг, бүх иргэдтэй очиж уулзаж, 2 жил дараалан ярьсан. Өнөөдөр нийт 330 сумынхаа иргэдтэй уулзаад явж байна.

Би бол хувь гишүүний хувиар 100 гаруй сумдаар яваад л ажиллаад л байна. Иргэд юу хүсээд байгаа юм. Иргэд энэ нэг талцал хуваагдлаа больж өгөөч, ийм л зүйл хүсэж байна шүү дээ. Иргэд юу хүсээд байна гээд тэгэхээр зүүн аймгийнхан тухайлбал бид нар ингээд махаа үнэд хүргэж зармаар байна, мах үнэгүй байна. Тэгээд толгой цувдай ингээд жалгаар ингээд хаягдаад байна. Улаанбаатар хот руу очихоор зардал нь тээврийн зардал нь 4 мянган төгрөг болчихоод байна. Гэтэл өөрийнх нь ингээд өртөг нь ингээд 1000 төгрөг буюу зах зээлийн үнэ нь 1000 төгрөг байна. Бид

нар яах юм, үүнийг чинь хаяхаас өөр яалтай билээ. Стандартын шаардлага хангасан мал нядалдаг газар үйлдвэр байхгүй байна. Тэрнээс чинь болоод ингээд арьсаа цоолоод байна, дахиад хаягдаад байна. Тэгэхээр энэ үйлдвэрүүдээ барьж болдоггүй юм уу даа Доржханд гишүүн ээ гэдэг ийм асуултуудыг маш их тавьж байна. Тэгвэл үүний боломж нь юу юм бэ? Энэ чинь кластер байхгүй юу. Тэр бүс нутгийн зах зээлийг үүсгэж, кластер байдлаар бид нар тэрэнд нь тохирсон арьс шир болон толгой цувдай янзлах, ангилах тийм жижигхэн цехүүдийг байгуулах боломж нь тэнд байхгүй юу. Гэтэл өнөөдрийг хүртэл бид нар 76 жижигхэн тойргийг усалж, үр дүнд нь Монгол Улсын төсөв байнгын алдагдалтай, улс маань байнгын өртэй, тэгээд цаашаа хөгжсэе гээд тэгэхээр хөгжих боломж байхгүй. Сумд байгаа иргэд нь аймгийн төв рүү шилжсэн, аймгийн төвийнх нь Улаанбаатар хот руу нүүсэн, Улаанбаатар хотынх нь гадагшаа явсан ийм л дүр зураг байна шүү дээ, энэ чинь.

Тэгвэл өнөөдөр бүгдээрээ үүнийгээ больё. Одоо ингээд очсон тойргоо ингээд төсвийн мөнгөөр угсардаг, угждаг, бэлэг тараадгаа больё. Одоо бүгдээрээ бүс нутгийн түвшинд зах зээлээ үүсгэе, хөгжсэе. Өөр өөрсдийнхөө намынхаа эрх ашгуудыг хажуу тийшээ тавьчихъя. Ардын нам ялах нь уу, АН ялах нь уу, Хүн нам ялах нь уу энэ бол 30 дугаар асуудал аа. Монгол Улс ялах хэрэгтэй байна. Монгол Улс ялах нь юунд хэрэгтэй байна аа гээд тэгэхээр энэ улсын тусгаар тогтнол, Монгол улсын ардчилал хэрэгтэй байгаа байхгүй юу. Тэгэхээр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг бодитойгоор цементлэх, бэхжүүлэх боломж нь юу байна гэхээр энэ бүс нутаг дээр тулгуурласан бүсэжсэн хөгжлийн бодлогоо бүгдээрээ амилуулъя, энэ тойргийнхоо зохион байгуулалтыг хийчихье гэж байгаа. Бүр томроосой гэж хүсэж байгаа юм.

ХҮН намын зүгээс 5 бүс байя. Улаанбаатар хотоос гадна.

Улаанбаатарыгаа нэг их бүс болгоё гэж санал оруулж байсан. Тэгээд ярьж байгаад өнөөдрийн дундын хувилбар аа гээд хүлээн зөвшөөрөөд явж байгаа юм. Тэгээд ийм болохоор өөрсдийнхөө эрх ашгийг татаарай. Улс орныхоо эрх ашгийг өмнөө тавиарай. Энэ улс чинь туйлдчихаад, хөгжих цаашаа алхах боломжгүй болчихоод байна шүү.

1 асуулт байна. Энэ сонгуулийн тойргийн төв чинь энэ хөгжлийн бүсийн тулгуур төвөөс ялгаатай байх аа, Энхболд дарга аа. Энэ дээр нэг ... /минут дуусав/

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хариулна.

Н.Энхболд: Өнөөдрийн тогтоолын төсөлд явж байгаа тойргийн төвүүд гэдэг бол зөвхөн сонгууль явахад ажлыг зохион байгуулахад Төв нь хаанаа байх юм бэ гэдэг л ийм л тойргийн төвийн л асуудал. Сонгуулийн тойргийн төвийн асуудал. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд туссан бүсүүдийн төв бол тусдаа асуудал. Үүнийг бид нар ер нь дахиж ярих хэрэгтэй, хэрэгтэй болно. Яагаад гэвэл хуучин 91 онд гарсан бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаар ерөнхийдөө тулгуур 8 төвтэй энэ тэр гэсэн бас үгнүүд байж байгаа. Тэгэхээр одоо бид нар нэгэнт Үндсэн хуульдаа өөрчлөлт оруулаад, сонгуулийн хуваарьдаа өөрчлөлт оруулаад ингээд явж байгаа бол А гээд хэлчихсэн бол В гэж хэлээд дараа нь В гээд дараагийн логик алхам нь тэгвэл одоо яг бүсчилсэн хөгжлийн төвүүд нь хаанаа байх юм бэ гэдгээ бид нар би дахиж ярих хэрэгтэй гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ 2 тусдаа асуудал шүү, тийм.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууна.

Т.Доржханд: Баярлалаа. Тэгэхээр би энэ Улсын Их Хурлыг улс орны шинэ чанартай реформ сайн хийж байгаа Улсын Их Хурал аа гэж ойлгож байгаа.

Одоо энэ дээр хатуу байх ёстой. Дахиад нэг зарчмаа хэлье. Энэ удаа АН ялна аа, эсвэл ХҮН нам ялна аа гэдэг асуудал биш ээ. Ардын нам ялна, ялагдана гэдэг асуудал биш. Одоо бүгдээрээ энэ амбицаа хойшоо тавиад улс орныхоо хөгжлийн төлөө ингээд хамтарч ажилладаг ийм платформыг угсрах боломж нь энэ гэж харж байгаа. Тэгээд ийм болохоороо өнөөдөр энэ шийдвэрийг гаргах нь энэ парламентын түүхэнд үлдэх шийдвэр шүү. Манай ХҮН намын гишүүд, удирдах зөвлөл 100 хувь үүнийг дэмжиж байгаа. Доржханд дарга аа, манай нам ялах ялагдах нь биш, үүнийг чинь 30 жил Монголын нийт эдийн засагчид хүсээж мөрөөдсөн юм шүү дээ. Энэ эдийн засгийг босгож ирье, үйлдвэржүүлье, бодит орлого өсгөе өө гэдэг чинь энэ улс орны эрх ашиг байгаа энэ дээр бүгдээрээ дэмжинэ шүү, та дэмжиж өгөөрэй гэсэн. Бид бол энэ дээр хав хатуу ... /минут дуусав/

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн алга байна.

Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэж байх хооронд 2 зүйл хэлье.

Бид Монгол Улс бол нэгдмэл улс аа. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улс унитарный буюу нэгдмэл 1 засаглалтай улс. Бид үндэстэн ястнаар хуваагдаж болохгүй ээ. Тэр тусмаа бид 3.5-хан сая хүн амтай, 2 том гүрний дунд оршдог улс. Тиймээс бид энэ Сонгуулийн тухай хууль дээрээ улсын нэгдсэн бодлого, нэгдмэл эрх ашгийг ярина уу гэхээс биш яс үндэс ярих нь туйлын буруу. Тиймээс Баян-Өлгий аймгийг салгаж нэг бүс болгож байгаа юм шиг буруу ярьж болохгүй ээ. Баян-Өлгий аймаг харин ч бүсчилсэн интеграцлалд орж, бүс нутгийнхаа хөгжлийн том бодлогод хамрагдаж явах ёстой. Тэгж байж бид бүс нутгийн, цаашилаад улсын хөгжил ярина. Ястан, үндэстэн гэж ярих

нь туйлын буруу. Бид цөөхөн хүн амтай, асар удам нутаг дэвсгэртэй Монгол Улсын иргэд. Хүний эрхийг дээдэлсэн улс. Цөөнхийн эрхийг дээдэлсэн улс. Бид 48 гишүүнийг жагсаалтад оруулж байгаа. Жагсаалтад иргэдийн төлөөлөл бүрээс үндэстэн, ястан бүрийн төлөөлөл бүр орох ёстой. Ийм боломжууд байгаа. Ийм учраас Улсын Их Хурлын гишүүд та бүхнийг сонгуулийн тойргийн асуудалд бид нэг Монгол гэдэг үгийг санаж, ул суурьтай хандаасай гэж хүсэж байна. Ийм ч агуулгаар Улсын Их Хурлын тогтоолд 3 дугаар заалтыг нэмж оруулсан байгаа. Ингээж зөрчил хагарлыг дэврэх гэсэн үзэл санаагаар үндэсний аюулгүй байдалд харш үг хэллэгийг хэрэглэж болохгүй гэдгийг сануулъя.

2 дугаарт, энэ бол нэг намын, хувь хүний эрх ашгийг биш улс орны хөгжлийн том бодлогыг бодсон тийм үзэл баримтлал, бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтай маш том шинэчлэлийг бас хийж байна гэж ойлгох ёстой. Ийм учраас бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг бид яаралтай оруулж ирж, шинэчлэн хөгжүүлэх ёстой. Үүний дагуу энэ сонгуулийн тогтолцоог баталж чадахгүй байсан нөгөө хар машин байхгүй, тоолж чадахгүй байсантай холбоотой юм байна лээ. 2000-аад оны үед үүнийг бас ярьсан юм байна лээ. Бүсчилсэн тойрог явуулъя гэж. Даанч санал хураадаг механизм машин байхгүй. Яаж тоолох нь тодорхойгүй энэ 9, 10 хүнийг яаж өрсөлдүүлэх юм 40, 50 хүнийг гэж ингээж ярьж байгаад тооллого будилаантай гээд ингээд хойшилж байсан түүхтэй.

Одоо Улаанбаатар улс болчихоод байна шүү дээ, үндэсний аюулгүй байдлын хувьд ч гэсэн. Манай 1,5 сая км хавтгай дөрвөлжин нутагт хүн ам маань сийрэг суурьшиж, дэлхий дээр хамгийн хүн ам суурьшсан хоцрогдсон улс болох гээд байна. Ийм учраас бүсчилсэн хөгжлийн үзлэгийн бодлогоор Дархан Сэлэнгийн районд Дархан хот, Хөвсгөл, Булган, Эрдэнэтийн районд Орхон хот, Баруун бүсийн тулгуур төв хот Ховд

хот, говийн бүсийн тулгуур төв хот Даланзадгад Сайншанд хот, Аж үйлдвэрийн парк болно уу. Зүүн төв, аялал жуулчлалын Чингис хот гэдэг гэх мэтчилэн энэ бүс нутгийн хөгжлийн төв, хотууд бий болж байж энэ 30 жилийн алдааг засна.

90 онд орон нутгийн чанартай хотууд гээд Арвайхээр хот, Улаангом хот гээд энэ бүх хотууд байсан. Энэ 30 жилийн гажуудлаар Дархан, Сэлэнгийн районд Дархан гэж аж үйлдвэрийн хот байгуулсныг Дархан-Уул аймаг болгочихсон. Орхон аймаг болгочихсон Эрдэнэт хотыг. Ингээд нэг аймаг, хот 2-ын завсар эрлийз ийм дэлхийд байхгүй жишиг явуулж ирсэн. Үүнийг засаж байна шүү дээ, үүгээрээ. Ийм учраас энэ бүс нутгийн интегралчлал хөгжлийн том бодлогын эхлэлийг үүнийг тавьж байгаа. Улс орны эрх ашгийн төлөө ямар нэгэн нам улсын эрх ашгаа намын эрх ашгаас илүү дээгүүр тавьж ийм шийдвэр гаргаж байна гэж ойлгож энэ хөгжлийн бодлого, төлөвлөлтөө бид нар шинэ шатанд гаргаж байна. Өөрөөр хэлбэл улс төрийн эрх мэдлийг эдийн засгийн эрх мэдэл 2 хамааралтай учраас. Баруун бүсийн мужийн захирагч гэж томилох ёстой, бүсчилсэн хөгжлийн бодлогоор бол. Мужийн захирагч нэгдмэл улсын бодлогыг хангасан Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч байна. Баруун 5 аймгийг бүсийн захирагч. Хуучин аймгийн нэг даргын томилчихдог буруу юм байна лээ. Энэ Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч, сайдын рангтай хүн байх ёстой. Баруун 5 аймгийн хөгжлийн нэгдсэн бодлогыг хангана. Нэгдмэл улсын нэг Засгийн газрын бодлогыг хэрэгжүүлнэ. Зүүн бүсийн захирагч, говийн бүсийн захирагч бөгөөд Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч. Тэгээд үүнтэйгээ нийцүүлээд энэ орон зай, геодези, зураг зүйн төлөвлөлт хийж, бүс нутгийн хөгжлийн бодлогууд, хот төлөвлөлтийн бодлогыг шинэ шатанд гаргана. Дархан, Эрдэнэт, Ховд гэх мэтчилэн энэ хотууд маань улсын чанартай хот болж хөгжинө.

4 жилийн дараа Улаанбаатар хотын түгжэрэл байхгүй болчихсон байх ёстой. Төвлөрөл саарчихсан байх ёстой. Аялал жуулчлал, аж үйлдвэр хөдөө аж ахуйн хот Эрдэнэт хот бол шинэ бүсийн төв болж хөгжих хэрэгтэй, алтан гурвалжин гэж нэрлэж байдаг. Дархан хот энэ босоо тэнхлэгийг холбосон Орос, Хятадыг холбосон замтай холбоотой том хөгжлийн төв болох бололцоотой. Баруун босоо төмөр зам авто зам баригдаж Завхан, Говь-Алтай, Ховд хотуудын хөгжлийн нэгдсэн бодлого гаргах хэрэгтэй. Ингэж том зургаар харж байж бид хөгжинө. Зүүн босоо чингэлгийн зам Дорнод, Сүхбаатар. Ингэж дэд бүтцийн хөгжлийн төлөвлөлт маань ч гэсэн том зургаар харж одоо нэг жалга дов нэг нам гэсэн, нэг цонх жижижгхэн хагархай цонхоор хардаг биш улсаа том хөгжлийн бодлогоор харж байж, бид нар ерөөсөө том хөгжлийн урагшаа алхах ийм том боломжийг Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт олгосон. Ийм учраас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө хэрэгжүүлж, улсын реформын цоо шинэ бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор улс төрийн намуудын дарга нар нэгдэж, санамж бичиг гарын үсэг зурж, нэг Монгол нийтлэг эрх ашгийн төлөө энэ шийдвэрийг гаргаж байгаа гэдгийг бид гүнээ ойлговол зохино.

Ингээд зочид танилцуулъя.

Монгол Улсын Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хүндэт харуулын ротын хугацаат цэргийн албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Үндсэн хуулиар хүлээсэн хүндэт үүргээ биелүүлж, эр цэргийн алба хааж байгаа эрхэм хүндэт дайчид та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. Баяр хүргэе.

Ингээд Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг

дэвсгэр, төвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулна. Санал хураалт.

72,3 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн үү? Алга байна. Эцсийн найруулга уншсанд тооцлоо.

Энэ Улсын Их Хурлын тогтоол батлагдсанаараа сонгуулийн тойрог, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоосноороо Монгол Улсын улс төрийн шинэчлэлийн төдийгүй бүсчилсэн хөгжил, эдийн засгийн хөгжлийн шинэ эрин үе ирж байна аа гэж байна. Үүний төлөө бас бүгдээрээ хамтран ажиллаж, их амжилт гаргахыг хүсэн ерөөе.

12.23 цаг

Дараагийн асуудал орно.

“Монгол Улсын Их Хурлын оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмаа танилцуулна.

Б.Жаргалмаа: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа дээрх саналыг хэлэлцээд дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт Улсын Их Хурал ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 02 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө товлон зарлаж санал авах өдрийг тогтооно гэж заасны дагуу ээлжит сонгуулийг 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэхээр товлон зарлах, мөн зүйлийн 9.2 дахь хэсэгт ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 6 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна гэж заасны дагуу ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2024 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байхаар тусгалаа.

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь хэсэгт гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрийг сонгуулийн төв байгууллагын саналыг үндэслэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал авах өдөр нь 4 хүртэл өдөр байна гэж заасны дагуу Сонгуулийн ерөнхий хорооноос 2023 оны 12 дугаар сарын 13-ны өдөр ирүүлсэн саналыг үндэслэн гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрийг 2024 оны 06 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүд байхаар тогтоолын төсөлд тус тус тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Занданшатар Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах өдөр болон гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдрүүд хоорондоо уялдах эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Доржханд Гадаад улсад байгаа иргэдийн нөхцөл байдлыг харгалзан санал авах өдөр болон цагийг уртасгах боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Батсуурь бүсчилсэн тойрог бүхий пропорциональ тогтолцоогоор зохион байгуулагдаж байгаа анхны сонгууль тул техникийн болон тогтоолын төсөлд заасан хугацаанд зохион байгуулах боломжтой эсэх мөн гадаад улсад ямар хэлбэрээр

иргэд санал өгөх талаар, Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж нэр дэвшигчдийн нэрс саналын хуудаст хэрхэн бичигдэх мөн сонгуулийн санал авах өдөр Баасан гараг байх нь сонгуулийн ирцэд нөлөөлөх эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дээрх тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг товлон зарлах, санал авах өдрийн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя.

Өмнөх ажлын хэсэгтэй овог нэр, ажил, албан тушаал нэг адил бүгд байна. Протоколд тэгж тэмдэглэе. Дагвадоржийн Дэлгэрсайхан, Пүрэвэгийн Дэлгэрнаран, Дугардоржийн Баяндүүрэн, Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ, Алтанцэцэгийн Банзрагчдорж нар бүгд байж байгаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу? Алга байна. Бөхчулууны Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Цэвэгдоржийн Туваан гишүүнээр тасаллаа. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр сонгуулийг бүтэн сайн өдөр голцуу явдаг байж байгаад сүүлийн хэд хэдэн сонгуулийг дандаа 3 дахь өдөр явуулж байгаа. Тийм, 3 дахь өдөр явуулдгийн гол ач холбогдол бол сонгуулийн ирцийг өндөр болгох тухай л асуудал байгаад байгаа

юм. Тэгээд өнөөдрийн энэ тогтоолын төслөөр орж ирж байгаа энэ өдөр бол 28-ны 5 дахь өдөр байгаа. Энэ тохиолдолд яах вэ гэхээр 4 дэх өдрийн орой ажлаа тарчхаад олон хүмүүс хөдөө ухасхийгээд 3 өдөр амрах юм байна. Аав, ээж дээрээ очоод ирье, аль эсвэл амралт зугаалгын газар явъя гээд ингээд ирц их муудах ийм нөхцөл байдал руу энэ сонгуулийн өдөр чинь товлогдоод байна. Тэгээд яг энэ өдөр дээр жишээ нь ХҮН намынхан яагаад ингэж дэмжээд явсан юм. Би ерөөсөө ойлгохгүй байгаа л даа. Баахан гарын үсэг зурцгаасан гэсэн.

Ер нь бол энэ залуучуудыг сонгуульд оролцуулж, энэ нийгмийн идэвхийг илүү сайн болгох нь энэ Монголын ирээдүйг илүү гэрэл гэгээтэй болгоно гэдэг ийм л байх ёстой. Тэгэхээр ер нь энэ сонгуулийн өдөр энэ товлосон өдөр чинь бидний зориод байгаа өөрөөр хэлбэл 4 жилд нэг тохиол олдож байгаа бас Улсын Их Хурлын сонгуулийг сонгох тэр эрхийг нь эдлүүлэх энэ л гол зорилготой. Тэгээд дээрээс нь энэ сонгуульдаа оролцсоноор өөрсдийнхөө бүтээсэн тэр засаглалыг ямар шатад байх вэ гэдгийг л харж хянах ийм л гол агуулгатай л гэж үзээд байгаа юм л даа.

Тийм учраас энэ өдрийг яагаад ингэж 5 дахь өдрөөр тавьж байгаа юм бэ?

Тэгээд 2 дугаарт нь, ер нь хагас сайн, бүтэн сайны өдөр, 3 дахь өдөр жишээ нь сонгууль боллоо гэхэд 5 дахь, хагас сайн, бүтэн сайн, нэг дэх өдөр нь гадаадад сонгууль өгч байгаа тэр хүмүүсийн сонгуулийг авах боломжтой. Өөрөөр хэлбэл тэр хэтэрхий урагшаа явах юм бол сонгуулийн тэр гадаадад өгч байгаа сонгуулийн санал дээр үндэслээд бас анализ хийгээд, янз янзын нөхцөл байдал үүсэх ийм нөхцөл бүрдэнэ гэж үзээд байгаа юм. Тэгэхээр аль болох тулгаад 4 дэх, 5 дахь, хагас сайн, 5 дахь, хагас сайн, бүтэн сайн, 1 дэхэд нь гадаадад амьдарч байгаа иргэдээс санал аваад, 3 дахь өдөр нь Монголд орон даяар

сонгуулиа авах нь илүү зөв зүйтэй л гэж үзээд байгаа юм.

Тэгээд энэ дээр яагаад ийм өдрийг сонгосон юм бэ? Тэгээд энэ намын дарга нар энэ өдөр дээрээ тохирч гарын үсэг энэ тэрээ зуралцсан юм уу. Тэгээд энэ өдрийн асуудал тэгээд өнөөдөр бид нар ингээд дөнгөж Их Хурлын гишүүд мэдэж байгаа. Ийм байдлаар хэдхэн хүн асуудлаа шийдээд, ингээд явчхаж байгаа юм уу? Өөрсдийнхөө өдөр сударт тааруулаад би ялбал ямар өдөр байх нь гэж тааруулсан юм уу яасан юм? Би ерөөсөө ойлгохгүй байна. Үүнийг нэг тайлбарлаж өгөөч.

Г.Занданшатар: Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Нямаагийн Энхболд гишүүн.

Н.Энхболд: Гадаадад сууж байгаа иргэдээс санал авах өдрийн хувьд техникийн бололцоо, тэнд санал хураачхаад нааш нь ирүүлэх хугацаа гэх мэтчилэн зүйлүүдийг тооцож үзээд, үзсэн гэж би бодож байна. Тэгээд Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналын дагуу одоогоор тавиад явж байгаа. 22, 23-ны өдрүүд нь хагас сайн бүтэн сайн өдөр байгаа. Энэ өдөр бас хүмүүс ирж саналаа өгөх бололцоог нь бас ямар ч тохиолдолд 22, гурванаа оруулъя гээд тэнд ажил хийж байгаа хүмүүс саналаа өгөх бололцоог нь хангаж өгч оруулсан байгаа гэдгийг хэлье.

Гадаадаас ирээд санал авах өдөр хүртэл тэр саналууд задрахгүй шүү дээ. Пүүжээ гишүүн ээ, битүүмжлэлтэй хэвээрээ байна. Тийм ээ, Дэлгэрнараран дарга аа. Яг санал аваад эхэлсэн 28 байна уу, хэдэн өдөр байна, тэр өдрөө л тоолж эхэлнэ. Түүнээс урьдчилаад дүнг нь гаргачхаад гадаадад байгаа Монголчууд ийм хандлагатай, ийм санал ирүүлсэн байна гэдэг тухай асуу яригдахгүй. Энэ нь хуулиараа хориотой. 1 өдөр бүх юмаа задалдаг ийм учиртай.

28-ны өдрийг би түрүүчийн тогтоол ярихад ярьсан. Үүнийг олон

талаас нь, тал талаас нь, намын удирдлагууд, Их Хурлын удирдлагууд бүгдээрээ л тал талаас нь ярьж байгаад л шийдээд л санал болгосон өдөр нь манай Байнгын хороон дээр орж ирээд олонхын санал аваад дэмжигдээд орж ирсэн гэдгийг л хэлэх байна даа.

Г.Занданшатар: Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Би Пүрэвдорж гишүүний саналыг дэмжиж байгаа юм. Энэ уламжлал ер нь сүүлийн сонгуулиуд дандаа Лхагва гарагт явагдсан. Энэ дээр Их Хурлын дарга ч гэсэн ер нь та бас анхаараад үүнийг тэр 1 саяын Пүрэвдорж гишүүний гаргасан саналаар буюу тэр Лхагва гараг гэдэг рүү нь гарах ямар гарц байна? Одоо хэдүүлээ энэ бодлого юм ярихаараа ингээд Монгол Улсын эрх ашиг, бүсчилсэн хөгжил энэ тэр гээд бас том концепцын юман дээрээ ойлголцоод, тойрог хуваагдаад ингээд явчихсан. Тэгээд энэ санал авах өдөр энэ тэр чинь бас л амьдралаас урган гарсан ийм санал шүү дээ. Мэдээж зуны улирал болчихсон. Бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Наадам дөхчихсөн, морь малын сунгаа гээд ингээд хөдөө орон нутагт энэ тэр асуудал болоод ингээд амралтын маягийн сезон руу орчихдог. Тэгэхээр сонгуулийн ирц буурах вий, энэ зохицуулалт буруу хийгдсэнээс болж энэ иргэдийн санал өгөх хувь унах вий гэдэг ийм л асуудал шүү дээ. Тэгэхээр үүнийг хэдүүлээ Их Хурал дээр яриад Их Хурлын дарга бас онцгой анхааралдаа аваад үүнийг яаж зохицуулж болохоор байна. Энэ чинь өөрөө Их Хурлын тогтоол учраас маш чухал асуудал мөртөө ингээд тогтоолоор ямар нэгэн анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг байхгүйгээр ингээд явчихаад байна шүү дээ.

Өчигдөр Байнгын хороон дээр саналууд гарсан. Тэгээд тэр санал тэгээд нийт том юман дотроо ороод живээд ингээд л явчихаж байна лээ шүү дээ. Тэгэхээр энэ дээр би эргүүлээд тэр ярилцах одоо шийдэхээс өмнө бас нэг

ярилцаад гаргалгаа гаргамаар байна гэж ингэж бодож байна. 06 сарын 26-ны өдрийн Лхагва гарагт хураагаад, санал хураалтаа явуулчихвал тохиромжтой шүү гэж ингэж бодож байна.

2 дугаарт, энэ ажлын хэсгээс боломж олдсон дээр энэ хуульд бид нар оруулж өгсөн. Сонгогчдын нэрсийн нэгдсэн жагсаалтаас нэр шүүнэ. Нэр гаргаж ирнэ гээд. Энэ дээр бид нар бас нэлээн хуулийн заалт болгож, оруулж өгсөн. Техникийн боломж талаас нь санхүүжилтийн асуудлыг нь улсын төсвүүд дээр шийдэж өгсөн. Тэгээд энэ дээр янз бүрийн яриа байхгүй биз. Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэл. Бүртгэлийнхэн чинь ер нь тэгээд бас л будилаантай шүү дээ. Та хэд. Өөрсдийнхөө дураар асуудалд ханддаг, улс төржсөн өнцгөөр асуудалд ханддаг. Тэгэхээр энэ дээр тэр хуулийн зүйл, заалт хэрэгжүүлэхэд одоо ямар нэгэн асуудал байхгүй гэдгийг энэ микрофонд би хэлүүлмээр байна.

Сонгогчдын нэрсийн жагсаалт дэд хороо гээд нэг байгууллага байгаа. Батсуурь гишүүн үүнийг ахалж байгаа. Ингээд ганц дэд хороогоор асуудал шийдмээргүй байна. Өчигдөр бас Их Хурлын дарга Байнгын хорооны хурал дээр хэлж харагдана лээ. Энд ажлын хэсэг юм уу эс үгүй бол тэр бүрэн эрхтэй ямар нэгэн тэр энэ бүртгэлийн программыг нь шалгачихдаг, сонгогчдын нэрсийн жагсаалтыг тулгаад шалгачихдаг, бүр томилогдоод бас тэр нэг хариуцлага хүлээгээд тэр цалин байдаг юм уу, юу байдаг юм хумаа аваад ингээд ажиллах нэг хүмүүс хэрэгтэй байна. Ганц энэ дэд хороогоор очдог, нөгөөдүүл нь доор хаанаасаа хаалгач гэж хүмүүс чинь нууц яриад ингээд энэ бүртгэл рүү оруулахгүй ээ.

Тэгэхээр энэ дээр нэгэнтээ л бас сонгуулийг зөв шударга, хар сэргүй, бүрэн итгэлцэл дунд ингээд зөвшилцөл дунд явуулах гэж байгаа юм бол энэ бүртгэлийн асуудал дээр ер нь ямар гаргалгаа гаргаж байна аа? Тэр дэд

хороог яаж ажиллах нөхцөлөөр хангах гэж байна, яаж туслах гэж байна аа гэсэн ийм асуултыг асууя.

Эцэст нь тэр Байнгын хорооны дарга, Энхболд дарга, Их Хурлын дарга, өшөө энэ намуудын дарга нар энэ тэр бас нэг ярилцаад энэ Лхагва гараг гэдэг дээр нэг гаргалгаа гаргаадхаач гэж ... /минут дуусав/

Г.Занданшатар: Нямаагийн Энхболд дарга Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга хариулъя.

Н.Энхболд: Би тэр Туваан гишүүн ээ, нөгөө бүртгэлтэй холбоотой асуултад нь би хариулчихъя. Нөгөөдхийг нь та дарга руу хандаад хэлчих шиг боллоо. Ер нь сонгогчдын нэрсийн бүртгэлд хяналт тавих үйл ажиллагаа эрхлэх тийм Улсын Их Хурлын дэд хороо байгаа. Батсуурь гишүүн ахалж байгаа. Өчигдөр Байнгын хороон дээр бас энэ талаар нэлээн яригдсан. Энэ тогтоолууд ингээд албан ёсоор баталгаажсаны дараа үндсэндээ сонгогчдын нэрсийн жагсаалттай холбоотой асуудлуудыг нарийн ярьж эхэлнэ. Ер нь тийм байдаг юм. Тогтоолоо батлагдсаны дараа ажилдаа ордог.

Тэгээд ер нь дэд хороо бол цөөхөн хүнтэй л дээ. Өөрснөө тэр ажлыг дангаараа хийхгүй, ойлгомжтой. Урьд өмнөх туршлагаар ч гэсэн бид нар тогтоолууд батлагдсаны дараа ажлын хэсэг байгуулж өгөөд, түүнд нь холбогдох мэргэжлийн хүмүүс оруулаад, дээр нь Улсын Их Хурлын Тамгын газар, бүртгэлийн газрынхан туслалцаад нэлээн том ажлын хэсэг болж ажилладаг. Энэ журмаараа явна. Шаардлагатай гэж үзвэл би Сонгуулийн ерөнхий хорооноос ч гэсэн сонгууль явах зардлаас тодорхой хэсгийг нь гаргаад саяын гишүүдийн тавьж байгаа нэгэнт л тэр хүмүүсийг хариуцлагатай ажиллуулах гэж байгаа юм чинь зүгээр чи ажилла гээд шахаад байхгүй. Бас нэг юу гэдэг юм урамшуулал цалин ч байдаг юм уу тэр талыг маань би зохицуулчхаж болох болов уу гэж

бодож байна. Хуулиар лав хориглосон зүйл байхгүй. Тэгээд энэ чухал асуудал аа, үүнийг хийж болно. Хийх ёстой, хийнэ гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Горимын санал ч яах вэ, тэгээд л ер нь сонгуулийн сурталчилгаа хаах өдөр нь л хамгийн гол өдөр шүү дээ. 3 дахь өдөр тэгээд л хаагдаж байвал.

Би Төрийн байгуулалтын байнгын хороо дээр яриад, ярьж ярьж байгаад тэгээд шийдчихсэн. Одоо ингээд санал болсон.

Саналаа хураалт явуулъя. Горимын санал гэж байхгүй.

Төрийн ажилд бүх өдөр сайн. Төрийн ажил бүх өдөр сайн. Муу өдөр муу гэж байхгүй. Тодруулах юм байхгүй.

Туваан гишүүн сая асуулт асуусан, 1 минут тодруулж болно. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Гаргалгаа байгаа. Одоо энэ дээр хэдүүлээ гаргалгаагаа яриад тэр энэ чинь амьдралаас урган гарсан санал шүү дээ. Ганц Туваан, Пүрэвдорж хэлээд байгаа юм биш шүү дээ. 3 өдөр дараалаад амраад ирц чинь унаад бүр сонгуулийн ирц хүрэхгүй бол яах юм. Ирцийг өндөр болгоё гээд идэвхжүүлэлт энэ тэр хийгээд явдаг шүү дээ. Тэгээд тэрний чинь нэг арга хэрэгсэл гэж бодоод үүнийг бас ярилцсан нь зөв байх. Одоо манайх болохгүй бол энэ дээр завсарлага авдаг юм уу. Тэгж байгаад энэ асуудлаа ярилцъя. Тэгэхгүй бол ингээд нэг Үндсэн хууль энэ тойрог гээд л ингээд л явж явж ирчхээд нэг ийм асуудал дээр гацаад хэрэггүй байх.

2 дугаарт, тэр ажлын хэсэг саяын тэр миний сонгогчдын нэгдсэн жагсаалтаас гэдэг юм дээр хариул л даа. Одоо тэгээд дараа нь бид нарт мөнгө байхгүй, техник дутуу, сүлжээ байсангүй энэ тэр гээд юм яриад унах вий. Тэрийг

нь би бас амаар нь протоколд сонсмоор байна.

Г.Занданшатар: Энхболд дарга хариулах уу? Тодруулгад. 82 Дэлгэрнаран дарга Пүрэвээгийн Дэлгэрнаран дарга.

П.Дэлгэрнаран: Туваан гишүүний асуултад хариулъя. 23 оны улсын төсвийн тодотголоор манайд санал тоолох төхөөрөмжийг нөхөж бүрдүүлэх, түүний дагалдах хэрэгслүүдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхээр тодорхой хэмжээний эх үүсвэр шийдэж өгсөн. Тэр шийдэж өгсөн эх үүсвэрийг бид нар ашиглаж, худалдан авалтыг хийж хуулийн дагуу, нөхөн бүрдүүлэлтийг хийсэн. Одоо бид бүх техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүдээ худалдан авч дуусаад, өөрийнхөө склад саванд байршуулсан. Одоо хяналт хийх, баталгаажуулах ийм ажил явагдаж байгаа.

Тэгэхээр бид нар 24 оны сонгуульд тойргийг ийм байдлаар зохион байгуулах, тэгээд хэсгийн хороодын тоо нэмэгдэх, нийт сонгогчдын тоо нэмэгдэх гээд бүх хүчин зүйлүүдийг тооцсон. Тэгээд энэ асуудал дээр бол ... /минут дуусав/

Г.Занданшатар: 84 Дэлгэрсайхан улсын бүртгэлийн дарга.

УБЕГ-ын дарга Дэлгэрсайхан Туваан гишүүний асуултад хариулъя. Энэ сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулга хүргүүлэх хуулиар хүлээсэн чиг үүрэг улсын бүртгэлийн байгууллагад байдаг. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт, онцлог зохицуулалт дээр би 3 зүйл хэлмээр байна.

1 дүгээрх нь, таны яг асууж байгаа энэ сонгогчдын нэрийн жагсаалтын ил тод байдал, хяналттай холбоотойгоор 20.21-д бүр маш тодорхой заалт орсон байгаа. Энэ юу вэ гэхээр Сонгуулийн ерөнхий хороонд бүртгүүлсэн нам, эвсэл, бие даагч, ТББ

сонгуулийн нэрийн жагсаалтыг үйлдэх энэ процесстэй танилцах эрхтэй байгаа. Өөрөөр хэлбэл сонгуулийн нэрийн жагсаалтыг ганц үйлдэх, танилцуулах, хүргүүлэх гэдэг маань өөрөө одоо энэ оноос, энэ оны энэ сараас эхлээд сонгуулийн санал авах өдөр хүртэлх томоохон процесс байдаг. Ийм учраас энэ дээр бид нар ганцхан улсын бүртгэлийн байгуул ... /минут дуусав/

Г.Занданшатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн.

Би саяын саналтай холбогдуулаад энэ Батсуурь гишүүн Төрийн байгуулалтын байнгын хороо дээр бас энэ асуудлыг хөндсөн юм. Би ч гэсэн хөндсөн, ярьсан. Энэ бүртгэлтэй холбоотой асуудлыг. Тэгэхээр Бүртгэлийн дэд хорооны дарга Жамбын Батсуурь гишүүн байна шүү дээ. Тогтоолын төсөл боловсруулаад Байнгын хорооныхоо Улсын Их Хурлын тогтоолын ажлын хэсэг, ажлын алба нөгөө юмаа тусгаад тэгээд Байнгын хороонд ТББХ-гоор хэлэлцүүлээд шийдье гэж би Нямаагийн Энхболд даргатай ярьсан. Та төслөө боловсруулах хэрэгтэй байна. Байнгын хороогоор шийдэж болж байвал Байнгын хороогоор шийдчихье. Байнгын хороогоор шийдэхээргүй бол Улсын Их Хурлын тогтоолоор шийдчихье. Бүртгэлтэй холбоотой асуудлыг.

Сая тэр Дэлгэрсайхан, Дэлгэрнаран 2 дарга тэр улсын бүртгэлтэй холбоотой асуудлуудыг туслаад, Батсуурь даргатай гараад тогтоолын төсөл боловсруулчих. Сонгууль ямарваа нэгэн хэл ам, хэрүүл тэмцэл, маргаангүй болгохын тулд бүртгэлийн асуудлыг цэгцлэхтэй холбоотой асуудлыг хаяг, адрес гээд зөндөө асуудал байдаг шүү дээ. Тэгэхээр дэд хорооны даргын хувьд түүнийг тэгж тохиръё. Их Хурлаар гээд тохиръё. Тэгээд та 2 Их Хурлын тогтоолын төсөл, бүртгэлээ. Ер нь хар машин энэ тэр дээр баараггүй гэдгээ манай Пүрэвдорж гишүүн, Батсуурь гишүүн,

бусад гишүүд ч гэсэн хэлчихсэн. Тэгэхдээ түүнийхээ хяналтыг ч гэсэн давхар хяналтын тооллого. Хамгийн гол нь сонгууль будилаангүй явуулах тэр нөхцөлийг хангахдаа л чиглэсэн тийм явж байна. Шударга явуулах хэрэгтэй гэж.

Өдөр, судрын хувьд тэгээд намын удирдлагууд тохирсон юм байна гээд би бас энэ асуудлуудыг өчигдөр бид нар ярьсан. Тэгээд өөр юу байна.

Одонгийн Цогтгэрэл гишүүн.

О.Цогтгэрэл: Энэ 2020-24 оны парламентын ингээд чуулга бүрэн эрх ер нь өндөрлөх тийшээ 8 чуулганы 7 дахь нь төгсгөл рүүгээ ингээд явж байна л даа. Энэ хооронд мэдээж олон ч хууль батлагдсан байх. Энэ дундаас онцгой чухал асуудлууд бол энэ Үндсэн хуулийн өөрчлөлт, дагаад сонгуулийн хуулийн өөрчлөлт, тэр тусмаа энэ бүс бүсчлэлтэй цаг хугацаатай холбоотой тогтоолын төсөл гэдгийг бүгдээрээ л бас зөвшөөрч байгаа. Харьцангуй энэ том өөрчлөлтүүд дээр бүхий л нам бүлгүүд, Их Хурлын гишүүд, ер нь харьцангуйгаар бас улс орны эрх ашиг гэдэг талдаа бүгдээрээ бас ойлголцож зөвшилцөж, бас том том алхмуудыг бас хийж ирсэн.

Мэдээж шинэ зам учраас үүнийг сайн муугийн тухай ярихад эрт. Тэгэхдээ ямар ч байсан итгэл үнэмшлийн хувьд энэ улс орны эрх ашиг юм аа гээд өнгөрсөн хугацаанд энэ олон өөрчлөлтүүдийг ингээд ярилцаад ирсэн. Эдгээрийн нэг чухал асуудал нь энэ өнгөрсөн тогтолцоо санал гээгддэг ээ. Өнгөрсөн нь манайд мажоритар тогтолцоо санал гээгддэг нэг дутуу талтай учраас мажоритар тогтолцоо, холимог тогтолцоо гэдэг олон зүйлүүдийг бас оруулсан. Тэгэхээр бас яг түүнтэй холбоотой нэг заалт хэдийгээр жижиг асуудал юм шиг мөртөө сонгуулийн санал хураах өдөр өөрөө иргэдийн оролцоо, тэр санал гээгдэх асуудалд ирц бага байх асуудалд нөлөөлөх вий гэдэг дээр манай АН-ын бүлгийн гишүүд бас их санаа зовниж, 5

дахь өдөр байх нь өөрөө олон хоногийн амралтын үеийг дамжуулж байгаа учраас иргэд тэр тусмаа залуучуудын оролцоо бас бага байна гэдэг дээр ингээд санаа зовниж байр суурь илэрхийлж байна лээ.

Тийм учраас энэ асуудал дээр яг энэ асуудал дээр энэ сонгуулийг товлох асуудал дээр АН-ын бүлгээс ажлын 3 хоногийн завсарлага авъя. Үүнийг бас дахин нэлээн цаг хугацаа бид нарт хангалттай бий. Нэгэнт бүсчлэлийн тогтоол батлагдсан. Зөвхөн товын асуудлыг эргэж нухацтай сайн ярилцах ийм хүсэлтэй байна. Их Хурлын даргыг дэгийн хуулийн хүрээнд завсарлага өгөхийг хүсэж байна.

Г.Занданшатар: Энэ чинь хугацаатай асуудал тийм ээ. Тэгээд ярилцаагай. 1 хоногийн завсарлага өглөө. Ахиад сунгаж болно. 1. Маргааш өглөө, маргааш хүртэл. Өнөөдөр сайн ярьцаа. Тэгээд.

12.47 цаг

Дараагийн асуудалд оръё.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Амгалангийн Адьяасүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

А.Адьяасүрэн: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.4 дэх хэсэгт заасны дагуу Төрийн байгуулалтын байнгын хороо “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулж, 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн

хуралдаанаараа дээрх тогтоолын төслийг хэлэлцээд, дараах санал, дүгнэлт, Улсын Их Хурлын тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулж байна.

Тогтоолын төслийг боловсруулахдаа Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д заасны дагуу Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник хэрэгслийг санал авах, тоолох, дүн гаргах үйл ажиллагаанд “New Image Cast” санал тоолох төхөөрөмжийг тус тус хэрэглэхийг зөвшөөрөхөөр тусгасан болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь саналын хуудаст бичигдэх нэр дэвшигч, нам, эвслийн дараалал, хэлбэр болон “New Image Cast” санал тоолох төхөөрөмжид тавигдах хяналтын талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж санал авах төхөөрөмжтэй холбоотой төсвийн тодотголоо батлагдсан санхүүжилтээр хийгдэхээр төлөвлөгдсөн ажлуудын талаар, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд сонгуульд саналаа цахим хэлбэрээр өгөх, мөн саналын хуудсыг хүчингүй болгохоос сэргийлж саналын хуудсыг газар дээр нь хянах боломжтой эсэх асуудлаар асуулт асууж, хариулт авсан болно.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж санал тоолох төхөөрөмжийн дүн болон гар тооллогын дүн зөрдөггүй талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь саналын хуудасны хүчинтэй байдалд анхаарах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн техникийн зохион байгуулалтад анхаарах, мөн хүн ам ихтэй тойргуудад сонгуулийн хэсгийн хороодын тоог нэмэгдүүлэх, сонгуульд оролцох иргэдийг мэдээллээр сайн хангах талаар тус тус саналаа илэрхийлсэн болно.

“Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтгэйгээр дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулах нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданиатар: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэлийн урилгаар Хан-Уул дүүргийн хороодын Засаг дарга нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хороодын Засаг дарга нарт ажлын өндөр амжилт гишүүдийн нэрийн өмнөөс хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн гишүүд. Ажлын хэсгийн гишүүд өмнөх тогтоолын төслийн ажлын хэсэгтэй нэр овог, ажил, албан тушаал нэг мөн адил байна. Протоколд тэгж тэмдэглэсүгэй.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд байна уу? Наянтайн Ганибал гишүүнээр тасаллаа. Цагаанхүүгийн Идэрбат, Жамбын Батсуурь гишүүн. Жамбын Батсуурь, Бөхчулууны Пүрэвдорж гишүүдээр тасаллаа.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Сонгуулийн энэ томсгосон, бүсчилсэн тойрог эд нар бас улс орноо бодсон зөв бодлого оо л гэж

ингээж бас бодож байгаа, дэмжиж байгаа. Сонгууль будилаангүй явах, сонгуулийн дүнг улс төрийн намууд, сонгогчид хүлээн зөвшөөрөхөд гол хүчин зүйл бол энэ сонгуулийн санал хураалтыг тоолох тоног төхөөрөмжийн асуудал байгаа. Энэ дээр “New Image Cast” гээд ийм санал тоолох төхөөрөмж ашиглаж байгаа талаар бас дурдсан байна. Тэгэхээр энэ маань нөгөө бидний ашиглаж байсан энэ төхөөрөмж байна уу, өөр төхөөрөмж байна уу. Доторх программ хангамж юмнууд нь өөр юм байгаа юу, байхгүй юу.

Бид үүнийгээ бас их зөв талдаа гаргаж, зөв ойлголтыг өгөхгүй бол сонгуульд амжилтгүй оролцсон хүний нэг гомдох шалтгаан болгочих гээд байдаг нэг ийм сөрөг тал байдаг, хардлага байдаг. Гэхдээ өнгөрсөн хугацааны энэ олон шатын сонгуулиудыг харж байхад 50 хувийг нь ч очоод тоолж л байсан. Сонголтоор тоолж л байсан, зөрдөггүй л юм билээ л дээ. Гэхдээ л шинэ юм орж ирж байгаа гэдгээр хардлага байх вий. Тэр тал дээр энэ туршилт байдаг юм уу? Энэ дээр улс төрийн намынхан байдаг юм уу, иргэний нийгмийн байгууллага байдаг юм уу, ийм оролцсон юмнууд бас хийж таниулах ийм төлөвлөгөө Сонгуулийн ерөнхий хороонд байгаа юу гэж, 1 дүгээрт.

2 дугаарт, УБЕГ дээр нэг асуудал байгаа юм. Энэ сонгуулийн хэсгийн хороодыг олонх болгох нэг асуудал. Нөгөө талдаа нэг хэсгийн хороон дээр ядаж нөгөө 2 саналын хуудас уншдаг машин байхад нэг хурууны хээний төхөөрөмж байгаад байдаг байхгүй юу. Тэгээд хурууны хээ нь гацдаг, уншдаггүй, ямар нэгэн байдлаар эвдрэл, гэмтэл гардаг техник л юм чинь тэр чинь. Тэгээд тийм юм гараад байдаг юм байна лээ. Саналын хуудасны машин уншихад бэлэн байгаад байдаг хурууны хээн дээр гацчихдаг, тэнд очер үүсээд байдаг, сонгуулийн хэсгийн хорооны гадаа бөөн хар очер болдог. Ялангуяа 22 цаг дөхөөд ирэхээр ийм байдал гардаг. Тэгэхээр энэ бид техникийн бэлтгэл, бэлэн байдлыг

хангахад энэ улсын бүртгэлийн тэр хурууны хээ уншдаг машин чинь их чухал юм байна лээ шүү. Амьдрал дээр харж байхад. Тэрийг уншуулаагүйгээр саналын хуудас өгч болохгүй. Түүн дээр гацчихдаг юм. Ийм байдал үүсээд байдаг юм байна лээ. Тэгэхээр саналын машин хэд байна, тэрэнтэйгээ адилхан хурууны хээ уншигчаа байлгамаар. Ард нь дахиад тэр чинь ачаалал авдаг, эвдэрдэг юм байна лээ. Бас нөөц юмнууд байна уу, үгүй юу? Ингээж байж бид энэ нөгөө олон нэр дэвшигчийг дугуйлна, пропорционалыг дугуйлна гээд. Ингээд нэг сонгогчдод зарцуулагдах хугацаа нэлээн урт болоод байгаа учраас энэ тал дээр улсын бүртгэл ер нь ямар бэлтгэл бэлэн байдал хангаад байгаа вэ гэдгийг бас би нэг тодруулъя гэж ингээж бодож байгаа.

Ер нь эцэст нь хэлэхэд тэр сонгуулийн дүнгийн асуудал туйлын чухал. Хэнтий аймагт 2013 онд шиг санаж байна даа. Аймгийн иргэдийн хурлын нөхөн сонгуулийн саналын хуудсыг ширээ тойрч тоолчихоод аваачаад уурын зууханд шатаачихсан тийм тохиолдол байдаг юм шүү дээ. Тийм. Тэгэхээр тэр бол яг тэр сонгуульд өрсөлдсөн хүмүүст ч тэр, ер нь их л бүдүүлэг л юм байдаг юм байна лээ, ер нь тийм. Тэгээд би үүнийг зориуд асуух гэж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: 84 Дэлгэрсайхан.

УБЕГ-ын дарга Дэлгэрсайхан Идэрбат гишүүний асуултад хариулъя. Техник тоног төхөөрөмжийн бэлэн байдал мэдээж зайлшгүй чухал шаардлагатай. Энэ ганц хурууны хээ биш иргэдийг таньж баталгаажуулах зорилгоор компьютер, принтер, хурууны хээ, бусад тоног төхөөрөмж залгуураас аваад, нөөц тэжээлээс авхуулаад ийм нэг багцыг улсын бүртгэлийн байгууллагаас хэрэглэдэг.

Энэ жилийн хувьд бид нар 2012 оны шинэчилсэн бүртгэлээс хойш анх удаагаа бүх тоног төхөөрөмжийг энэ жилийн төсвийн тодотголоор шинэчилсэн байгаа, 1 дүгээрт.

2 дугаарт, ер нь зохион байгуулалтын хувьд 1800-аас дээш сонгогчтой хэсгүүд дээр 2, шаардлагатай аймгийн төв болон нэлээн хүн ам ихтэй, сонгогч ихтэй газар бид нар илүү тоног төхөөрөмж, 3 тоног төхөөрөмж байгуулахаар, хэрэглэхээр зохион байгуулалтад орсон байж байгаа. Ер нь сонгогчдыг таньж баталгаажуулах бол яг өнөөдрийн байдлаар улсын бүртгэлийн байгууллага дээр хэрэглэгддэг, хэрэглэж байгаа бас энэ системүүд бас явдаг учраас харьцангуй бас туршигдсан гэж ойлгож болно. Бүх аймаг, бүх дүүргүүдэд, гадаадад суугаа Дипломат төлөөлөгчийн газруудад яг өнөөдрийн байдлаар энэ хурууны хээгээр бүртгэл хийгдэж, энэ бас систем нь явдаг учраас одоо бид нарын энэ шинээр авсан тоног төхөөрөмж дээр тухайлан бас туршилтын ажил хийгдэх бас шаардлагагүй байгаа учраас системийн бэлэн байдлын талаар нэлээн анхаарал хандуулж ажилласан байгаа гэдгийг бас энд хэлмээр байна.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя.

Монгол Улсын Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн хүндэт харуулын ротын хугацаат цэргийн албан хаагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Хүндэт цэргийн албан хаагчид, эр цэргүүд та бүхэнд ажил олноо амжилттай хаахыг хүсэн ерөөгөөд, хамгийн сайн сайхан, эрүүл энхийг хүсэн ерөөе.

Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

82 Сонгуулийн ерөнхий хорооны дарга.

П.Дэлгэрнаран: Идэрбат гишүүний асуултад хариулъя. Тэр “New Image Cast” гээд энэ манай энэ 12 оноос хойш хэрэглэж байсан төхөөрөмжийн албан ёсны нэр нь юм байгаа юм. Тэгэхээр энэ бид нар сая 23 оны төсвийн

тодотголоор нөхөн бүрдүүлэлт хийгээд Улсын бүртгэлийн газар манай 2 хамтарч бас мэдээллээ солилцоод, ер нь төхөөрөмжийнхөө хүртээмжийг бид нар нэлээн нарийн сайн тооцоолсон. Тэгээд бид нар бид хэдийн ажиллуулах хэсгийн хороодод ажиллах төхөөрөмжийн тоо адилхан байгаа. Тэгээд одоогоор бэлтгэгдсэн бүрдүүлсэн төхөөрөмжийн тоо бол хангалттай хүрэлцээтэй гэж байгаа.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Хар машин ашиглаад энэ программ хангамж ашигласнаас хойш бас яг энэ сонгуулийн маргаан багассан. Үүнийг бас тодорхой хэмжээнд энэ техник технологийг ашиглах нь зөв. Гэхдээ бид нар энэ тойргийн энэ хуваарилалтыг өөрчлөх, энэ сонгуулийнхаа энэ тогтолцоог өөрчлөх болгон дээр гардаг маргаанууд маш их байдаг. 2008 оны 07 сарын 01-ний маргаан бол тухайн үедээ гараар тоолж байсан тоолох процесс дээрээ нэр дуудаж тоолсноос болоод Монгол Улсад үймээн самуун үүсэж байсныг та бүхэн бүгдээрээ бас санаж байгаа байх. Хүний нэрийг өөр хүний нэрээр уншаад, ингээд зохион байгуулалттай луйвар явсны учир Монголын ард түмэн өгсөн санал нь гээгдэж, өөр тийшээ явсан учраас нийгмийн бухимдал дээд цэгтээ хүрч, тэнд бас сонгуулийн дараах үймээн болж байсныг бид нар хэзээ ч мартаж болохгүй, энэ хар өдрийг бол. Тэгэхээр энэ хар өдрийг бий болгохгүйн төлөө сонгуулийн хорооны бэлтгэл, зохион байгуулалт хамгийн чухал байдаг. Тэгэхээр энэ удаа ч гэсэн бид нар хэдий энэ хар машиныхаа программ хангамжийг апдэйт хийж, шинэчлэл хийсэн байх тийм ээ, хийхээр төсөв мөнгөө тавиулсан. Үүнийгээ маш сайн хяналттай хийх хэрэгтэй. Энэ тэгээд машины тооллого нь гар тооллого 2 ямар нэгэн байдлаар зөрөх юм бол энэ 07 сарын 01-нд давтагдах магадлал өндөр шүү. Тийм учраас энэ асуудал дээрээ аль алин дээр нь анхаарах хэрэгтэй.

Одоо бид нарт өнгөрсөн сонгуулиар гар тооллогыг хийхэд хүндрэл багатай байсан. Яагаад гэхээрээ нэг тойрог дээр цөөхөн мандаттай байсан учраас аль ч хэсгийн хороо дээр тоолоод үзэхэд тэрийг 3 хэсэгт юм уу, 4 хэсэгт хувааж байгаад тоолоход амархан байсан. Одоо бид нар 10 мандаттай тойрог дээр гар тооллогыг зохион байгуулах тэр процедураа журмаа маш тодорхой болгох хэрэгтэй.

Дээрээс нь тэнд оролцож байгаа ажиглагч нарт бүх боломжийг нь хангах тэр журмыг баталж өгөх ёстой. Ингээж байж бид нар тэр итгэл үнэмшлийг л дээд цэгт нь ямар нэгэн луйвар ороогүй байна аа гэдгийг харуулж чадах юм бол сонгуулийн дараах маргаан гардаггүй юм. Харин ямар нэгэн байдлаар гар тооллого хийж байхад зөвхөн хэсгийн хорооны гишүүд нь тооллогод оролцдог, ажиглагч нарыг оролцуулдаггүй, нээлттэй байдлаар камераар нийтэд тэр ажиглагч нар бүрэн хянах боломжгүй байдал энэ тэр үүсгэх юм бол эргээд энэ 07 сарын 01 давтагдах магадлал өндөр шүү. Үүнийг дандаа бодож явж байх ёстой. Монголын энэ 33 жилийн ардчиллын түүхэнд хийгдсэн хар мөр байгаа. Үүнийг хэзээ ч бид нар алдаа гаргаж ийм байдал үүсэхгүй байхын төлөө ажиллах ёстой. Тэгэхээр энэ дээр та бүхэн маш сайн журамлаж, сургалтуудаа хийж ингээж яваарай гэж хэлье.

2 дахь асуудал. Энэ программ хангамжийн энэ цаг хугацаанд шинэчлэл хийгээд дээрээс нь энэ олон техникийн шийдлүүд гарч ирж байна шүү дээ. Технологийн. Эд нарыг богино хугацаанд цаг хугацаатай минуттай энэ амжих уу? Энэ дээр та бүхэн бас, энэ тал дээр бас асууя.

Г.Занданшатар: Дэлгэрнараран дарга 82. 83 Бат-Эрдэнэ дарга.

Сонгуулийн ерөнхий хорооны Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ Ганибал гишүүний асуултад хариулъя. 1 дүгээрт, гишүүний ярьж байгаа зүйлтэй

санал нэг байна. Бид хяналтын тооллогын үйл ажиллагааг нээлттэй ил тоолж явуулах энэ үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн байгууллага болон сонгогчдын оролцоотой, төлөөллийг ажиглагчдыг бүрэн оролцуулж явуулах тал дээр анхаарч ажиллах зайлиггүй шаардлага бий. Энэ ч утгаараа өнгөрсөн хаврын чуулганаар батлагдсан Их Хурлын сонгуулийн тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр энэ чиглэлийн хэд хэдэн цогц зохицуулалтыг хийсэн.

1 дүгээрт, санал авах байр болгон дээр хяналтын камерыг байршуулж байгаа. Ингээд хяналтын камераар гар аргаар энэ хяналтын тооллого хэлж хийж байгаа энэ үйл ажиллагааг шууд дамжуулах, шууд харуулах энэ боломж нь бүрдэнэ.

Мөн дээрээс нь хуучин хяналтын тооллогын үйл ажиллагаанд зөвхөн хэвлэл, мэдээллийн байгууллага оролцох л боломжтой. Ажиглах боломжтой байсан бол нэмээд сонгогчдын төлөөлөл өөрсдөө ажиглагчаар оролцох энэ боломжийг энэ эрх зүйн орчныг бас бүрдүүлсэн байгаа.

Системийн хувьд 2012 оноос хойш хэрэглэж байсан энэ систем ерөөсөө өөрчлөгдөөгүй. Түрүүн хэлж байгаа бол бид нар зүгээр нөхөн бүрдүүлэлтийг л хийсэн. Ямар нэгэн шинэ систем, шинэ төхөөрөмжийг программ хангамжийг огт ашиглахгүй, 12 оноос хойш хэрэглэж байсан энэ төхөөрөмжөө ашиглана.

Өшөө нэг зүйл маань мэдээж бүх хэсэг дээр 100 хувь гараар хяналтын тооллого хийнэ. Мэдээж үүнтэй холбоотойгоор зохион байгуулалтын арга хэмжээ авах, энэ журмынхаа ил тод байдлыг хангах, процессын үйл ажиллагааг илүү боловсронгуй болгох тал дээр Сонгуулийн ерөнхий хороо журмаа боловсруулахдаа илүү анхаарч ажиллах боломжтой гэж хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ганибал гишүүн тодруулъя, 1 минут.

Н.Ганибал: Тэгэхээр санал хураалтын процесс дээр мэдээж хэсгийн хороод, сумын багууд дээр бас энэ санал хураалтууд явна. Энэ дээр хяналт хийхэд бүх энэ тойрог, хэсгийн хороод дээрх камерын асуудлууд, мэдээж тэр камерын бичлэгийг олон нийтэд ажиглагч нарт харуулах тэр дэлгэц телевизор байх юм уу, дэлгэц байх юм уу? Энэ асуудлууд дээр санхүүгийн хувьд шийдлээ олчихсон уу, мөнгө төгрөг нь байгаа юу? Зүгээр энд тэндээс цуглаж, аваачиж зохион байгуулах гэж байна уу?

Г.Занданшатар: 83 Бат-Эрдэнэ.

Д.Бат-Эрдэнэ: Бид хяналтын камерыг бүх хэсгийн хороод дээр байршуулах ажлыг 2021 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар бүрэн туршаад үзсэн. 2100 орчим хэсгийн тал дээр нь яг шууд рийл тайм дамжуулах ийм боломжтой. Нөгөө сүлжээгүй газруудад хяналтын камер маань бичлэгээ авч хадгалдаг ийм зохион байгуулалтаар ажиллаж байгаа. Энэ камерын хяналтын бичлэгийг шууд үзэх эрхийг сонгуульд оролцож байгаа нам, эвслүүдэд өөрсдөд нь админ эрхийг нь шууд өгдөг.

Мөн дээрээс нь Сонгуулийн ерөнхий хороо өөрийн байгууллага дээр байршуулдаг энэ дэлгэцээр бүтэн өдрийн турш нээлттэй хэвлэл, мэдээллийн байгууллагынхан дамжуулдаг энэ үйл ажиллагааг зохион байгуулдаг. Яг энэ жишгээрээ энэ 2024 оны ээлжит сонгуулиар ажиллана гэж төлөвлөж байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Өчигдөр Төрийн байгуулалтын байнгын хороо дээр олон асуулт асууж, хариулт авч бас нийгэмд, иргэдэд, сонгогчдод мэдээлэл өгсөн гэж ингэж ойлгож байгаа. Нэг зүйлийг давтан асуугаад бас хариултыг нь авчихъя гэж ингэж бодож байна.

Мандатын тоогоор санал өгнө. Хэрвээ мандатын тооноос нэгээр ч юм уу, хэдээр ч юм илүү байвал мандатын тооноос нэгээр ч юм уу, хэдээр ч юм уу дутуу байвал буцаж хар машин буцаагаад, ингээд тэр гарч ирсэн алдаатай саналыг нарийн нууцлалд хамруулж, архивд аваад дахиж санал өгүүлэх боломж бүрэн бүрдсэн гэж өчигдөр хариулсан. Энэ бүр баталгаатай юу гэдгийг би лавлаж асууж байна. Учир юу вэ гэхээр ингэж байж маш их зардал мөнгөөр маш их хүмүүсийн оролцоогоор болж байгаа сонгууль. Хэдэн хувь нь ч одоо дутуу мандатын бөглөснөөрөө юм уу, илүү мандатын тоо зурснаараа хүчингүй болох юм бол сонгуулийн ерөнхий үр дүн бүр засаглалын тогтолцоонд ч өөрчлөлт орохыг үгүйсгэхгүй. Тийм болохоор нэг ч хүн гомдолгүй байх зүйл бол өгсөн бүх хүн яг мандатынхаа тоогоор өгөх энэ боломжийг хангана аа гэж өчигдөр хэлсэн. Тэгэхдээ тэрийг баталгаажуулж асууж байгаа юм гэж хэлэх гэсэн юм.

Дээр нь хэдүүлээ сонгууль гэхээр нэг л зүйл байгаа. Шударга л явагдах ёстой. Тэгээд хэн ялах нь бол тэр 30 дугаар асуудал байх ёстой. Шударга явуулахын тулд Сонгуулийн ерөнхий хороо, Улсын бүртгэлийн газар, тойргийн хороо, салбар хороод, хэсгийн хороод, дээр нь Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэл хяналтын дэд хороо бидний хамтын ажиллагаа чухал аа. Сая Улсын Их Хурлын дарга Занданшатар даргаас бид нарт үүрэг өгчихлөө. Тийм учраас үүнийг бас нэг жижигхэн ажлын албатай болгоод дундын бид нарын би, та нар бол өөр өөрсдийнхөө өмнөө даасан салбарынхаа ажлыг хийгээд л явдаг. Тэгээд үүнийг бөөгнүүлж хэдүүлээ хамтарч Их Хурлын хяналтад оруулах, дараа нь маргаан мэтгэлцээн болох ч гэдэг юм уу, үгүй бол ойлгомжгүй асуулт бий болох ч гэдэг юм уу, шийдэл хийхэд хэдүүлээ мэргэжисэн удирдлагаар хангах ийм боломжийг бүрдүүлэх энэ тогтоолын төслийг бас нэг жижигхэн ажлын албатай, референттэй ийм болгож оруулж ирье. Энэ дээр манай 2

дарга өмнөх туршилагууд юу байна, бусад орнуудын туршилага юу байна вэ? Энэ дээр бас анхаарч ажиллах байх аа гэж ингэж бодож байна.

Тэгээд юуны хяналтын систем бол өчигдөр бас тайлбарласан. Аудит хийгддэг бусад юунуудаас хийгддэг гэж. Өчигдөр би дахиад хэлсэн. Үүний хяналтыг ТЕГ, цагдаа өөр Улсын бүртгэл, Сонгуулийн хорооноос хамтарсан ажлын хэсэг хянадаг аа гэж. Үүний хяналтад УИХ-д суудалтай, хариуцлага барьж байгаа сөрөг хүчнийг заавал оруулах ёстой. Ингэж байж өөрөө хяналт чинь тодорхой болно, тодорхой болно. Тэгэхгүйгээр юу гэдэг юм эрх баригч хүчин яадаг вэ гэхээр бүх л асуудлуудыг тушаал, шийдвэрээр хийдэг. Энэ ч өмнөх шат шатны сонгуулиудад бас анзаарагдаж байсан. Хэдийгээр тангараг өргөсөн албан хаагч гэж байгаа боловч яг дээдх дарга нар нь очоод тулгачихдаг. Тэгээд төрийн албан хаагчдыг бүлтгэнүүлээд байдаг, ийм байдаг. Тийм учраас тэнд хөндлөнгийн, нэгэнт л хөндлөнгийн хяналт шударга ёсны төлөө явж байгаа учраас энэ парламентад суудалтай сөрөг хүчнээс тэнд хүн оруулах ёстой гэж ингэж хэлж байна.

Г.Занданшатар: 87.

Сонгуулийн ерөнхий хорооны Банзрагчдорж. Гишүүний асуултад хариулъя.

Саналын хуудасны хувьд 10 мандаттай хэсэг, 10 мандаттай газар, 10-аас илүү юм уу эсвэл 10-аас дутууг бөглөсөн тохиолдолд санал тоолох төхөөрөмж маань уншихгүй. Хэрвээ 10-аас илүүг бөглөчихсөн бол тухайн бөглөсөн саналын хуудас нь хүчингүй болгоод тухайн сонгогч ахиад 1 удаа саналын хуудас шинээр нөхөж авах боломжтой. 10-аас дутууг бөглөсөн байвал зохион байгуулалтын л асуудал болно гэсэн үг. Саналын хуудсыг нь уншихгүйгээр буцаагаад гаргаад ирчихнэ.

Тэр буцаасан саналын хуудсыг гүйцээж бөглөх тийм ажил явагдана гэсэн үг.

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя, тодорхой хариул даа. 82.

П.Дэлгэрнаран: Батсуурь гишүүний асуултад нэмж хариулъя. Тэгэхээр төхөөрөмж маань өөрөө хажуудаа өөрөө дэлгэцтэй. Тэгээд хэрвээ тухайн сонгогч мандатын тооноос илүү өгсөн юм уу, дутуу өгсөн тэр дэлгэцэн дээрээ мессеж өгнө. Та илүү өглөө, дутуу өглөө гэдэг. Тийм учраас тэр саналын хуудас нууцлалтайгаар буцаагдаад тэгээд дахиж 1 сонгогчдод 1 удаа тухайн алдааг сануулаад дахин бөглөж, машинд уншуулах ийм ажил хийгдэнэ. Тэгээд ер нь энэ хүчингүй саналын хуудас гэдэг юм бол гардаггүй. Энэ техник маань өөрөө ийм үйлдэлтэй учраас хүчингүй санал гэдэг саналын хуудас гэдэг юм гардаггүй. 20 оны Улсын Их Хурлын сонгууль дээр энэ техникийг ашиглахад ерөөсөө хүчингүй саналын хуудас байгаагүй. Ирсэн санал болгон хүчинтэйд тооцогдож явсан.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна.

Ж.Батсуурь: Саналын хуудсан дээр будах уу, дугуйлах уу. 1 дүгээрт, будах уу, дугуйлах уу. Саналын хуудасны өмнөхийг будах юм уу, дугуйлах юм уу, 1 дүгээрт.

2 дугаарт, ингээд 10 мандаттай 10-ыг зурлаа гэхэд бүгдийг голд нь будаад нэгийг нь хажууд нь будчихсан байвал тэр алдаанд тооцогдох уу.

Г.Занданшатар: 85. тодорхой асуулт асууж байна.

Д.Бат-Эрдэнэ: Батсуурь гишүүний асуултад нэмж хариулъя. Саналын хуудсан дээр тэмдэглэх хэсэг нь улаан зууван дугуй байгаа. Энэ улаан зууван дугуйг дүүргэн будаж, саналаа тэмдэглэнэ. Түүрүүн Дэлгэрнаран даргын хэлсэн асуулт дээр нэмж хэлэхэд 10

мандаттай тойрогт 11-ийг тэмдэглэх юм бол саналын хуудсыг уншихгүйгээр эргүүлээд буцаагаад гаргачихна. 9 мандатыг тэмдэглэсэн байх юм бол эргүүлээд саналын хуудсыг чинь буцаагаад гаргачихна. Ингэхээр зэрэг тухайн сонгогчид 1 удаа саналын хуудас өгөөд 10 мандатаа бүтэн тэмдэглэж байж л санал тоолох төхөөрөмж маань уншина. Ингэхээр зэрэг саналын хүчинтэй хуудас маань санал тоолох төхөөрөмжөөс бүгд гарна аа л гэж ингэж ойлгох хэрэгтэй.

Түрүүн Батсуурь гишүүний асуулт дээр бас яригдаж байсан энэ сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой асуудал дээр Сонгуулийн ерөнхий хороо хамтарч ажиллахад нэгдсэн удирдлагаар хангаад, хамтарч ажиллахад бэлэн байгаа. Яагаад гэхээр зэрэг одоо энэ тийм энэ саналыг дэмжиж байгаа. Бид нар тогтоолын ... /минут дуусав/

Г.Занданишатар: Гүйцээгээд хариулчих, 85 Баяндүүрэн.

Д.Баяндүүрэн: Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой асуудал дээр Сонгуулийн ерөнхий хороо хамтарч ажиллахад бэлэн байгаа. Энэ тогтоолын төсөл бусад асуудлаар бид нар ил тод нээлттэй ажиллана гэж хэлмээр байна. Санал тоолох төхөөрөмжийг баталгаажуулах ажлын хэсэг гээд хуулийнхаа дагуу сонгуулийн автоматжуулсан систем нь хуулийн дагуу гардаг. Энэ дээр Тагнуулын байгууллага, Сонгуулийн ерөнхий хорооны Мэдээлэл технологийн төв, Цахим хөгжлийн яам гэсэн энэ 3 субъект ордог байгаа. Энэ 3 субъект бол энэ ажлаа хуулийн дагуу хийж гүйцэтгэнэ.

Дээрээс нь улс төрийн намууд энэ баталгаажуулах ажилд ил тод нээлттэй оролцох боломжтой. Өмнө нь ч гэсэн ингээд оролцоод ирж байсан гэдгийг хэлмээр байна. Энэ асуудал нээлттэй гэдгийг хэлмээр байна. Баярлалаа.

Г.Занданишатар: Батсуурь гишүүн тодруулъя.

Ж.Батсуурь: Сая Дэлгэрнаран дарга, Баяндүүрэн гишүүн 2-ын ярианд 10-аас илүү юм 10-аас дутуу бол алдаа заагаад дахин боломж олгоно гэсэн. Бат-Эрдэнэ түрүүнд ингээд хэлчих шиг болсон 10-аас илүү бол алдаа, 10 хүртэл бол болно гээд дуугарчих шиг болсон. Яг аль нь вэ? Тийм. 10 хүртэл болох юм байна. 10-аас илүү алдаа гэж тооцно гэж түрүүн тэгж хариулсан уу, үгүй юү?

Г.Занданишатар: Доржсүрэнгийн Бат-Эрдэнэ 83.

Д.Бат-Эрдэнэ: Гишүүний асуултад хариулъя. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль дээр маш тодорхой заасан байгаа. Саналын хуудсыг хүчингүйд тооцох үндэслэл гээд. Мандатын тооноос илүү эсхүл дутуу тэмдэглэсэн саналын хуудас бол хүчингүй. Хүчингүй саналын хуудсыг санал тоолох төхөөрөмж уншихгүй.

Г.Занданишатар: Бөхчулууны Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Сонгуулийн санал тоолох машинд би 2012 онд ялагдаж байхдаа ч итгэж байсан, 16, 20 онд ялж байхдаа ч итгэж байсан. Тэгэхээр энэ өөрийнхөө буруугаас болж ялагдсан нөхөд энэ бас хар машин гэж цоллоод тэгээд зарим нь шатааж байсан ийм тохиолдлууд байгаа. 12 онд МАН ялагдчихаад сонгуулийн хар машинаас боллоо гээд л гонгинодог байсан. 16 онд манай намынхан бас зарим нэгэн хүмүүс энэ хар машинаас боллоо гэж яриад байгаа. Тэгэхээр энэ дээр гол асуудал нь ийм хардалт байгаа учраас үе үеийн сонгуулиудыг сонгож, заримыг нь 50 хувилж, сүүлийн Ерөнхийлөгчийн сонгуулийг бүр 100 хувиар гараар тоолж шалгасан. Эндээс ямар ч зөрөө, хаана ч 1 ширхэг ч зөрөө гараагүй. Би олон газраар явж уулзалт хийж байгаа, олон газар АН-ын засаглалтай сумууд байж байгаа. Түүн дээр ингэж ингэж юм явдаг шүү

гэдэг тийм юм надад 1 ч хэлж байгаагүй. Зүгээр нэг нийгмийн хардалт байгаад байх шиг байгаа юм.

Тэгээд ер нь энэ доминион вотингийн энэ санал тоолох машины асуудал бас олон улсад ч бас хардлага дагуулдаг. Тэгээд түүнийх нь дагуу Фокус Ньюс хэвлэлийн компани хэвлэлийн байгууллага Трампын сонгуулийг энэ санал тоолох машинаар луйвардчихлаа гэдэг асуудлыг хэвлэн нийтэлснийхээ төлөө доминион вотинг нь шүүхэд өгөөд 2,7 тэрбум доллар нэхээд, тэгээд 787 сая долларын торгууль төлсөн байж байгаа. Өөрөөр хэлбэл энэ хар машин ямар ч асуудалгүй байна аа гэдгийг тогтоогоод, буруутгах шалтгаанаа нотолж чадаагүй учраас энэ 787 сая доллар шүү. Ийм их мөнгө төлсөн байж байгаа.

Тийм учраас энэ итгэдэг учраас энэ сонгуулийн санал тоолох машины программ хангамж, дээрээс нь шинээр худалдаж авахад зориулаад нэлээн шаардсаны үндсэн дээр 15,9 тэрбум төгрөгийг Сонгуулийн ерөнхий хороонд хуваарилсан. Үүний дагуу программ хангамж бүх зүйлээ аваад явж байна.

Дээрээс нь хурууны хээний тоног төхөөрөмж, түүний программ хангамжид нийтдээ 18 тэрбум төгрөг энэ 23 оны улсын төсвийн тодотгол дээр тавьж бас хуваарилагдсан байгаа. Бүх тоног төхөөрөмжөө аваад программ хангамжаа авчихсан байж байна. Тэгээд үүнийг намайг шаардсаны үндсэн дээр гэхээр намайг өөрийгөө яриад байна гэж магадгүй. Тэгэхээр 2 дарга бас үүнийгээ бас тодорхойлж хэлж өгөөрэй гэж хүсэж байна.

Ийм асуудал ер нь программ хангамж нь асуудалгүй болсон. Гол асуудал бол улсын бүртгэл дээр тэр бүртгэлийн асуудал байгаа. Түүн дээрээ нэлээн сайн хариуцлагатай ажиллаарай гэж хэлье, 1 дүгээрт.

2 дугаарт, нэр дэвшиж байгаа хүмүүс өөрсдөө энэ дээр маш тийм

хариуцлагатай хяналттай хүмүүсээ хянуулж ажиллах ёстой гэдгийг хэлэх нь зүйтэй.

Тэгээд хамгийн сүүлд нь нэг асуулт байна. УБЕГ 2020 оны сонгуулийн сонгогчдын нэрсийн жагсаалтыг манай намд 3 өдрийн өмнө өгсөн, 3 өдрийн өмнө яг энэ адилхан хуультай байсан тэр өгсөн. Гэтэл тэр сонгогчдын нэрсийн жагсаалт нь онгойдоггүй, нээгддэггүй. Тэгээд тэр код нь байхгүй ингээд л авчраад өгчихсөн, тэрийг нь манай төв нам онгойлгож чадахгүй, нээж чадахгүй сүүлдээ Ховд руу манай программист, над дээр ажиллаж байсан программист тэрийг нээгээд буцаагаад энэ улс орон даяар намынхаа байгууллагуудад өгсөн байхгүй юу даа. Ийм асуудал дахиад энэ юугаар энэ 24 оны сонгуулиар гарах вий гэдэг ийм асуулт байна. Энэ дээр ... /минут дуусав/

Г.Занданшатар: Асуултад хэн хариулах вэ? 84 Улсын бүртгэлийн газар.

УБЕГ Дэлгэрсайхан Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Тоног төхөөрөмжтэй холбоотойгоор мэдээж бэлтгэл ажлыг маш сайн хангах шаардлагатай. Төсвийн нэмэлт тодотголоор 3 мянган компьютерын сонгогчдыг таньж баталгаажуулах төхөөрөмжийг авсан. Одоо яг бэлэн байдалд нь оруулж байна. Өөрөөр хэлбэл ойролцоогоор 2100 гаруй хэсэг байдаг. Тэгэхээр энэ хэсгүүд дээр зарим газар 2, бүр шаардлагатай бол 3 тоног төхөөрөмжийг хэрэглэх ийм бэлтгэл ажлыг хангаад байж байна.

Сонгогчдын нэрийн жагсаалтыг энэ удаагийн Их Хурлын сонгуулийн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр ч гэсэн 2 удаа нам, эвсэлд олгохоор байгаа. Тэгэхээр нээгдэхгүй гэдэг асуудал Хувь хүний мэдээллийг хамгаалах тухай хуулиар бид нар тухайн үед “хуулж болохгүй” ийм тохиргоо хийсэн байсан. Түүнээс биш нээгдэхгүй юм байгаагүй. Одоо манай архивд ч гэсэн байгаа, нээгдэж харагдаж байгаа. Харин

хуулагддаггүй, копи селек хийж болдоггүй, өөрөөр хэлбэл бид нар тэр файлийг давхар өөр байдлаар ашиглахгүйн үүднээс тийм код хийсэн байсан юм шүү гэдгийг бас танилцах, хуулийн зохицуулалт ч бас тийм байсан. Өөрөөр хэлбэл хувь хүний мэдээллийг бас хамгаалах тодорхой тийм шаардлага байсан гэдгээ бас танд тайлбарлаж хэлье.

Г.Занданшатар: Санал хураалт явуулна, гишүүд суудалдаа сууя. Энэ хооронд Дэлгэрнараран дарга 82 гүйцээгээд хариулчих.

Гишүүд асуулт асууж, үг хэлж, хариулт авч дууслаа.

Нэг зүйл тогтлоо. Хар машин дээр ямар ч асуудал байхгүй гэдгийг Пүрэвдорж гишүүн нотлон хэлсэн учраас бусад гишүүд бүгд нотолсон учраас машин дээр ямар ч асуудал байхгүй юм байна. Харин хяналтыг сайн тавих хэрэгтэй. Энэ машин чинь харин энэ олон бүсчилсэн санал хураалт явуулах бололцоог олгож байна шүү дээ, тийм ээ.

Ингээд санал хураалт явуулна. Байнгын хорооны санал дүгнэлттэй холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж дууссан.

Байнгын хорооны саналаар “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

55,6 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хөөш Пүрэвдорж гишүүн ээ. Ингээд 2 тогтоол батлагдчихлаа. Нэг тогтоол батлагдсангүй. Тэгсэн яагаад завсарлага авсан юм гэсэн чинь энэ Адьшаа гишүүн, Цогтгэрэл гишүүн 2 харш өдөр учраас санал хураалт явуулж болохгүй гээд завсарлага авчихсан байна.

Тэгээд хүн болгоны өдөр тааруулах юм бол өдөр болгон л сайн шүү дээ. Тэгээд ингээд бүтэн төрийн ажил уяад байх хэрэг байгаа юм уу?

Тогтоолын төсөл батлагдлаа.

Тогтоолын төслийн эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Алга байна.

13.22 цаг

Дараагийн асуудалд орёё.

“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна.

Хөдөлмөрийн хуулийн дагуу цайны цаг гэж Туваан гишүүн дэмжиж байна.

Ингээд завсарлалаа. Туваан гишүүний саналыг хүлээж авлаа, хүндэтгэлтэйгээр. Хөдөлмөрийн хууль яг зөрчих гэж байсан байна.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

Г.Занданшатар: Үнэнбат дарга аа, гишүүдийг дуудаарай.

“Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэнэ.

Төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Индэрт урьж байна. Танилцуулгаа хийгээд явж байя.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн байнгын хорооноос боловсруулсан “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Хууль зүйн байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм нь Хүний эрхийн Үндэсний Комиссоос тусдаа бүтэц, орон тоотой байснаар үйл ажиллагаагаа явуулах боломж хэрхэн бэхжиж, сайжрах талаар, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяа Хүний эрхийн Үндэсний Комисс болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний бүтэц, орон тоо, төсөв хөрөнгө нь тусдаа байх боломжтой эсэх талаар тус тус асуулт асууж, хариулт авсан болноо.

Түүнчлэн Байнгын хорооны хуралдаанаар тогтоолын төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх, хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах зэрэг механизм байгаа бөгөөд комиссын дэргэд дахин комисс байгуулах нь хүний эрхийг хамгаалах тогтолцооны нэгдмэл байдлыг алдагдуулах, төсөвт хүндрэл учрах, хүний нөөцийн тогтвортой

бодлого алдагдах талаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Улсын Их Хурлаас соёрхон баталсан эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр, төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенцын нэмэлт протоколд эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх механизм нь хараат бус бие даасан байхаар заасан ба Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулиар Хүний эрхийн Үндэсний Комисс болон эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүнийг үйл ажиллагаагаа хараат бусаар хэрэгжүүлэхээр зохицуулсан ч зохион байгуулалтын хувьд хамтдаа байгаа нь асуудал үүсгэж байгаа талаар үг хэлсэн болно.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн түгээмэл тунхаглалын батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хууль зүйн байнгын хорооноос боловсруулан “Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж,

үг хэлэх Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна.

Санал хураалт явуулна. Гишүүдийг дуудаарай.

Хууль зүйн сайд, холбогдох сайд байхгүй байгаа учраас энэ асуудлыг хойшлуулсан. Эрхэлсэн сайд байхгүй бол хойшлуулах бас дэг байна.

Дараагийн асуудалд оръё. Саяын тогтоолыг санал хураалт үлдсэн юм чинь санал хураалтыг нь дараа нь явуулчихъя.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Даваажанцангийн Сарангэрэл танилцуулна.

Д.Сарангэрэл: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 06 дугаар сарын 28-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаараа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан бөгөөд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Туваан хуулийн

төсөлд уламжлалт анагаах ухааныг орчин үеийн шинжлэх ухаантай хослуулан, иргэдийн эрүүл мэндийг эрсдэлт хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах зохицуулалтыг тусгасан эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа иргэдийг өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх зорилгоор биеийн тамир, спортоор хичээллэх хөшүүрэг болгож, ЭМД-аас тодорхой хөнгөлөлт, урамиуулал олгох боломжтой эсэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир хуулийн төсөл батлагдсанаар 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс нийтээр дагаж мөрдөхөд эрүүл мэндийн байгууллагуудад суурь нөхцөл бүрдсэн эсэх талаар асуулт асууж, хариулт авлаа.

Улсын Их Хурлын 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед хуралдаан даргалагчаас өгсөн гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасныг баримтлан зарчмын зөрөөтэй 2 санал, анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжсэн боловч дахин санал хураалгах шаардлагатай гэж Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд үзсэний дагуу мөн зүйлийн 42.2.3-д заасныг баримтлан зарчмын зөрөөтэй 1 саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг

явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны танилцуулга, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Сарангэрэл гишүүнд.

Байнгын хорооноос гаргасан зарчмын зөрүүтэй 3 санал байгаа. Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авах Улсын Их Хурлын гишүүн байна уу. Алга байна. Асуулт, хариулт байна уу.

Санал хураалт явуулна. Санал хураалтад бэлтгэтэл асуулт асууж санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асууж, хариулт авах хүн байхгүй бол санал хураалтад орно.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийн талаар Нийгмийн бодлогын байнгын хорооны гаргасан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгаж дэмжсэн санал байна.

1. Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “Үйл ажиллагаанд баримтлах” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүн, нотолгоонд” гэж тус тус өөрчилж, 4.1.1 дэх заалтын “, тэгш хүртээмжтэй, чанартай” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4.1.8.чанар, үр ашигтай байх;

4.1.9.тэгш хүртээмжтэй байх;

4.1.10.жэндэрийн эрх тэгш байдлыг хангах. Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо санал хураалт явуулна.

Тэгш байдал гэсэн байсныг эрх тэгш байдал гээд тогтвортой хөгжлийн зорилттой нийцүүлээд л найруулгын шахуу засварууд л байгаа.

С.Одонтуяа: Гишүүд танхимдаа цуглая. Санал хураалт.

Сарангэрэл гишүүний микрофоныг өгье. Эцсийн хэлэлцүүлэг дээрээ.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Өнөөдөр Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэг явагдах гэж байна. Та бүхэн маань энэ хуулийн ач холбогдлыг бол сайтар ойлгож байгаа гэдэгт бид итгэлтэй байгаа. Эрүүл мэндийн салбар бол эмнэлгийн тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ гэсэн 2 цогцоос бүрдэх учиртай. 2016 онд Улсын Их Хурлын дэд дарга Одонтуяа, Энх-Амгалан гишүүн бид нар бас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг батлуулаад энэ хүрээндээ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хуулийг мөн давхар авч явахаар олон жил ярьсан. Энэ хуулийн төсөл хойшилогдсоор яваад өнөөдөр ингээд эцсийн хэлэлцүүлэгт бас орохоор болж байгаад бид баяртай байгаа.

Хамгийн гол нь энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн ач холбогдол бол Монгол Улсын 3,4 сая хүнд бүгдэд нь хамааралтай, иргэдээ өвдөхөөс нь өмнө урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх ийм боломжийг нээж өгч байгаа. Хэдийгээр бид нар эдгээр зүйлийг хийгээд яваад ирж байсан ч гэсэн нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлийнхээ энд ажиллаж байгаа эрүүл мэндийн ажилтнуудынхаа нийгмийн баталгааг шийдээгүй байсан. Санхүүжилт нь

тодорхой биш, бие даасан бүтэц байхгүй, ингэж явсаар ирсэн. Одоо энэ асуудлыг бид нар өнөөдөр Улсын Их Хурлаар шийдвэрлэснээр эрүүл мэндийн салбар маань 2 жигүүртэй болох ийм боломжтой болж байгаа юм.

Хамгийн гол нь нас баралтын тэргүүлэх шалтгаан болоод байгаа зүрх, судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх ийм цогц арга хэмжээг эрүүл мэндийн салбар бүхэлдээ авах ийм боломж бүрдэнэ. Өнөөдөр Монгол Улсын маань хүн амын нэг 750 мянган 40-65 насны хүн байгаа. Судалгаагаар тэдгээр хүмүүсийн маань 50 хувь нь зүрх, судасны өвчний эрсдэлтэй гэж гарсан байгаа. Зүрх, судасны өвчний шалтгааныг бол бид урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой. Манай эрүүл мэндийн салбарынхан бол энэ дээр судалгаа хийгээд хөдөлгөөн, эрүүл бус хооллолт, архи тамхины хэрэглээ зэрэг ингээд 5 шалтгааны улмаас Монгол хүний нас баралтын тэргүүлэх шалтгаан нь зүрх, судасны өвчин болоод байгаа юм. Үүнээс урьдчилан сэргийлэх боломжтой гэдгийг нэгэнтээ тодорхойлоод гаргачихсан. Тэгэхээр энэ чиглэлд ажиллах, ард иргэдийнхээ эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, мэдлэг мэдээлэл өгөхөд энэ хууль маань өөрөө цогц бие даасан заалттайгаараа бас мөн ийм давуу талтай.

Тухайлбал бид нар хүүхдийн өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүүхдүүддээ бага наснаасаа явал эрүүл саруул байж болох вэ, юу хийх ёстой вэ гэдгийг нь тогтмол тогтвортой ийм мэдээллээр хангах ийм боломжийг бол хууль, эрх зүйн орчны хүрээнд бүрдүүлж байгаа нь энэ хуулийн маш том давуу тал юм байгаа юм. Тийм учраас бол манай Улсын Их Хурлын гишүүд Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг бол тал талаас нь дэмжиж, хамгийн эхэнд энэ чиглэлээр эрүүл мэндийн салбар маань өөрсдөө манлайлж, хамгийн анхны алхмыг цогцоор нь хийх ийм боломжийг бүрдүүлэх хуулийн төслийг дэмжиж

өгөөч ээ гэж хүсээж байгаагаа илэрхийлж байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Дахиад 2 минут байна. Чинбүрэн гишүүн мэдээлэл өгье.

Гишүүд чуулганыхаа танхимд хүрэлцэн ирнэ үү. Санал хураалт.

Ж.Чинбүрэн: Энэ Нийгмийн эрүүл мэндийн тусламжийн тухай хуулийн төслийн эцсийн эцэслэн батлах энэ чухал хурал болж байна. Энэ дээр бол энэ 8 дахь парламент бол эрүүл мэндийн салбарын хууль, эрх зүйн шинэчлэл дээр бол онцгой анхаарч ажиллаж байгаа. Тэр дотроо бид бас энэ олон түмний эрүүл мэндийн өвчлөл биш өвчлөхөөс нь өмнө урьдчилан сэргийлж чаддаг, эрт илрүүлдэг, дээрээс нь орчны эрүүл мэндийн асуудлыг хамгаалж чаддаг, ярьж чаддаг ийм тогтолцоог бий болгох анхдагч хуулийг батлах гэж байгаа энэ торгон мөч дээр бид бас энэ асуудлыг ярилцаж байна.

Тэгэхээр энэ нийгмийн эрүүл мэндийн тусламжийг оновчтой, чадамжтай ард иргэдийг нөгөө өвчин зовлон туссан хойно биш байхад гол зүйл бол ерөөсөө л нийгмийн эрүүл мэндийн ажилчдын боловсон хүчний нөөцийг зөв байлгах нь бол их чухал юм. Жишээлбэл аймгуудад эрүүл мэндийн газар нь эмнэлгийн тусламжийн газар шиг ажилладаг болчихсон. Тухайн аймгийн иргэдийнхээ эрүүл мэндийн хамгаалах, урьдчилан сэргийлэх, орчны эрүүл мэндийг бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаа байхгүй ерөөсөө л өвдсөн хүмүүстэй тулж ажилладаг эмнэлгийн даргын ажлыг хийдэг, тэгээд эмнэлгийн дарга нь эмнэлгийн нэгдсэн эмнэлгийн дарга нь юм уу, эрүүл мэндийн газрын дарга нь юм уу мэдэгдэхгүй болчихсон. Ийм тогтолцооны гажуудал байгааг засах чухал зүйл.

Дээрээс нь ер нь бол энэ гүйцэтгэлийн санхүүжилттэй холбоотойгоор эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч нар энэ нийгмийн

эрүүл мэндийн чиглэлд ажиллах хүсэл байхгүй болчихсон. Яагаад гэвэл цалин бага байгаа учраас тэнд хэн очиж ажиллах юм бэ. Тэр нийгмийн эрүүл мэндийн асуудлыг очиж тэр аймагтаа, дүүрэгтээ ажиллах хүнгүй болчихсон, эзгүйдчихсэн. Тэгвэл энэ хуулиараа бид бас энэ нийгмийн эрүүл мэндийн ажилчдын, боловсон хүчний, хүний нөөцийн асуудлыг шийдэх томоохон асуудлыг энд оруулж ирж байгаагаараа бас онцлогтой гэж бүр зориуд энд цохон тэмдэглэж хэлмээр байгаа юм.

Дээрээс нь салбар хоорондын уялдаа тийм ээ. Жишээлбэл бид өнөөдөр утаа бохирдолтын талаар ярьж байна. Архи тамхины тухай ярьж байна. Эрүүл хооллолтын тухай ярьж байна. Тэгсэн хэр нь үүнийг хэрэгжүүлдэг нэгдсэн том бодлогоор зангиддаг зөвлөл байхгүй. Тэгвэл өнөөдөр энэ хуульд бид бас Нийгмийн эрүүл мэндийн үндэсний зөвлөл Ерөнхий сайдын удирдлага доор ийм зөвлөлтэй болж байгаа нь салбар хоорондын уялдааг салбар бүрийн яамдын сайд нарын ажлын үүрэг дотор нийгмийн эрүүл мэндийн тусламжийн асуудлуудыг зангидаж оруулж өгч байгаагаараа бас онцлог болж байгаа гэдгийг бас энд онцлон хэлмээр байна.

Мөн бас ди парламент энэ цахим шилжилттэй холбоотой ди парламентад нэлээдгүй олон саналууд ирсэн. 40 гаруй саналууд ирсэн гэж байгаа. Энэ дотор уламжлалт анагаах ухааны чиглэлийн байгууллагууд хоорондоо нэгдэж зөвлөлдөж, тэгээд саналаа оруулсан нь энэ ер нь Монгол хүний энэ түүхэн уламжлалт энэ идээ ундаа, явдал мөр, энэ онцлогийг зангидсан эрүүл амьдрах ухааныг хэрэгжүүлэхэд оролцоотой байна гэдэг энэ хуулийн өөрчлөлтийг бас энэ дээр нэмж оруулж өгч байгаа нь бас онцлог. Тэгэхээр орчин цагийн анагаах ухаан нэмэх нь уламжлалт анагаах ухааны ололтод сайн нотолгоонд суурилсан, судалгааны үр дүнд суурилсан энэ шийдвэрүүдийг гаргадаг байх ёстой гэсэн энэ зарчмыг

орүүлж өгч байгаагаараа бас энэ хуулийн бас нэг онцлог тал гарч ирж байна.

Ингээд бид нарын гол зорьж байгаа зүйл бол Монгол Улсын өвчлөлийн ерөнхий зураглалыг том мэдээллийн сангаараа дамжуулан харж чаддаг. Үүн дээрээ анализ хийгээд ямар ямар өвчлөл голдуу Монгол хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учруулж байгааг тогтоож чаддаг. Түүний учир шалтгааныг нь 4 жил болгон хийж байгаа Степ судалгааныхаа дүгнэлтээ базаад, дүгнээд тэгээд түүнээсээ урьдчилан сэргийлэх бодлогоо гаргаж ирж чаддаг ийм Си Ди Си буюу өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, шинжлэх ийм төвтэй болох энэ тогтолцоо, мэдээллийн сантай болох ийм тогтолцоо хийж өгч байгаагаараа бас энэ хуулийн онцлогийг бас энд зориуд цохон тэмдэглэмээр байгаа юм.

Тийм учраас 8 дугаар энэ парламент ,8 дахь удаагийн сонгуулиар гарсан энэ парламент эрүүл мэндийн салбарт бид эмнэлгийн тусламж, үйлчилгээг илүү бие даасан болгох. Энэ дээр бол Чинзориг сайд амласан. Энэ 23 ондоо багтаад эрүүл мэндийн том лавлагаа төвүүд ТУЗ-тэй, биеэ даасан тогтолцоотой болох. Нийгмийн эрүүл мэндийн тусламж бол төрийн том бодлогоор зангидаж нэгдсэн бодлогоор нэгж болгонд онцлог, тухайн аймаг, дүүргүүдийн онцлогт тулгуурласан ийм бодлого явуулах ёстой гэдэг ийм зарчмын том 2 том ийм жигүүртэйгээр эрүүл мэндийн салбарт том өөрчлөлт хийж байгаа гэж харж байгаа. Баярлалаа.

С.Одонтуяа: Санал хураана.

Гишүүд танхимдаа цугларъя.

Үдээс хойших бүртгэлийн санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ бүртгэлийн санал хураалт шүү. Гишүүдээ дуудаарай, энэ бүртгэлийнх. Болорчулуун ороод ирлээ. Болорчулуун ороод ирсэн болох байх.

Болчихсон, болчихсон. Саналын томъёолол уншлаа шүү.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтыг үндэслэн хураалгаж, дэмжсэн саналыг уншъя.

1. Төслийн 4 дүгээр зүйлийн гарчгийн “Үйл ажиллагаанд баримтлах” гэснийг “Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “нотолгоонд” гэснийг “судалгааны үр дүн, нотолгоонд” гэж тус тус өөрчилж, 4.1.1 дэх заалтын “, тэгш хүртээмжтэй, чанартай” гэснийг хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмэх:

“4.1.8.чанар, үр ашигтай байх;

4.1.9.тэгш хүртээмжтэй байх;

4.1.10.жендэрийн эрх тэгш байдлыг хангах. Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

Тогтохсүрэн даргынх эсрэг гарчхаж, Та өөрөө. Бейсен гишүүн горимын санал гаргая.

Б.Бейсен: Энэ миний төхөөрөмж ажиллаагүй учир дахин санал хураалгаж өгнө үү.

С.Одонтуяа: Бейсен гишүүний саналаар саяын хураалгасан саналыг хүчингүй болгож, дахин санал хураалт хураахаар санал хураая. Санал хураалт.

Тийм байлгүй дээ. Бейсен гишүүн энэ салбарынхаа хуулийг хамгийн л дэмжих хүн шүү дээ.

55 хувийн саналаар Бейсен гишүүний горимын санал дэмжигдлээ.

Гишүүд суудалдаа сууна уу. Саяын уншсан саналын томъёоллоор дахин

санал хураалт явуулъя. Дахин санал хураалт.

59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дахь санал.

Төслийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг, 5.2.1 дэх заалтыг нэгтгэн доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“5.2.Энэ хуулийн 5.1.1-д заасан нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх хүрээнд дараах үйл ажиллагаа явуулна:

5.2.1.халдварт болон халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг тандан судлах, тодорхойлох, урьдчилан сэргийлэх, хянах арга хэмжээг орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны судалгааны үр дүн, нотолгоонд суурилан зохион байгуулах;

5.2.2.нийгмийн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээ, мэдээлэлд дүн шинжилгээ хийх.” Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо. Санал хураалт.

59,5 хувийн саналаар дэмжигдлээ.

3 дахь санал. Байнгын хороогоор дэмжигдсэн санал.

1. төслийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсгийн “байгууллагын” гэснийг хасах. Санал гаргасан Нийгмийн бодлогын байнгын хороо, санал хураалт.

59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж дууслаа.

Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцэслэн батлах

бэлтгэл хангуулахаар Нийгмийн бодлогын байнгын хороонд шилжүүлээ.

Дараагийн хуульд оръё. Ажлын хэсгийнхэнд баярлалаа. Ажлын хэсгийн ахлагч Сарангэрэлд Баярлалаа.

14.43 цаг

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлгийг явуулна.

Төслийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цагаанхүүгийн Идэрбат танилцуулна. Индэрт урьж байна.

Ажлын хэсгийн гишүүд орж ирээд байраа эзэлж байгаарай.

Ц.Идэрбат: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 10 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурлын 2023 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат ахалж, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн П.Анужин, Б.Баярсайхан,

Б.Бейсен, Б.Жаргалмаа нар ажилласан болно.

Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10 дахь хэсэгт заасны дагуу зүйл бүрээр хэлэлцлээ.

Ажлын хэсгээс Засгийн газраас өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн үзэл баримтлал, зарчмыг хөндөхгүйгээр салбарын мэргэжилтэн, судлаачдын зөвлөмжийг тусган боловсруулсан зарчмын зөрөөтэй 35 санал, найруулгын шинжтэй 1 багц санал болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй 19 санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно. Үүнд:

1. Эцэг эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж, хүүхдийн дэргэд архи, согтууруулах ундаа хэрэглэх болон хэрэглэсэн үедээ хүүхэд байгаа орчинд нэвтэрснийг хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсан гэж үзэх, үе тэнгийн дээрэлхэлт үйлдсэн хүүхдийн хамтаар сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ, төлөвшилд нөлөөлөх сургалт үйл ажиллагаанд хамруулах,

2. Боловсролын салбар дахь хүүхэд хамгааллын хүрээг өргөжүүлж, багш боловсролын сургалтын байгууллага нь хүүхэд хичээлдээ тодорхойгүй шалтгаанаар ирээгүй тохиолдолд нэн даруй эцэг эхэд мэдэгдэх, хүүхэд эрсдэлт нөхцөлд орсон тохиолдолд холбогдох ажилтанд мэдэгдэх, хүүхдийн эрх, хамгааллын нөхцөл байдлын үнэлгээг хийх, эцэг эхийн зөвлөл нь хүүхдийн эрх хамгааллын бодлоготой байх,

3. Цахим орчин дахь хүүхэд хамгааллын хүрээг өргөжүүлж, хэвлэл

мэдээлэл, өргөн нэвтрүүлэг, цахим орчинд хүүхдийг хортой, хориотой мэдээлэл, контентоос хамгаалах чиглэлээр холбогдох байгууллагуудын дотооддоо авч хэрэгжүүлэх арга хэмжээг зааж, цахим орчинд хүүхдийг урхихдах, дээрэлхэх, дарамтлахыг хориглох,

4. Соёл, спортын салбарт хүүхдийн оришин суугаа газраас өөр газарт 24 цагаас дээш хугацаагаар аливаа нэг арга хэмжээнд оролцуулсан тохиолдолд 15 хүүхэд тутам заавал 1 хүн харгалзан явах, бүх төрлийн хурдан морины уралдааныг зохион байгуулагч харьяа орон нутгийн захиргаанд мэдэгдэх. Уралдаанч хүүхдийн эрх аюулгүй байдлыг хангах хүрээнд морио уралдуулж байгаа морины өмчлөгчид үүрэг хариуцлага хүлээлгэх,

5. Гамшиг, онцгой байдлын нөхцөлд хүүхдийн амь нас, эрүүл мэндийг эрсдэлт нөхцөлд оруулан байгаа газраас нь авч явах болон тээвэрлэхийг хориглох,

6. Хүүхэд хамгаалал, удирдлага, зохион байгуулалтын хүрээнд хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн байгууллагад ажиллуулахыг хориглох.

Сум хорооны 3000 хүртэлх хүн амд 1 хүүхэд гэр бүлийн нийгмийн ажилтан байхаар тооцож ажиллуулах. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны дарга нь Засаг дарга, түүний орлогч, эсвэл хуулийн асуудал хариуцсан нэгжийн дарга байхаар, Хүүхдийн эрхийн хууль зүйн хороо болон хамтарсан багийн санхүүжилт, үйл ажиллагааны зардлыг харьяа газар, орон нутгийн төсвийн төсөлдөө заавал тусгаж, эрх бүхий этгээдүүдээр батлуулан хэрэгжилтэд хяналт тавих,

7. Хүүхэд хамгааллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, хяналтыг сайжруулах хүрээнд орон

нутаг нь хэрэгжүүлсэн ажлынхаа тайланг жил бүрийн 2 дугаар сард Хүүхэд гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлж, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл нэгтгэсэн тайланг хэлэлцэн дүгнэж, шаардлагатай тохиолдолд холбогдох этгээдэд чиглэл өгч ажиллах,

8. Тухайн шатын Засаг дарга хүүхдийн эрхийн олон нийтийн байцаагчийг баг, хороо бүрд ажиллуулж болохоор тус тус боловсрууллаа.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Баярсайхан хүүхдийн асуудал хариуцсан агентлагийн даргыг хэзээ томилох талаар асуулт асууж, хариулт авлаа.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил хуулийн төслийн 2.7 дугаар зүйлтэй холбогдуулан зарчмын зөрөөтэй санал гаргасан бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.19-д заасны дагуу цөөнх болж, нэгдсэн хуралдаанд саналаа тайлбарлаж, үг хэлэхээ илэрхийлсэн болно.

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг та бүхэнд хүргүүлсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Хууль хүчингүй болсонд тооцох тухай, Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүн худалдаалахтай

тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хууль зүйн туслалцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамингаас хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Онц байдлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлт, зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

С.Одонтуяа: Баярлалаа.

Мэндчилгээ дэвшүүлье. Өмнөговь аймгийн Говийн байгаль, түүхийн музейн ажилтнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийнхээ нэрийн өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе.

Ажлын хэсгийн гишүүдийн нэрийг танилцуулъя. Ирсэн гишүүд босоод өөрийгөө харуулаарай.

Нарантуяагийн Баярмаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Дугаржавын Ренчиндорж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хуулийн хэлтсийн дарга, Жаңцандоржийн Азжаргал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүүхдийн эрхийн хэрэгжилтийн бодлого зохицуулалт хариуцсан мэргэжилтэн, Пүрэвээгийн Баттулга Хуулийн зөвлөх,

өмгөөлөгч, Ганчулууны Оюунболд ЗГХЭГ-ын шинжээч, хуулийн зөвлөх, Начиндагвын Өлзийхутаг Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга, Батсүхийн Батсайхан Нийслэлийн Гэр бүл, хүүхэд хөгжлийн газрын Хүүхдийн хөгжил, хамгааллын хэлтсийн дарга, Жадамбаагийн Мягмар БШУЯ-ны ерөнхий боловсролын бодлогын удирдлага зохицуулалтын газрын СӨБ-ын хэлтсийн дарга, Батсуурийн Дуламсүрэн БШУЯ-ны шинжээч, Дарьбазарын Наранцэцэг Соёлын яамны Соёлын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Аюурзанын Өнөржаргал Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусламж, үйлчилгээний газрын дарга, Лхагвасүрэнгийн Нямдорж Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Хуулийн хэлтсийн дарга, Тойруулын Батболд Харилцаа холбооны зохицуулах хорооны зохицуулалтын бодлогыг хэрэгжүүлэх газрын дарга, Энхбаатарын Оюун-Эрдэнэ Цахим хөгжил, харилцаа холбооны яамны мэргэжилтэн, Андраа Уранчимэг Харилцаа холбооны зохицуулах хорооны ахлах мэргэжилтэн, Хүрэлбаатарын Мөнхзул Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн, Пүрэвээгийн Болормаа ЦЕГ-ын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, Санжаагийн Бат-Эрдэнэ ирсэн байна. Үндэсний Аудитын газрын Санхүүнийцлийн аудитын газрын аудитын ахлах менежер, Чойжилын Болд ирсэн байна. Үндэсний аудитын газрын Санхүүнийцлийн аудитын газрын аудитын менежер, Ганбаатарын Мөнхчимэг ирсэн байна. Үндэсний аудитын газрын Санхүүнийцлийн аудитын газрын аудитын менежер, Балжиннямын Жавзанхүү Хүүхдийн эрхийн сургалт, судалгааны үндэсний хүрээлэнгийн тэргүүн, судлаач, доктор.

Ажлын хэсгийн гишүүд бүгд 100 хувь ирсэн байна. Баярлалаа.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Нэр авъя, бүртгэе. Адыасүрэн гишүүнээр тасаллаа. Наянтайн Ганибал гишүүн асуулт асууя.

Н.Ганибал: Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын энэ асуудал дээр бас өмнөх хэлэлцэх эсэх дээр нь тодорхой асуудлуудыг ярьж байсан л даа. Тэгээд тэр асуудлууд маань ер нь хэрхэн орсон юм бэ. хэрхэн өөрчлөгдсөн бэ? Тоон дээр бол гишүүд олон байр сууриудыг илэрхийлж байсан.

Монгол Улс бол Ази соёлтой улс орон. Тэгээд Азийн соёл нь бусад улс орны соёлоосоо ялгагддаг нь болохоороо энэ гэр бүлийн хүмүүжлийн асуудал, гэр бүлийн тэр үнэт зүйлээ бусад үндэстнүүдээс илүүтэй хамгаалдаг, түүгээрээ хүмүүждэг, ийм соёлтой улс орон л доо. Тэгээд энэ асуудлууд дээр хэд хэдэн тийм тодорхойгүй асуудлууд байсан л даа. Энэ асуудлуудын нэг бол хүүхэд эцэг, эхээсээ татгалзах гэсэн ойлголт энэ хуульд орж ирсэн. Энэ асуудал маань өмнөхтэйгээ хэвээрээ байгаа юу? Ажлын хэсэг энэ дээр бас гишүүдийн саналуудыг сонсож, энэ татгалзах гэдэг ойлголт дээр ямар ойлголтыг өөрчилж, оруулж ирж байгаа вэ гэдгийг бас та бүхнээсээ асууя.

Ер нь Монголчуудын хамгийн чухал асуудал бол мэдээж хотынхон ба хөдөөгийнхөн гэдэг 2 ийм үндсэн уламжлалт соёл нь ингээд өөрчлөгдөөд явж байгаа. Мэдээж Улаанбаатар хотын иргэнишж байгаа энэ хотынхон бол магадгүй энэ Европ маягийн соёлыг бол нэлээдгүй хэмжээгээр тэр соёл руу шилжиж байна. Хөдөө орон нутгийнхан маань бол уламжлалт Монгол амьдралын хэв маяг, соёлтойгоо байгаа. Тэгэхээр энэ 2-ын хооронд бас зарчмын маш их зөрөөнүүд бол сүүлийн үед гарч ирж байгаа. Тэгээд энэ зөрөөг нэг л энэ хуулиар, энэ хууль нь болохоороо цууд утгаараа бас энэ Европын соёлыг хуулбарласан ийм хууль орж ирсэн

байсан. Тэгээд энэ дээр энэ зөрөөнүүдийг ер нь бас тодорхой хэмжээнд гаргах ийм боломж та бүхэнд бас, энэ ажлын хэсэг дээр та бүхэн үүнийг ярилцсан уу? Үүнийг хэрхэн шийдэх вэ? Эцэг эхээсээ татгалзах гэдэг нэр томъёоллын бас заалт дээр ямар нэгэн байдлаар хүчирхийлэлд өртөх гэж, хүчирхийлэл гэдэг нь өөрөө бас тодорхойгүй байсан. Энийгээ тодорхой болгосон уу? Үр хүүхдээ сурган хүмүүжүүлэхдээ ямар нэгэн алганы амт үзүүлснийхээ төлөө тэр хүүхэд гомдол гаргавал эцэг, эхээсээ татгалзах ийм боломж өмнөх та бүхний өргөн барьсан хууль дээр байсан л даа. Тэгээд энэ зарчмын зөрөөтэй саналууд хэлэлцэх байх. Энэ дээр бас энэ асуудлууд орсон уу гэдгийг бас тодруулъя.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Микийнхээ дугаарыг дээш нь өргөөд, Баярмаа дарга уу? 83 дугаар микрофоныг нээе. Баярмаа дарга хариулна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам.

Н.Баярмаа: Ганибал гишүүний асуултад хариулъя. Хүүхэд хамгааллын тухай хуульд бас үндэснийхээ үзэлд нь үзэл хүүхдээ хүмүүжүүлэх ёс заншлын асуудлыг бас тусгаач ээ гэдэг асуудал өмнөх хэлэлцүүлгийн үеэр яригдаж байсан. Гэхдээ хүүхдийн эрхийг хангах асуудал дээр бол эцэг, эхийн үүрэг хариуцлага байгаа. Түүхэн уламжлал ёс заншлаа хүүхдэдээ өвлүүлэн дээдлэх энэ асуудал бол Хүүхдийн эрхийн тухай хуулиараа эцэг, эхийн үүргийн тэр хэлбэрт туссан чиглэлээрээ явж байгаа. Хүүхэд хамгааллын тухай хуульд яг энд бол хүүхэд эцэг, эхээсээ татгалзана гэсэн ямар нэгэн заалт бол байхгүй байгаа. Харин энэ нийгмийн ажилтан нөхцөл байдлын үнэлгээ хийж, нөхцөл байдлын үнэлгээ дээрээ тулгуурлан хүүхдийг гэр бүлд нь асран хамгаалах эцэг, эхэд нь сургалт зөвлөгөө өгч, хүүхдийн сайн сайхан байдлыг хангахын төлөө хамтарсан баг болон нийгмийн ажилтнууд ажиллах чиг үүрэг нь байгаа. Хэрвээ үнэхээр гэр бүлдээ аюулын зэрэг нь өндөр байгаад эрсдэлт нөхцөлд орсон тохиолдолд цагдаагийн албан хаагчдын

аюулгүйн зэргийн үнэлгээ болон нийгмийн ажилтны нөхцөл байдлын үнэлгээ дээр тулгуурлаж одоо хүүхдийг гэр бүлээс нь тусгаарлаж, төрөл садны асрамжид түр хугацаагаар хамгаалуулах, төрөл садны ойр дотнын хүн байхгүй бол Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд заасан Нэг үзгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байранд байрлуулах, боломжгүй тохиолдолд бол асран хамгаалах, асран хүмүүжих, асрамж халамжийн байгууллагад нь холбон зуучлах гэсэн ийм үйлчилгээнүүдийг хуулийн төсөлд бол тусгасан байгаа.

Тэгээд хүүхэд хамгааллын энэ хуулийн гол зарчим болон үйлчилгээний гол зарчим бол ерөөсөө гэр бүл төвтэй хүүхэд хамгааллын асуудал байгаа. Гэр бүлд нь эцэг, эхтэй нь энэ хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулж, холбогдох эцэг, эхийн сургалтад хамруулах, хөдөлмөрт зуучлах, ажил орлоготой байх, эерэг харилцаатай байхад нь зөвлөн туслах замаар энэ хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан ажилладаг байх ийм үйлчилгээний гол зохицуулалтыг энэ хуульд хуулийн төсөлд орсон байгаа.

Тэгээд дээрээс нь нэмээд хэлэхэд Гэр бүлийн хуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл одоо бас хэлэлцэгдэж байгаа. Энд бол яг энэ гэрлэгчдийн эрх үүрэгт нь угийн бичгээ хөтлөх, хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, гэр бүлийн үнэт зүйл, үндэсний соёл, уламжлал, зан заншлыг хүүхдэдээ өвлүүлэх, эцэг эхийн чиг үүрэгт бол төрөлх бичиг үсэг, боловсрол эзэмшүүлэх, хүүхдийнхээ нас, сэтгэхүйн онцлогт нийцсэн аргаар уламжлалт арга болон хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлэх гэсэн энэ заалтууд бол эцэг, эхийн үндсэн болон журамт үүрэг гэсэн ийм агуулгатайгаар явж байгаа гэдгийг хэлье.

С.Одонтуяа: Ганибал гишүүн тодруулья.

Н.Ганибал: Түрүүний миний асуудал чинь нөгөө нэг Гэр бүлийн тухай

хууль гээд бас өөр хуулиар зохицуулагдах гээд орж ирж байсан юм байна. Тэгэхээр Хүүхэд хамгааллын хуулийн асуудал дээрээ бол яах вэ, одоо нөгөө нэг нийгэмд болж байгаа энэ олон асуудлуудыг хариулт болгож, зөв тийш нь одоо залах гэж явж байгааг л харж байна л даа. Энэ зарчмын зөрүүтэй оруулж ирж байгаа санал болгон дээр бол бас тодорхой шийдэлтэй ийм заалтууд орж ирж байгаад нь бас талархаж байна.

Тэгээд ер нь бид нарын үндсэн энэ амьдралын хэв маяг дээр бол бид нарт 2 янзын энэ амьдралын хэв маяг бий болсон шүү. Энэ ер нь зүгээр энэ дээр бол бид нар маш сайн анхаарч явах бас энэ хуулиуд дээрээ тусгах зайлшгүй шаардлага байгаа. Тэгэхээр уламжлалт гэр бүлийн энэ харилцааг бид нар олон нийтэд сурталчлах, өнөөдрийн бид нарын олон жил явсан энэ үндсэн амьдралын хэв маягаа бас улам илүү тод болгож байж бид нар бас дэлхий нийтэд өөрийн гэсэн үндсэн тэр гэр бүлээ хайрлах энэ соёл цааш нь үргэлжлээд явах байхаа гэж бодож байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Ажлын хэсгийн дарга Ц.Идэрбат гишүүн нэмж хариулах гэсэн юм уу.

Ц.Идэрбат: Хүүхэд хамгааллын хуулийн өргөн барьснаас хойш ажлын хэсэг гарч нэлээдгүй бас ажлуудыг хийсэн. Энэ дээр бол яг хүүхэд хамгаалалттай холбоотой энэ Монгол Улсад гараад байгаа энэ одоо мөрдөгдөж байгаа хуулиа цааш нь чамбайруулахаас гадна энэ янз янзын кэйс тохиолдол бол гарах болгонд ингээд л нэг хяналтын сонсгол, тэгээд л гишүүд өргөн бариад л янз янзын сонсголдууд хийгээд л тэндээс ингээд л зөвлөмж юмнууд гараад л энэ болгоныг бас нэгтгээд, мөн тэр Монгол Улсын Алсын хараа, мөн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр гээд энэ бүх зүйлүүдээс тусгахаас гадна яг энэ хүүхэд хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа энэ төрийн бус

байгууллагууд, дээрээс нь яг энэ Монгол Улсын төрийг төлөөлөөд хүүхэд хамгаалах үйл ажиллагааг энэ анхан, дунд шатад явуулж байгаа бүхий л энэ субъектүүдтэй бид цахимаар болон танхимын уулзалтуудыг зохион байгуулж нэлээн юмнууд гаргаж ирсэн. Энэ дээр ер нь бол яах вэ, эцэг эхээсээ татгалзах, эцэг, эхийг түдгэлзүүлэх, татгалзах, эцэг, эх байх эрхийг нь хасах гээд ийм зүйл заалт бол явж байгаа. Эцэг, эхээс татгалзах гэж бол байхгүй. Шүүхийн шийдвэрээр эцэг, эх байх эрхийг нь хасна гэсэн ийм зүйл заалт. Тэгээд амьдрал дээр бол энэ ч гэсэн бас нэлээн асуудал дагуулдаг болсон юм байна. Үнэхээр өөрийнхөө хүүхдийн эцэг, эхээс татгалзчихаад, дараагийн шинэ амьдрал эхлүүлээд нөгөө энэ амьдралынхаа хүүхдүүдийг асрамжийн газарт өгөөд бүр бүгдийг нь өгөөд явчихсан тохиолдол ч бас байдаг юм байна. Тэгэхээр нөгөө нэг бидний үхтэл үр харам гэдэг энэ Монгол философи бас зарим үед алдагдаад байгаа ч юмнууд байгаа юм байна. Тийм учраас энэ олон хэлэлцүүлэг юмнуудаас бол энэ хүүхдийг ер нь хүүхдийн хүмүүжил энэ хүүхэд хамгаалалд эцсийн эцэст явж явж энэ эцэг, эхийн үүрэг роль гэдэг чинь туйлын чухал юм байна. Эцэг, эхийн үүрэг ролийг бид нар бас хариуцлагажуулж өгөх ёстой юм байна. Энэ миний хүүхэд, үүнийг би яасан ч болно гэдэг энэ хандлагыг өөрчлөх ёстой юм байна гэсэн үндсэн концепц бол бас энэ хуулийн нэг том шинэчлэл энд явж байна.

Дээрээс нь соёлын зөрүү гарч байна гээд ийм зүйлүүд байгаа. Ер нь бол яах вэ, хүүхдийн энэ нийгмийн хөгжлөө дагаад уламжлалт гэж бодож байсан тэр зүйлүүд эргээд хүүхдүүддээ хүлээн зөвшөөрөгдөхгүй болж байгаа юмнууд ч бас их байгаа юм байна лээ. Магадгүй бидний үед алганы боов гэж яриад л ингээд л нэг амсчихвал чих нь зөөлрөөд явдаг байсан гэдэг бол одоогийн хүүхдүүдэд тийм байдлаар хандвал сэтгэл зүйн гэмтэл гаргадаг. Тэр нь насан туршид нь тэр мартагддаггүй хар бараан дурсамж болж үлддэг эд нар гээд

ингээд олон зүйлүүд бас байгаа юм байна лээ гэдгийг бас хэлье.

Сургууль доторх үе тэнгийн дээрэлхэлтийн асуудлууд ч гэсэн бас энд нэлээн хурцаар яригдаж орж ирэх юм байна лээ. Энэ бол хот, хөдөө гэхгүйгээр бий болчихсон юм байна гэдгийг энэ хуулийн хэлэлцүүлгүүдийн явцад орон нутагт ажиллаж байгаа, энэ хүүхэд хамгааллын багт ажиллаж байгаа нөхдүүдийн ч бас хэлж байгаа кэйсүүд бол үүнийг илэрхийлээд байгаа юм. Улаанбаатар хотод бол улсын сургууль, хувийн сургууль ч гэдэг юм уу, энэ бас л их тодорхой болоод нэг сар гаруйн өмнө нэг жишээ байгаа шүү дээ. Дээрэлхэлд өртсөн эсэхийг яах юм, ямар хариу арга хэмжээ авах юм эсвэл сургууль нь дараад өнгөрөх юм уу эд нар гээд. Ийм зүйлүүдийг ер нь төрийн бодлогод орсон зүйлүүд энэ Улсын Их Хурлаас гаргасан тогтоол шийдвэрүүд, дээрээс нь амьдрал дээр гарч байгаа энэ хүндрэл юмнуудыг шингээсэн хүүхэд хамгааллыг бас нэлээн цогц утгаар нь харахыг хичээсэн ийм хууль болсон гэж бас тайлбар нэмж хэлье.

С.Одонтуяа: Баярлалаа. Одоо Амгалангийн Адъяасүрэн гишүүн асуултаа асууна.

А.Адъяасүрэн: Энэ Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийг бол дэмжиж байгаа. Ингээд ажлын хэсгийн дарга Идэрбат гишүүнээс асуулт асуух гэсэн юм. Би энэ 2023 оны 11 сарын 16-нд танд нэг албан бичиг явуулсан байгаа. Энэ дээр болохоор энэ Төслийн 6 дугаар зүйлийн 6.1.6-д хуулийн этгээд нь өөрийн цалингийн нийт сангийн нэгээс доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг хүүхэд хамгааллын бодлогод зарцуулж байхаар заасан чухал заалт гэж үзэж маш дэмжиж байгаа. Гэхдээ үүнтэй холбоотойгоор нэг чухал ач холбогдол бүхий зохицуулалтад энэ малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид болоод албан бус эдийн засагт ажилладаг хүмүүсийн хүүхдүүд энэ

хүүхэд хамгаалалд зарцуулах хөрөнгийн асуудал орхигдож байгаа энэ асуудлыг нь үндэс болгоод 6.1 дээр 6.1.7 гэдэг дээр би бас зарчмын зөрүүтэй саналыг таныг дэмжиж өгөөч гэж албан бичиг явуулсан юм. Энэ дээр 6.1.7 дээр албан бус эдийн засагт ажиллаж байгаа малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн хүүхэд хамгааллын зардалд зарцуулах мөнгөн хөрөнгийг энэ зүйлийн 6-д хэсэгт заасан зориулалтаар аймаг, сум, нийслэл, дүүргийн төсөв болон хамтын хэлэлцээрт тусгаж хэрэгжүүлнэ гэдэг энэ заалтыг оруулж өгөөч ээ гэж энэ тан руу 11 сарын 16-нд албан бичиг явуулсан байгаа. Энэ дээр ямар байр суурь баримталж байна вэ? Энэ зарчмын зөрүүтэй санал хураалтад орох уу? Үүнийг надад тодорхой хариулж өгөөч?

С.Одонтуяа: Ажлын хэсгийн дарга Идэрбат гишүүн хариулъя.

Ц.Идэрбат: Хууль дээр хүүхэд хамгааллын зардалтай холбоотой нэлээдгүй зарчмын том өөрчлөлтүүд орж ирж байгаа. Нэгдүгээрт, төрийн болон бүх байгууллагууд цалингийн сангийнхаа бас нэг хувийг хүүхэд хамгааллын зардалд тусгах ёстой гэсэн нэг ийм заалт байгаа. Гэхдээ ийм заалт бас ахмадын хууль дээр байгаад, эргээд аудитын байгууллага энэ дээр ялангуяа улсын төсвөөс санхүүжиж байгаа босоо удирдлагатай газруудад бас хэрэгжихгүй ийм бас нэг хаалт гараад байдаг. Орон нутагт бол үүнийг орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа байгууллагууд бол бас тодорхой хэмжээнд шийдээд явчихдаг ийм зүйл байгаа. Гэхдээ ажлын хэсэг дээр үүнийг нэлээн яриад, аудитын байгууллагаас ийм хаалт хийх бас бололцоо гарахгүй ээ. Энэ ингээд хэрэгжээд явна гэсэн байдлаар шууд тусгаад ингээд явсан байгаа. Нэг хүүхэд хамгаалалттай холбоотой зардал.

Хоёрт, таны хүсэлт дээр албан болон албан бусаар ажиллаж байгаа хувиараа хөдөлмөр эрхлэгчийн гээд хүүхдийн асуудал байгаа. Тэгээд энэ дээр хүүхдийг хөдөлмөр хийлгэхэд бол

Хөдөлмөрийн тухай хууль дээр 13-16 насны хүүхдээр хөнгөн хөдөлмөр хийлгэж болно оо л гэсэн тийм зүйл заалттай. Тэр нь тусгай зохицуулалттай ингээд явж байгаа юм байна лээ.

Нөгөө талаасаа энэ дээр бол аймаг орон нутгийн төсөв хамт төсөвт тусгаж өгөөч ээ, аймаг орон нутгийн төсөвт тусгаж өгөөч ээ гэсэн ийм зүйл заалт байгаа. Бидний хувьд бол ер нь энэ хүүхэд хамгааллын үйл ажиллагаа өнөөдөр бас доголдож байгаа одоо байгаа бүтэц маань бүрэн 100 хувь ажиллаж чадахгүй байгаагийн шалтгаан бол энэ төсөв хөрөнгөтэй шууд холбоотой байдаг. Би бол бас сумын хамтарсан багийг ахалж ажиллаж байсан хүний хувьд бас олон зовлонг бас мэднэ.

Тийм учраас энэ хууль дээр бид бүхэн энэ анхан шатад болон дунд шатад энэ хүүхэд хамгаалалтай холбоотой тэр дундаа бүр анхан шатад хамтарсан багийн үйл ажиллагааны зардлыг тухайн нэгжийн төсвийн төслийг тухайн шатын ИТХ-д 11 сарын 24-ний өдөр өргөн барихдаа төсвийн төсөлд нь тусгаад оруулах ёстой гэсэн ийм зүйл заалтыг оруулж өгч байгаа юм. Тэгэхээр яах вэ, төсвийн төсөлд гэж зориуд тусгаж өгсний учир шалтгааныг ойлгож байгаа байх. Төсөв хэлэлцээд эхэлсний ард дээр хаа нэгтээгээс энд тэндээс нэг жижиг, сажиг мөнгө хамж ирээд зардал тавихгүйгээр төсвийн төслөө өргөн барихдаа мөнгөө тавьчихсан, хүүхэд хамгааллын үйл ажиллагаа найдвартай, жигд, тасралтгүй явах энэ бололцоог л энэ төсвийн бодлого дээр бас тусгаж өгсөн байгаа. Тэгэхээр үндсэндээ хүүхэд хамгааллын зардалтай холбоотой ийм 2 зүйл байгаа. Хүүхдийн хөдөлмөртэй холбоотой асуудлыг бол төсөв дээр тавих бололцоо байхгүй. Гэхдээ энэ бол Хөдөлмөрийн хуулиараа 3 талт хэлэлцээрээрээ хүүхдийн аюулгүй байдлыг хангахаас авхуулаад ийм бэлэн зохицуулалтууд бол бас байдаг юм билээ гэж би гишүүнд хариулъя.

С.Одонтуяа: Сарангэрэл гишүүн асуултаа асууна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Энэ Хүүхэд хамгааллын тухай хууль маань нөхцөл байдал, цаг үе их хурдан өөрчлөгдөж байгаа учраас мөн дагаад бас өөрчлөлтүүд хийх шаардлагууд байн байн гарч байгаа. Тэгээд УИХ дахь 13 эмэгтэй гишүүн бол энэ хүүхэд хамгааллын чиглэл дээр онцгойлон анхаарч ажилладаг. Тэр дундаа Баярсайхан гишүүн маань бол энэ хүүхэд хамгааллын асуудлыг, Жаргалмаа гишүүн маань ахмадын асуудлыг гээд ингээд бид нар дор бүрдээ бас сэдвийн асуудлаа хуваарилж аваад ингээд ажилладаг юм. Тэгэхээр бол энэ Хүүхэд хамгааллын хууль бол Улсын Их Хурлын 13 эмэгтэй автортай ийм хууль. Манай Одонтуяа дарга маань ахлаад Хүүхэд хамгааллын хуулийн төслийг шинэчлэн найруулах, өөрчлөх энэ асуудлыг бас мөн дэвшүүлж тавиад бид бас өргөн барьсан. Тэгээд 1 хэсэг энэ хуулийн төсөл Хууль зүйн яам дээр эсвэл Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам дээр гээд харьяалал нь тодорхойгүй явж явж ингээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол Засгийн газрын шугамаар өргөн бариад ингээд өнөөдөр орж ирж байна. Энэ хуулийн төслийг бол бид нар эхнээс нь ажилласан учраас бол дэмжиж байгаа.

2 дугаарт, миний хэлэх гэж байгаа зүйл бол Адьясүрэн гишүүн ээ, миний нэг хэлэх гэж байгаа зүйл бол та бүхэн маань 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдөр юу болсныг мэдэж байгаа тийм ээ. Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо Сутай хотхонд гал түймэр гарч, 6 ам бүлтэй айлын 4 хүн нас барж, улмаар төрийн албан хаагч нэгэнтээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр ил болсон болохоор би хэлье. Хөөрхий талийгаачийн гэр бүлийн эзний эгч нь бас хамт ингээд амиа алдсан байдаг. Тэгээд өнөөдрийн байдлаар бол энэ гэр бүлийн нөхцөл байдал маш хүнд байгаа. 4-ийн 4 хүнээ алдаад Даваа гарагт хөдөөлүүлнэ гээд байж байтал, хайхрамж болгоомжгүйн улмаас бусдын эд хөрөнгөд хохирол

учруулсан, энэ хохирлыг барагдуул гэдэг ийм том дарамтад орчихоод байж байна. Өнөөдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайд, мөн энэ хүүхэдтэй холбоотой бүх байгууллагын төлөөлөл, ажилтнууд ингээд та бүхэн маань өөд өөдөөсөө хараад 10 хүн сууж байна шүү дээ. Би та бүхнийг хариулт өгөөсэй гэж хүсэж байна. Энэ гэр бүлийнхэн 4-ийн 4 хүнээ алдчихсан, тэр улсуудын хохирлыг барагдуулах нь битгий хэл, өөрсдөө орох оронгүй болчихсон байгаа юм. Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд нийгмийн ажилтнууд, байцаагчид байгаа. Энэ гэр бүл дээр очсон уу? Энэ хүмүүсийг яаж орон гэртэй болгох вэ? Бид яг энэ хуулийг л яриад өнөөдөр байж байна шүү дээ. Энэ асуудлыг яах вэ?

Дээр нь тэр орцны, 10 давхар байрны орцны айлууд тэр тортогтой болсон, амьдрах аргагүй тийм орчин нөхцөлд бид нар байна гээд ингээд бас орцондоо засвар үйлчилгээ хийлгэх ийм шаардлагуудыг тавиад ингээд нэг гэр бүл 4 хүнээ алдсанаас гадна ийм олон давхар дарамтад орчихсон. Манай цагдаагийн байгууллагын төлөөлөл, Хүүхэд гэр бүл залуучуудын газрын төлөөлөл, Булгаа сайд, та бүхэн маань энэ дээр судалгаа хийсэн үү? Ийм нөхцөлд төр ямар арга хэмжээ авдаг юм бэ? Энэ гэр бүлийг, энэ орон сууцыг хэрхэн яаж анхаарч байна вэ? Хууль, эрх зүйн орчин нь ямар байгаа вэ? Энэ талаар та бүхэн надад нэг хариулт өгөөч. Тэгээд би дараа нь тодруулъя. Баярлалаа.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Микрофоноо өргөөд. 81 хариулъя. Өлзийхутаг дарга.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүрэг гүйцэтгэгч Өлзийхутаг байна. Энэ үнэхээр харамсалтай зүйл болсон. Одоогоор бас энэ шалгах ажиллагаа бол явагдаж байгаа. Тэгээд энэ дээр бид нарт бас нэг давхар бас маш харамсалтай зүйл нь манай СБД-ийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэргэжилтэн энэ байрны 6

давхарт амьдардаг байсан хүн. Хүүхдийн амь аврах гэж 4 давхрынхаа айл руу ороод мөн угаарт хордож бас амь насаа алдсан ийм давхар гишүүдалтай зүйл бол болсон. Тэгээд бид бүхэн бас энэ гэрийн аюулгүй орчныг хангах чиглэлээр “хамтдаа шалгая, хамгаалъя” гээд арга хэмжээг бас энэ 2023 оны 10 сарын 26-наас 11 сарын 26-ны хооронд бүтэн сарын хугацаанд явуулсан. Эцэг, эхчүүдэд бид нар бас гэрийнхээ аюулгүй орчныг хэрхэн хангах вэ. Миний гэрийн аюулгүй орчин гээд ийм цахимаар болон бусад постер зөвлөмж, иторк хүргүүлэх гэх мэтчилэнгээр ингээд ажиллаж, олон байгууллага, эцэг, эхчүүд бол энд оролцсон. Тэгээд цахим асуулт явуулахад хүртэл 170 гаруй мянган эцэг, эхчүүд энд хамрагдаж ер нь бол бид нар энэ чиглэлээр нэлээдгүй ажлуудыг бол зохион байгуулж ажиллаж байгаа. Тэгээд одоо манай Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс маань энд очиж ажиллаж байна. Эхний ээлжид сэтгэл зүйн зөвлөгөө өгөх бас гэр бүлийн гишүүдтэй уулзах, тэгээд хүүхэд хамгааллын мэргэжлийн ангиуд бас ажиллах, төлөвлөгөө гаргаж бид бас хүүхэд хамгааллын үйлчилгээг үзүүлэхийн тулд төлөвлөгөө, нөхцөл байдлыг, эрсдэлийг үнэлээд төлөвлөгөө гаргадаг. Тэгэхээр энэ төлөвлөгөөнийхөө дагуу манай орон нутгийн хэлтэс маань бас энэ дээр ажиллаж байгаа.

С.Одонтуяа: Сарангэрэл гишүүн тодруулъя.

Д.Сарангэрэл: Өлзийхутаг дарга аа, би хийж байгаа ажлаа тоочоод орхи гээгүй шүү дээ. Яг энэ тохиолдолд энэ гэр бүлд учирсан энэ уй гашуу, хор хохирлыг бага ч гэсэн нимгэлэхэд бид ямар үйл ажиллагаа явуулах ёстой вэ л гэдгийг асуусан. Баярмаа дарга яамнаас хариулах уу? Энэ айл байна шүү дээ, Баярмаа дарга аа, 6 ам бүлтэй айл. Нөхөр нь нэг охинтойгоо л үлдчихсэн. Юун тэр ойр хавийн айлын хохирол барагдуулах. Өөрсдөө орох оронгүй болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бид нар энд чинь цагдаагийн байгууллагын төлөөлөл,

хүүхэд, гэр бүл, залуучуудын газрын төлөөлөл, яам ингээд бүхэлдээ байж байна шүү дээ. Ийм нөхцөлд яадаг юм бэ, энэ гэр бүлийг бид яах вэ гэдгийг л би та бүхнээс асуугаад байна шүү дээ. Ямар хууль, эрх зүйн орчин байна? Ямар үйлдэл та бүхэн хийж чадах вэ. Тэрийгээ нэг надад хэлээд алиач.

С.Одонтуяа: Баярмаа дарга хариулъя. 83.

Н.Баярмаа: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Үнэхээр харамсалтай тохиолдол болсон. Тэгээд энэ нь яг энэ тохиолдол бол манай Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу онцгой нөхцөл байдлын хүүхдийн эрхийг хамгаалах журмыг 2019 онд бид нар баталсан. Аймаг, дүүрэг болгонд яг ийм тохиолдолд хүүхдийн эрхийг хамгаалах мэргэжлийн ангиуд байгуулагдаад газар, хэлтсийн даргаар ахлуулсан ангиуд ажиллаж байгаа. Тэгээд яг энэ тохиолдол дээр бол манай Хан-Уул дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хэлтсийнхэн бол үнэлгээ хийгээд ажиллаж байгаа. Одоогоор бол үнэхээр сэтгэл зүйн хувьд маш хүндрэлтэй байгаа учраас сэтгэл зүйн туслалцаа үйлчилгээ авахад ч гэсэн хүндрэлтэй байна гэгчихсэн байгаа. Яг ийм тохиолдолд бол Нийгмийн халамжийн тухай хуулиар гамшиг ийм онцгой тохиолдолд орон гэргүй болсон хүмүүст бас онцгой тохиолдлын болон амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийг олгодог. Гэнэтийн аюул осол, урьдчилан төсөөлөх боломжгүй бусад шалтгаанаар гэр оронгүй гэр нь цаашидаа амьдрах боломжгүй болсон тохиолдол бол... /минут дуусав/

С.Одонтуяа: Баярмаа дарга гүйцээгээд хариулъя.

Н.Баярмаа: Амьжиргааны эх үүсвэрээ алдсан өрх, иргэнд бол энэ онцгой тохиолдлын тэтгэмжийг олгодог байгаа. Тэгээд яг одоогийн байдлаар Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу сая 200 мянган төгрөгийн тэтгэмж байгаа. Энэ дээр бид нар бас

нийгмийн халамжийн нөгөө мэргэжлийн анги дотор нийгмийн халамжийн газар, хэлтэс маань ажилладаг. Тэгээд нийгмийн халамжийн газар, хэлтэстэйгээ Хүүхэд, гэр бүлийн газар, хэлтэс хамтарч нийгмийн тусалцаа дэмжлэгийг үзүүлэхээр ажиллаж байна.

Яг ийм тохиолдлын үед энэ хүүхдийн асуудлыг яах вэ гэдэг асуудал дээр бас энэ Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гамшиг онцгой нөхцөл байдлын үе дэх хүүхэд хамгаалал гэсэн ийм бас нэг дэд зүйл орж ирсэн байгаа. Энд эцэг, эх нь бас энэ хүүхдээ аюул осолтойг мэдсээр байж байж бас авч явах, хүүхдээ бас ийм тохиолдолд орхих ийм зүйл заалтууд байна. Дээрээс нь нэмээд яг гамшиг, онцгой үеийн хүүхэд хамгааллын үйлчилгээг ямар нэгэн саад бэрхшиэлгүй явуулах зэрэг ийм зохицуулалтууд орсон.

Мөн гэр бүл дэх хүүхэд хамгаалал гэсэн энэ зүйл дээр бас яг эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, анхаарал болгоомжийг нэмэгдүүлэх үүднээс бас эцэг, эхчүүд маань гэр орондоо хүүхдийн аюулын эрсдэлийн үнэлгээг цахилгаан, тог, дулаан байр орчиндоо эрсдэлийн үнэлгээг хийдэг байх, дээр нь нэмээд хүүхэд, гэр бүлийн байгууллагууд энэ дээр нь зөвлөгөө мэдээлэл өгдөг байх ийм шинэлэг заалтуудыг бас оруулсан байгаа гэдгийг хэлье.

С.Одонтуяа: Тодруулж асууя, Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Одонтуяа даргадаа баярлалаа. Үнэхээр, энэ бол бас бид ярих ёстой. Хүний уй гашиу тохиолдсон энэ асуудлыг бид бас хуваалцах ёстой. Тийм учраас би Өлзийхутаг дарга, Баярмаа дарга нарыг энэ чиглэлээр хууль номын дагуу ямар арга хэмжэ хэмжээ авснаа Улсын Их Хурлын гишүүн миний нэр дээр бичгээр ирүүлэхийг хүсье. Баярлалаа.

С.Одонтуяа: Гишүүд асуулт асууж дууслаа.

Одоо 55 саналын томъёололтой, санал хураалт явуулъя. Булгаа дарга аа, хүмүүс чинь хурч байна уу?

Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулга. Анхны хэлэлцүүлэг хийгдэх гэж байна. Маши чухал хууль шүү. Гишүүд танхимдаа цуглая.

2021 оны 03 дугаар сарын 08-ны өдөр эмэгтэй гишүүдийн бүлгээс бас Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг өргөн барьсан байгаа. Энэ нэмэлт, өөрчлөлтийг Засгийн газраас Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгатай хамтран хэлэлцэхээр хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн. Ажлын хэсгийн энэ бүх саналыг үзэхэд бол бид нарын тавьж байсан тэр саналууд бүгд орсон байна гэж харсан.

Тогтохоо дарга аа, танай намын бүлэг дэмжихгүй байгаа юм уу, энэ хуулийг. Гишүүдээ дууд л даа. Та нар нөгөө тойрог яачихсан чинь гишүүд чинь тойрог руугаа явчихсан юм биш биз дээ.

Засгийн газар оруулж ирж байгаа. Энэ Засгийн газрын гишүүд чинь дэмжихгүй байгаа юм байна шүү дээ, дуудчих.

Энэ гишүүд цуглалал Идэрбат дарга аа, ажлын хэсгийн дарга аа, нэг юм танаас тодруулчихъя. Энэ төслийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хасах гэж байгаа байхгүй юу. Тэгээд би энэ Үндсэн хууль дээр нь харахаар энэ хурдан морь унаач хүүхдүүдийн асуудалтай холбоотой зүйл орсон юм байна. Тэгсэн, үүнийг хасчхаж. Үүнийг ер нь яагаад хассан юм, та нэг тайлбарлах уу? Уг нь их чухал заалт л байх юм. Тэгээд энэ яагаад хасагдчихав.

Идэрбат гишүүн хариулъя.

Ц.Идэрбат: Тийм. Энэ хуулийн төсөл дээр бол энэ 4 дэх заалт болоод үндэсний морин спорттой холбоотой, мөн үндэсний морин спортын үеийнх

хүүхэд хамгааллын асуудал гээд ингээд орж ирсэн юм байгаа юм. Гэхдээ энэ Хүүхэд хамгааллын хуулийн бид яг хүрэн дээр ганцхан үндэсний морин спортыг онцолж үзэх шаардлага байхгүй ээ. Спорт гэж үзвэл бүх л спорт эрсдэлтэй. Амьдрах орчин нөхцөл яривал өнөөдрийн энэ гарч байгаа жишээ, энэ бүх юмнууд бидэнд харуулж байгаа. Тийм учраас хуулийн хүрээ бол өргөн хүрээтэй байна гэж ингэж үзээд хасаад, гэхдээ энэ дотор спорт, соёл гэсэн бүлэг дээр энэ үндэсний морин спорттой холбоотой нэлээн том олон заалтууд орсон байгаа. Нэлээн хариуцлага юмнуудыг нь бас нэлээн тодруулж өгсөн байгаа. Жишээ нь яах вэ, үндэсний баяр наадмын үеэр морин уралдаан юм зохион байгуулахад энэ бүх л сум, аймаг, улсгүй л зохион байгуулалтад ордог. Жишээ нь овооны, үсний, одонгийн гэдэг юм уу, ийм уралдаануудын үеэр хүүхдийн амь нас бол эрсдэж байна. Үүнийг ямар нэгэн байдлаар мэдэгдэхгүй хийж байгаа ийм тохиолдлууд байна. Тийм учраас ер нь энэ уралдаануудыг заавал тухайн орон нутгийнхаа захиргаанд мэдэгдэж байх ёстой. Мэдэгдсэний үндсэн дээр тэр төрийн хүүхэд хамгааллын үйлчилгээ тэнд ажиллах ёстой. Тэнд нөгөө хүүхдийн хамгаалал, нөгөө хантааз малгай гээд л энэ бүх юмнуудыг хийлгэх ёстой гэсэн ийм л юмнууд бол бас орсон байгаа.

Тэгэхээр яах вэ, энэ 4 дээрээс хасдаг нь бол ийм олон өргөн хүрээний асуудлыг бид зөвхөн үндэсний морин спорт гэдгээрээ ингэж энэ дээр оруулж ирэх нь зохисгүй юмаа л гэж ингэж тийм агуулгаар хасагдаад хойшоо бол орсон. Нэлээн дэлгэрэнгүй орсон байгаа.

С.Одонтуяа: Санал хураах уу?

Нийгмийн бодлогын байнгын хорооны дэмжсэн саналуудаар санал хураая.

1.Төслийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат ажлын

хэсгийн дарга, П.Анужин, Б.Баярсайхан, Б.Бейсен, Б.Жаргалмаа. Цаашид ажлын хэсэг гэх. Санал хураалт.

Бейсен гишүүн горимын санал гаргая.

Б.Бейсен: Би дэмжсэн санал өгөх боловч ингээд дахин санал хураалгаж өгнө үү.

С.Одонтуяа: Бейсен гишүүн дэмжиж өгсөн боловч эсрэг гарчихлаа. Горимын саналаар санал хураая. Саяын хураасан саналыг хүчингүй болгохыг дэмжиж байгаа гишүүд саналаа өгье. Санал хураалт.

57,5 хувь дэмжсэн учраас саяын хураасан санал хураалтыг хүчингүйд тооцлоо. Дахин санал хураалт явуулъя.

Төслийн 1.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Одоо гишүүд анхааралтай байна шүү. Санал хураалт. Хонх дуугарсны дараа.

59 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын учруулахуйц үл хайхрах гэснийг учруулах гэж өөрчилж, мөн заалтын сэтгэл санаа гэсний дараа эдийн засаг гэж, мөн зүйлийн 1.12 дахь заалтын кэйс менежмент гэсний өмнө тохиолдлын зохицуулалт гэж тус тус нэмж, 1.11 дэх заалтын хүүхдийн эцэг, эх болон хүүхдийн эцэг, эхтэй гэрлэсэн хүн ороогүй, түүнчлэн гэснийг мөн зүйлийн 2 дахь хэсгийг тус тус хасаж, мөн зүйлийн 1 дэх хэсэгт дор дурдсан агуулгатай 1.6, 1.15, 1.16 дахь заалтыг тус тус нэмэх.

1.6. Хүүхдийг үл хайхрах гэж хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч үүрэг хүлээсэн бусад этгээд хүүхдийн аюулгүй байдал, бие махбод, эрүүл мэнд, сэтгэл санаа, боловсрол, хөгжлийн хэрэгцээг гачигдуулсан, асран хамгаалах үүргээ

биелүүлээгүйн улмаас хүүхдийг эрсдэлт нөхцөлд оруулсныг,

1.15 Хориотой агуулга гэж хуулиар хориглосон контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг,

1.16. Хүүхдэд хортой агуулга гэж хуулиар хориглоогүй боловч хүүхдийн эрүүл мэнд, нас, бие махбод, оюун санаа, ёс суртахууны хөгжил, төлөвшил, хүмүүжилд сөргөөр нөлөөлөх контент, бүтээл, мэдээ, мэдээлэл, зар сурталчилгааг. Санал гаргасан ажлын хэсэг, санал хураалт.

60 хувийн саналаар санал дэмжигдлээ.

3 дахь санал. Төслийн 1.5 дугаар зүйлийн 1.5 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн хүүхдэд зааж сургахдаа гэснийг хүүхэдтэй харилцахдаа гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

4. төслийн 2 дугаар бүлэг гэснийг 4 дүгээр бүлэг гэж өөрчилж, 2.1 дүгээр зүйл доор дурдсан агуулгатай 5 дахь хэсэг нэмэх.

5.Хүүхдийн эсрэг болон хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, эрүүгийн хариуцлага хүлээсэн хүнийг хүүхдийн эрх, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлдэг байгууллагад ажиллуулах, хүүхэдтэй холбоотой ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Үгүй ээ, тийм хүнийг ажиллуулахгүй гэж байгаа, харин. Тийм гэмт хэрэг үйлдсэн этгээдийг. Энхболд гишүүний үгийг микрофонд унших уу.

52,5 хувиар санал дэмжигдлээ.

5. төслийн 2.4 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтыг хасаж, мөн зүйлийн 1.4 дэх заалтын этгээдийг гэснийг этгээдэд тавигдах шаардлага гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

55 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6. Төслийн 2.4 дүгээр зүйлийн 1.5, 1.6 дахь заалтыг 2.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт шилжүүлж, 1.16, 1.17 дахь заалт болгох. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

52,5 хувиар санал дэмжигдлээ.

7 дугаар санал. Төслийн 2.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн мэргэжлээр дээд боловсролтой гэснийг эсхүл боловсрол, нийгмийн ухааны чиглэлээр дээд боловсрол эзэмшиж гэснийг өөрчилж, мөн зүйлийн 2.3 дахь заалтын үнэлгээ хийх гэсний дараа дүгнэлт гаргах гэж, мөн зүйлийн кэйс гэсний өмнө тохиолдол гэж тус тус нэмж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.9 дэх заалт нэмэх.

2.9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр оролцох. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Асуулт байхгүй үг хэлж болно. Үгүй ээ, түрүүн асуучихсан таныг ирэхээс өмнө. Дэгийн хуулиараа эхлээд асуулт асуусан. Одоо саналууд дээр асуулт байхгүй.

Учрал Засгийн газрын гишүүн эсрэг. Энэ хүүхдийн хууль учраас анхааралтай. Учрал гишүүн горимын санал гаргана.

Н.Учрал: Энэ Хүүхэд хамгааллын хуулийг дэмжиж байгаа тэгээд Идэрбат гишүүний ажлын хэсэг сайн ажилласан байна. Тийм. Сая уг нь дэмжсэн тэгээд дэмжээгүй л гарчихсан байна. Тэгээд дахин санал хураалгаж өгөөч.

С.Одонтуяа: Учрал гишүүний горимын саналыг дэмжье гэсэн гишүүд саналаа өгье. Саяын саналыг хүчингүй болгохоор. Санал хураалт.

59 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

7 дугаар саналыг түрүүн уншиж, танилцуулсан. Одоо санал хураана. Энэ хууль манай бас эмэгтэй гишүүдийн өргөн барьсан хууль учраас бид нар бас бүгд дэмжээд байгаа шүү. Та нар бас хамтарч хэлэлцэж байгаа хууль юм байгаа юм. Үгүй ээ, тэгээд л хүүхдийн асуудал болохоор л та нар эмэгтэйчүүд дуугарсангүй гэдэг шүү дээ.

7 дугаар саналаар санал хураая. Гишүүд ээ, анхааралтай байгаарай, саналаа өгөөрэй.

53,8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

8 дугаар санал. Төслийн 2.7 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг гэсний доор дурдсан өөрчлөн найруулах.

6. сум, хорооны 3 мянга хүртэлх хүн амд нэг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан байхаар тооцож, сум, хороо бүрд ажиллуулна. Санал гаргасан ажлын хэсэг.

Ганибал гишүүн үг хэлье. Энэ дээр асуулт байхгүй, үг байгаа. Ганибал, дараа нь Мөнх-Оргил гишүүн.

Н.Ганибал: Үгүй ээ, энэ асуудлуудыг одоо ингээд нөгөө нэг орон тоо, нэг хүний асуудал яригдаад ирэнгүүт цаана нь мөнгө яригдаад л байгаа шүү дээ, тийм үү. Өнөөдөр бид нар ингээд батлах гэж байгаа хууль дээр өнөөдөр авч цаашид батлагдаад шууд хэрэгжүүлэх арга хэмжээ юм уу? Ирэх оны 01 сарын 01-нээс энэ жилийн төсөвт суусан арга хэмжээ юм уу? Үүнийг нэг тодруулаад хэл дээ. Тэгээд яг энэ тоо нь зөв юм уу? Энэ нэг хүнд ноогдох, 1 хүүхэд тийм. Үүнийг

тодруулаад хэлээд өгөөч? Яг энэ заалт дээрээ ажлын хэсгээс асууж байна.

С.Одонтуяа: Хууль яг хэзээнээс хэрэгжих юм бэ? Идэрбат дарга.

Ц.Идэрбат: Энэ дээр, энэ хууль хэрвээ энэ заалт ингээд хэрэгжвэл ер нь зүгээр бидний энэ өнөөдөр ярьж байгаа хуулийн амин сүнс энд байгаа шүү. Өнөөдөр хороон дээр та бүхэн 15 мянгаас 20 мянган хүнтэй хороон дээр дөрөвхөн хүн тавьчихаад, тэр дотор хүүхэд хамгаалал явуулна эд нар гэж бодож байгаа бол эндүүрэл. Өнөөдөр ингээд нэг гарсан кэйс дээр шаагилдаж, бид шогшироод л байгаа болохоос биш дахиж кэйс гаргахгүйн төлөө юм хийх хэрэгтэй байгаа юм. Тийм учраас Улаанбаатар хотод хороон дээр энэ 15-20 мянган хүнд 4 хүн тавьчихаад бид илрүүлнэ, барина, сэргийлнэ гэвэл түүн шиг худлаа юм байхгүй.

3 мянган хүнтэй сумд нийгмийн бодлогын мэргэжилтэн гэдэг ганцхан хүн дээр энэ хөдөлмөр, халамж хамаг юмыг овоолчихоод хүүхэд хамгаалал ярих гэж байгаа бол бас худлаа. Аймгийн төвийн 6 мянган хүн дотор нэг ч ийм хүүхэд хамгааллын ажилтан байхгүй, 3-хан хүн тавьчихаад хүүхдээ хамгаална гэвэл бас худлаа.

Тийм учраас үүнийг 3 мянга гэж ингэж оруулж ирсэн юмаа. 3 мянга гэдэг тоо нь бол энэ Засгийн газрын бас нэг нийгмийн ажилтнуудын стандарт тогтоол байдаг юм билээ. 3 мянган хүн тутамд нэг байна гэж. Энэ хууль, энэ заалт хэрвээ батлагдвал бид энэ хэрэгжих хугацааг нь 2025 оны 01 сарын 01-нээс гэж ингэж үзэж байгаа юм. Сангийн яамнаас тодорхой бас энэ хуулийн төсөл боловсруулах явцдаа санал юмнуудыг нь ажлын хэсгээс авсан. Энэ бол нэг улсын төсөв дээр 1100 орчим хүний асуудал яригдана. Улсын төсөв дээр 16 тэрбум орчим төгрөгний л одоо асуудал яригдах юм байна лээ.

Хэрвээ энэ асуудал шийдэгдэхгүй ингээд унагаад энэ хууль цаашаагаа яваад, одоо байгаа бүтцээрээ, одоо байгаа санхүүжилтээрээ эд нар явна гэж бодож байгаа бол явахгүй. Тэрний оронд бараг хууль санаачлагч нь татаад авчихсан нь дээр. Яагаад гэвэл одоо бид хүн хүч маань тэнд хүрэхгүй, ингэж ажиллаж байгаа үед нь энэ хуулиар маш их юмнуудыг бас шинээр гаргаж өгч байгаа байхгүй юу. Хариуцлагажуулж өгч байгаа юм. Тэгээд гол ингээд хүн, хүчтэй холбоотой асуудлыг нь хасчих юм бол энэ хууль явахгүй шүү гэж би бас ажлын хэсгийн ахлагчийн хувьд бас хэлье гэж ингэж бодож байна. Тэгэхээр энэ дээр нэг 15 тэрбум төгрөг гэдэг чинь өнөөдөр 1500 хүүхдийн сургууль барьж хүрэхгүй мөнгө байгаа шүү. Энэ улсын хэмжээний тогтолцоог бид сайжруулах юмтай харьцуулахад би бол бас Монгол Улсын төсөв энэ зэргийн юмыг даагаад явчих болов уу гэж ингэж бодож байгаа.

С.Одонтуяа: Идэрбат гишүүн үг хэллээ. Мөнх-Оргил гишүүн цөөнх, үг хэлье гэсэн.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Би Нийгмийн бодлогын байнгын хороо дээр ажлын хэсгийн энэ саналын эсрэг санал өгсөн юм. Тэгээд харамсалтай нь цөөнх болоод энэ санал батлагдаад явчихсан юм. Би тэгээд чуулган дээр цөөнх болно шүү гэдгээ хэлсэн юм. Энэ ийм байгаа байхгүй юу, гишүүд ээ. Одоо байгаа тогтолцоо нь болохоор тухайн хороонд, сумд хэдэн байцаагч байх вэ гэдгийг Засгийн газар хүн амын байршил, тоо, тэнд гарч байгаа гэмт хэрэг, эд нарыг үнэлээд Засгийн газар аргачлал гаргачхаж байгаа байхгүй юу. Тэгээд зарим сумд, зарим одоо юу гэдэг юм Сонгинохайрхан дүүргийн хүн ам ихтэй хороололд бол хоёр, гурав, дөрвөөрөө байж болно. Хүн ам цөөтэй бол нэг хоёроороо байж болно, аягүй уян хатан байхгүй юу.

Одоо ингээд оруулаад ирэхээр та нар бодоод үз дээ. Сонгинохайрхан дүүргийн 19 дүгээр хороо ч байдаг юм уу,

20 дугаар хороо 15, 16 мянган хүнтэй. Тэнд нэг хэсгийн төлөөлөгч, нэг нийгмийн ажилтан тэгээд нэг 2 цагдаатай байж байгаа. Тэгтэл тэнд 3 мянган хүн дээр нэг гэр бүл хүүхдийн байцаагч гэхээр цагдаагаасаа олон, нөгөө өрхийн эмнэлгээсээ бараг олон нийгмийн ажилтнууд тэнд очих гээд байгаа байхгүй юу. Тэгээд би бүр аргаа бараад үгүй ээ, ингэж байж болохгүй ээ, одоо ингэх юм бол байна шүү дээ, яг араас нь залгаад ямар ч салбар ороод л ирнэ шүү дээ. Цагдаа тэгвэл 3 мянган хүн дээр нэг цагдаатай болно, 2 мянган хүн дээр нэг цагдаатай больё гээд л ороод ирдэг, тэгээд яах юм. Энэ чинь хэчнээн чухал асуудал гэдгийг бид нар ойлгож байна. Хүүхдээ хамгаалахаас илүү чухал асуудал бидэнд байхгүй. Тэгэхдээ энэ чинь төрийн албаны тогтолцоо, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээ гэдэг чинь бүхэлдээ нэг ийм том тогтолцоо байна шүү дээ. Тэр гээд л дунд дундаас нь салгаад л энэ өнөөдөр хууль баталж байгаа бол энийгээ яачихъя, энэ маргаан хууль баталбал тэрийгээ дэмжчихье гээд ингээд бүхэлдээ тогтолцоог нь алдагдуулаад байж болохгүй байхгүй юу.

Тэгэхээр Засгийн газрын гишүүдийн анх өргөн барьсан тогтоол энэ хуулийн заалт нь яг зөв заалт байгаа байхгүй юу. Хүн амын тоо, байршил, алслагдмал байдал, гарч байгаа гэмт хэргийн тоо, тэнд асрамж хэрэгтэй байгаа хүүхдүүдийн тоо зэргийг харгалзаад Засгийн газар аргачлал баталчихна. Тэр аргачлалын дагуу Засгийн газрын гишүүн тоог нь баталчихна, түүгээр нь санхүүжилтийг нь хийгээд явчихна. Одоо өнөөдөр ийм олон дээд боловсрол эзэмисэн энэ чинь дээд боловсрол эзэмшинэ гэж байгаа шүү дээ. Энэ гэр бүл, хүүхэд хамгаалал хүүхдийн хамгааллын асуудал хариуцсан байцаагч чинь дээд боловсролтой. Тэгээд сум, хороонд очоод ажиллах ийм олон тооны боловсон хүчин угаасаа байхгүй, төсөвт мөнгө нь суугаагүй. Тэгэхээр үүнийг ингэж нөгөө бүхэл бүтэн тогтолцоогоо эвдэж, ингэж нэг асуудал чухал гээд л ерөөсөө бусад бүх юмаа

хаягчаад л ингээд оруулаад ирж болохгүй шүү дээ. Тэгээд юм хэлэхээр хүүхэд хамгаалах асуудлыг эсэргүүцлээ ч гэдэг юм уу, тэрийг дэмжихгүй байна гэж яриад байж болохгүй байхгүй юу. Энэ чинь бид нар төрийн хууль баталж байгаа байхгүй юу.

С.Одонтуяа: Идэрбат гишүүн ээ, хариулах дэг байхгүй юм. Тэгэхээр Өнөрболор гишүүн үг хэлнэ. Зөвхөн үг хэлэх дэг байгаа шүү.

Д.Өнөрболор: Энэ ер нь хүний мөн чанар, энэ ёс зүй, ёс суртахууны хэм хэмжээ алдагдсанаас болж энэ гэр бүлийн болон энэ хүүхдийн эрхийн асуудлаар нийгэмд сэтгэл зүйн асуудал нэлээн тулгамдсан асуудал болж байна. Ер нь энэ хүүхдийн хамгааллын асуудлыг үндсэндээ ингээд цогцоор нь ингээд шийдэх ёстой асуудал байгаа юм. Ер нь олон улсад энэ салбар бүрт байгаа, салбар бүрт тийм ээ, одоо ингээд төрөлжүүлээд, мэргэшүүлээд ийм мэргэжлийн баг ингээд ажиллаж байгаа юм. Манайхан болохоор яах вэ, мэдээж энэ хуулийн төсөл бол тодорхой хэмжээгээр ингээд сайжирсан. Гэхдээ энэ хууль дээр ер нь төрийн л энэ байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үүрэг оролцоог л ингээд нэмэгдүүлээд л тэрийг л одоо ингээд л олон талаас нь ингээд л нэмэгдүүлээд байгаа ийм асуудлыг л юу гэдэг юм, энэ хууль дээр ингээд тусгаад байна.

Ер нь энэ олон улсын энэ нийгмийн аюулаас урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийн зөрчлөөс энэ урьдчилан сэргийлэх асуудлыг тухайн юу гэдэг юм, тэр нөгөө улс орны онцлог дээр тулгуурлаад тийм ээ, одоо ингээд юу, мэргэжлийн төрөлжссөн ийм багуудыг ажиллуулдаг юм байна лээ. Тухайлах юм бол энэ Бельги улс гээд аваад үзэхэд чинь зөвхөн эрүүл мэнд тал дээр нь илүү их ач холбогдол өгөөд, энэ итгэмжлэгдсэн эмчийн үйлчилгээний төвүүдээр дамжуулаад энэ хамгаалах үйлчилгээгээ үзүүлдэг байж байх жишээний. Тэгээд ингээд маш үр дүнд хүрчихсэн байж байх жишээний.

Тэгээд бид нар энэ үр хүүхдээ хамгаалах үйл ажиллагаанаас ингээд мөнгө, санхүүгийн асуудал ингээд л байнгын яриастай, тэндээс одоо ер нь нэг 8 тэрбумын асуудал шийдэх гэж хэчнээн юм болов. Гэтэл олон улсын байгууллагын хийсэн байж байгаа судалгаа дээрээс ингээд аваад үзэхлээр энэ аймаг бүрт дунджаар нэг 3 саяас 77 сая төгрөгөөр юу гэдэг юм, хэмжээд, хуваарилаад хүүхдийн хамгааллын зардалд харилцан адилгүй болох юм байна. Ер нь ойрын хугацаанд бол 21 тэрбум хүргэх ийм шаардлагатай юм байна гэсэн зөвлөмжүүдийг өгсөн байж байгаа. Энэ судалгааг миний хувьд бол уншсан. Тэгээд 21 бүү хэл, 200 тэрбум төгрөгийг зарцуулсан ч яадаг юм. Энэ хүүхдийн хамгааллынхаа асуудал дээр. Тэгээд энэ нийгмийн энэ зөвхөн төрийн байгууллагуудын оролцоо, үүрэг хариуцлага чадавхын л асуудал яриад байх юм. Одоо бид нарын хамгийн наад захын мэддэг энэ “Лантуун дохио” гээд тийм ээ, энэ хүүхдийн эрхийн асуудлаар шүгэл үлээж байгаа, өнөөдөр тийм ээ, ингээд энэ нийгэмд яг энэ чиглэлээр оролцоо, чадавхыг нь тийм ээ, ингээд сайжруулах энэ төрийн бус байгууллагуудын оролцоог ингээд хангаад ажиллуулахад ямар асуудал байгаад байна аа? Яагаад энэ хамтын ажиллагаа, уялдаа тийм ээ, одоо энэ оролцогч талуудын оролцоог энэ цар хүрээг нэмэгдүүлэх тал дээр энэ хууль дээр бас ингээд зохицуулалтуудыг хийж болохгүй байгаа юм бэ? Зөвхөн л төр үүнийг ингээд зохицуулах ёстой юм. Тэгсэн хэр нь ингээд тодорхой үр дүнд хүрсэн асуудал нь маш шүүмжлэлтэй байж байдаг. Тэгээд энэ тал дээр ер нь ингээд зохицуулалт яагаад хийж болдоггүй юм бэ? Би энэ дээр хариулт авмаар байна.

С.Одонтуяа: Хариулт өгөх дэг байхгүй.

Зочид танилцуулъя.

Шихихутуг их сургуулийн Бизнесийн эрх зүйн 2-ын В ангийн

оюутнууд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүгдэд Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе.

Дахин дэг танилцуулъя. Зарчмын зөрүүтэй санал дээр дэмжсэн 3, дэмжээгүй 3 үг хэлэх боломжтой, асуулт асууж, хариулт авах дэг байхгүй байгаа.

Балжиннямын Баярсайхан гишүүн үг хэлнэ.

Б.Баярсайхан: Баярлалаа. Өнөөдөр Монгол Улсад хамгийн эмзэг, 3 хүн тутмын 1 нь ядуу байгаа. Хүүхэд үнэхээр эмзэг, хэцүү нөхцөлд амьдарч байгаа гэдгийг бид нар мэдэж байгаа. Энэ хуулийг олон жил хүлээсэн, нийгмийнхээ шаардлагыг дагаад шинэчилсэн найруулгын төсөл ингээд орж ирж байна. Тэгээд би үнэхээр гайхаж байна. Би төсөв мөнгө хязгаартай гэдгийг мэднэ. Гэхдээ яагаад яг хүүхдийн асуудал болохоор л дандаа хүүхдээсээ харамласан ийм боломжгүй гэсэн ийм үгүйсгэлийг дандаа хийж байдаг юм бэ гэдэг дээр үнэхээр бухимдаж байна. Хөдөө орон нутагт мал хариуцсан 5 хүн байна. Гэтэл хүүхэд хариуцсан мэргэжилтэн байхгүй байна шүү дээ. Энэ дээр бид нар нийгмийн ажилтан, дээр нь нэмээд сэтгэл зүйчийн асуудал ярих ёстой байхгүй юу. Гэтэл хамтарсан баг гээд нэг өрхийн эмч, багийн дарга, цагдаа, нэг нарийн бичигт хариуцуулаад гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн асуудлуудаа хариуцуулчихаад тэд нар дээрээ төсөв мөнгөө хуваарилдаггүй. Ингээд нийгмээрээ гэр бүл, хүчирхийлэл хамгийн өндөр түвшинд бараг дайны үеийн ийм түвшинд хүрчихсэн, амь насаа алдаж байгаа, бидний ирээдүй болсон үр хүүхдүүд маань дандаа дотроо сэмэрсэн, шархалсан, ийм зүрх сэтгэлтэй, гаднаас нь харахад бүтэн ч гэсэн дотроо ийм бүрэн бүтэн биш ийм үндэстэн ингээд араас гарч ирж байна шүү дээ. Энэ хууль чинь 25 оны нэг сараас хэрэгжинэ.

Яагаад бид нар төсөв дээрээ мөнгө тавьж болохгүй байгаа юм бэ. Тэгээд энэ ажлын хэсэг дуугараач ээ та нар, ажлын хэсгээс энэ юугаа хэл л дээ. Үгүй ээ, би Улсын Их Хурлын гишүүдээсээ үнэхээр хүсэж байна, гуйж байна. Бид нарын арай ядан тавьдаг 8 тэрбум төгрөг нэг айлын шкафнаас гарч ирж байгаа биз дээ. Хүүхэд хамгааллын жилийн төсөв. Өнөөдөр нүүрсний хулгай дээр өчнөөн 100 тэрбумаар нь ингээд хулгайлчихсан хулгай гарч ирж байхад яагаад нэг 3 мянга хүн тутам, 3 мянган хүн ам тутамд нэг нийгмийн ажилтан ецэ бид нар цаашаа дахиад нэг нийгмийн ажилтан, нэг сэтгэл зүйч бол заавал байлгах шаардлагатай байгаа.

Өнөөдөр 12 настай хүүхдүүд жирэмсэлж байгаа шүү дээ. 12-17 насны хүүхэд жилдээ 600-аад хүүхдүүд абортод орж байна шүү дээ. Яагаад хүүхдийн асуудал гэхээр яг ингэж дандаа 3 дугаарт, 4 дүгээрт ингээд хандаж байдаг юм бэ гэж үнэхээр бухимдаж байна. Яг энэ дээр эсрэг үг хэлж байгаа, үүнийг дэмжихгүй байгаа хүмүүст үнэхээр энийгээ одоо ойлгооч ээ. Миний бие бараг бүтэн жил шахам энэ Улсын Их Хурлын гишүүдийн хамтаар хүүхдийн байгууллага, хүүхдийн өнөөдөр Хүүхэд хамгааллын хууль хэрхэн хэрэгжиж байгаа талаар маш олон байгууллагаар орсон, орон нутгаар явсан, хамтарсан багуудтай уулзсан. Үнэхээр нөхцөл байдал хүнд. Хамтарсан баг гээд тэр өдөр, шөнөгүй ажиллаж байгаа төрийн албан хаагч нарт чинь нэг айлд хүчирхийлэл гарахад бензин хийгээд явах машин нь ч байхгүй, бичиг цаасны зардал байхгүй, хүчирхийлэлд өртсөн хүмүүстэйгээ уулзах өрөө тасалгаа ч байхгүй байгаа шүү дээ.

Үнэхээр Идэрбат гишүүний хэлж байгаагаар энэ батлагдахгүй л юм бол энэ хууль цаашаа байхын хэрэг байхгүй. Энэ хуулиа одоо буцаагаад эмэгтэйчүүд маань, эмэгтэй гишүүд маань татаж авсан нь дээр. Энэ асуудал шийдэгдэхгүй бол бид нар хүүхдүүдээсээ ингэж гар

татах юм бол үнэхээр өөр юм, өөр ямар ч шийдэл байхгүй ээ гэж хэлмээр байна.

Тэгээд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас яаралтай Нийгмийн ажлын тухай хуулиа оруулж ирээч. Өнөөдөр Монгол Улсад нийгмийн ажилтнууд ямар ч эрх зүйн орчин байхгүй, ямар ч ажлын үнэлэмж байхгүй. Нийгмийн ажилтнаар төгсчхөөд ажлын байрны баталгаа байхгүй, яг чиг үүргийнхээ дагуу ажиллаж чадахгүй ийм нөхцөл байдалд байгаа шүү. Гаднын туршилагаар хамтарсан баг гээд байгуулчихсан, гадаад оронд чинь төсөв мөнгө нь байдаг юмаа, ажиллах хүнийх нь нөөц нь хангалттай байдаг юм.

С.Одонтуяа: Дамдины Цогтбаатар гишүүн үг хэлнэ. Дамдины Цогтбаатар гишүүн. 3 дэмжиж, 3 дэмжихгүй үг хэлж болно.

Д.Цогтбаатар: Гишүүддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ хуулийг дэмжиж байгаа. Би тэгээд гишүүдийгээ дэмжээч ээ гэж уриалмаар байна. Юун, Аргентин улс 46 сая хүнтэй, 21 яамтай байж байгаад буулгаад, 9 яамтай болгож байна. 3 сая хүнтэй Монгол Улс 22 яамтай ичихгүй байж байж, та нар хэдэн хүүхдээс мөнгөө харамлаад. Яамдаа татан буулгаач. Тийм, харин тийм учраас тэрийг нь ч тэгвэл та нар дэмжээд өг л дөө. Яг ийм юман дээр нь орж ирээд мөнгө ингээд ярихаар хүүхдийн асуудал дээр мөнгө байхгүй гээд, төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийг дахиж нэгийг ч битгий байгуулаач гэж санал оруулаад одоо болтол энэ асуудал шийдэгдээгүй явж байна. Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдээ тэгвэл цөөлөөд буулгаач. Тэгээд түүн дээр нь тоо тэндээс чинь хэмнэгдэх зөндөө мөнгө гарч ирнэ. Тэгээд ийм боломжууд байхад үүнийг нь ерөөсөө харахгүй. Төр нь ийм том байх ёстой, 225 мянган юу ажилтнуудтай байх ёстой гээд хэн ч эргэлзэхгүй бодоод, тэгээд түүн дээрээ нэмээд мөнгө бодох гээд байгаа байхгүй юу. Хэн ч түүн дээр нэмж мөнгө бодоогүй байгаа шүү дээ.

Энийгээ хэмнээд багасгаач. Тэгээд мөнгө чинь гараад л ирнэ шүү дээ.

С.Одонтуяа: 3 дэмжиж, 3 цөөнх болсон.

Одоо санал хураалтаар асуудлаа шийднэ. Сая Баярсайхан гишүүн хэлж байна. 7 тэрбум нэг авлигачийн гэрээс гарч байгаа гэж. Хажуугийн зааланд нүүрсний сонсгол дээр 700 тэрбумыг зүгээр хилээр бүртгэлгүй аваад гарчихсан хүмүүс байгаа шүү. Тэгэхээр энэ авлигачдын мөнгийг багасгах хэрэгтэй байна. Хүүхэд рүү аль болох мөнгөө шилжүүлэх хэрэгтэй.

Санал хураалтаар бэлэн үү, гишүүд. Цөөхөн байх шиг байх юм.

Төслийн 8 дугаар саналаар санал хураая. Дахин уншиж өгье.

Төслийн 2 дугаар зүйлийн 6.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах. Ганибал гишүүн ээ, чимээгүй байж байгаарай.

Сум, хорооны 3 мянга хүртэлх хүн амд нэг хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан байхаар тооцож, сум, хороо бүрт ажиллуулна. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал дэмжигдсэнгүй. Тэгэхээр эцсийн хэлэлцүүлэг дээр 3-ны 2-оор бас Байнгын хороон дээр босох боломжтой биз дээ, тийм ээ. 3-ны 2-оор тийм үү.

Бейсен гишүүн санал гаргая гэнэ. Горимын санал. Бейсен гишүүн горимын санал.

Б.Бейсен: Энэ төхөөрөмж ажиллаагүй, дахин санал хурааж өгнө үү.

С.Одонтуяа: Бейсен гишүүний горимын саналаар саяын хураасан санал хураалтыг хүчингүй болгоё гэдгээр санал хураая. Одоо эхлээд ямар ч байсан Бейсен гишүүн горимын санал гаргасан учраас

саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё.

52,5 хувийн саналаар Бейсен гишүүний горимын санал дэмжигдлээ. Саяын санал хураалтыг хүчингүйд тооцъё.

Гишүүд ээ, одоо хариуцлагатай байя, тэгэх үү. Үгүй ээ, санал хураалтаар л яана.

Ажлын хэсгийн дарга горимын санал гаргаж байна. Санал хураахын өмнө Байнгын хороо руу гүйцээн боловсруулахаар чиглэл өгье. Нэгэнт санал хураачихвал болохгүй. Тэгэхээр сая Бейсен гишүүний горимын саналаар хүчингүй болгосон. Үгүй ээ, одоо би санал хураахгүйгээр шууд гүйцээн боловсруулахаар чиглэл өгч байгаа. Үгүй ээ, тэгээд Бейсен гишүүн горимын санал гаргачихлаа шүү дээ. Дэгээ барьчихъя.

9 дүгээр санал. Төслийн 2.8 дугаар зүйлийн 1.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

Монгол Улсын хэмжээнд Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл, орон нутагт Хүүхдийн төлөө зөвлөл нь хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтэд хяналт тавина. Хүүхдийн төлөө үндэсний болон орон нутгийн зөвлөл улирал тутам хуралдаж, хүүхэд хамгааллын талаар хийсэн ажлын тайланг хэлэлцэж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага, холбогдох бусад хуулийн этгээдэд зөвлөмж өгч хүүхэд хамгааллын бодлого тодорхойлох, шийдвэр гаргахад талуудын оролцоог хангаж санал дүгнэлт гаргана. Санал гаргасан ажлын хэсэг.

Үг хэлэх юм уу. Ганибал гишүүн үг хэлье гэж байна.

Н.Ганибал: Яах вэ, бид нар гол асуудлыг ярьж байгаа нь зөв. Өнөөдөр

бид нар бас энэ захиргааны үйл ажиллагаанууд, төрийн хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд бага байгаагаас болоод өнөөдрийн энэ хүүхдийн холбоотой олон янзын гэмт хэргүүд, асуудлууд гарч байгаа гэж харж байгаа бол эндүүрэл шүү. Энэ бол эндүүрэл. Бид нарт өнөөдөр энэ ёс суртахууны энэ үйл ажиллагаанууд дээр бид нар хүний эрхийн, хүүхдийн эрхийн энэ асуудлууд дээр бид нар нийтээрээ энэ, тэр одоо ёс суртахууны доголдол руу гэх юм уу даа, түвшин нь дэндүү доошоо ороод байна. Энэ дээрээ бид нар соён гэгээрүүлэх ажиллагаануудыг маш сайн хийх шаардлагатай байгаа.

Тэгээд би түрүүний асуудал дээр бол дэмжсэн л дээ. Өнөөдөр Монгол Улсад 217 мянган төрийн албан хаагч байгаа. Дээрээс нь 486 мянган тэтгэврийн хүн байна, 170 мянган оюутан байгаа, 180 мянга нь Монгол Улсаасаа дайжаад гадаадад ажил хөдөлмөр эрхлэхээр явчихсан. Монголд нэг 800-аад мянган хүн л хөдөлмөр эрхлээд нэг хүн бараг 4-5 хүн тэжээж байгаа ийм л нөхцөл байдалтай Монгол Улс байгаа. Тэгэхээр энэ зураглалаа хэдүүлээ, нэн ялангуяа өнөөдөр эрх баригч нар харж байгаад, үнэхээр яамд нь илүүдээд байгаа бол тэрийгээ татан буулгахыг нь буулгаад, хүүхдийн эрхийн асуудал дээрээ хүмүүсээ нэмээд, яг ямар бодитой ажил хийх юм тэр хүмүүсээ нэмээд ингээд явбал болж байна. Түүнээс зүгээр өнөөдөр нэг хууль дагуулаад мянган төрийн албан хаагч нэмэгдүүлж, оруулж ирээд байх юм бол бид нар дараа дараагийн бүх хуульд мянга мянгаараа л нэмэгдэнэ. Өнөөдөр бид нар яаж төрийн албан хаагч нараа цөөлж, хамгийн оновчтой хэрэгтэйгээ авч үлдэж, цааш нь явах вэ гэдэг бодлогыг өнөөдөр том зургаар нь нэн ялангуяа Булгантуяа дарга сайд бол үүнийг зурж оруулж ирмээр байна. Тэгээд энэ дээрээ бас асуудлуудаа ярихгүй бол одоо юу гэдэг юм энэ салбарынх нь зөв, энэ салбарынх нь буруу гэдэг байдлаар асуудалд хандах нь ч өөрөө буруу.

Ер нь бид нар, та бүхэн хараарай. Анх орон нутгийн агентлагуудын дарга нарыг бүгдийг нь босоо болгох нэг л хууль орж ирсэн. Өнөөдөр 8 жилийн хугацаанд бүгдийг нь босоо болгоод авчихсан. Яагаад гэхээрээ тэр салбар босоо болгосон юм чинь энэ салбар босоо болгоно гэсээр байгаад өнөөдөр орон нутагт эрх мэдэл гэж юу ч байхгүй болчихсон шүү. Яг үүнийхээ эхлэлийг бид нар тавих гээд байна л даа. Тэгэхээр энэ чинь аливаа юм чинь том зураглалаараа явж байж, зөв голдиролд орно уу гэхээс өнөөдөр нэг салбар дээрээ энэ асуудлаа яриад та нар энэ хүмүүсийн төлөө хүүхдүүдийн төлөө буруу зөрүү бодож байна гээд ингээд нэг хаширч байгаад батлуулчихдаг. Маргааш нь дараагийн эх орноосоо урвах гэж байна гэж байгаад бүх салбарууд чинь ингээд батлуулна. Тэгэхээр ийм байдлаар асуудалд хандах нь өөрөө буруу, хандлагын бас алдаа харагдаад байна. Зөв зохистой тэр төрийн албаны хуваарилалт, бүх асуудлуудаа зөвөөр нь гаргаж ирж байгаад энэ асуудлаа оруулж ирж тайлбарлаж байвал зөв байна шүү. Түүнээс юу гэдэг юм, ямар нэгэн хүйсийн ялгаварлал, асуудалд хандаж байгаа хандлага байдлаар нь асуудалд ингэж ярьж, ингэж асуудлыг шийдэж болохгүй шүү гэдгийг бас хэлье.

Тэгээд энэ удаагийн анхааруулга нь дараагийн салбарууд үүнийг яг давтана гэдгийг би шууд мэргэн хүн шиг хэлчихье. Анх, тийм, би энэ энэ асуудал дээр бол Мөнх-Оргил гишүүн, Сандаг-Очир гишүүн энэ тэртэй санал нэг байгаа юм шүү.

С.Одонтуяа: *Идэрбат гишүүн үг хэлье.*

Ц.Идэрбат: *Гишүүд маань энэ хуулийн төслөө бас би нэлээн уншсан болов уу. Уншаагүй бол нэг сайн тогтоод уншихаарай гэж хүсье. Энэ зүгээр нэг уламжлалт яваад ирж байсан тогтолцоо дээр нь хэдэн хүн нэмэх гээд байгаа асуудал огт биш шүү. Энэ өнөөдөр бид нар ямар нэгэн харамсалтай*

юм болсны дараа бүгдээрээ л шогшироод л байгаа биз дээ. Тийм харамсалтай юм гаргахгүй тогтолцоог л энэ дээр бас бий болгох гэж үзээд байгаа юм. Түүнээс зарим хүмүүсийн инээгээд чи сонгуулийн юм ярилаа гээд ингээд нэг бөөсний онигоо шиг юм болгоныг сонгууль руу битгий холбоод байгаач ээ гэж хүсэх гээд байгаа юм. Мэдэхгүй, та нарт инээдэм байгаа байх. Яг энэ асуудлыг судлаад энэ төрийн бус байгууллагуудтай хүүхдүүдтэй энэ орон нутагт ажиллаж байгаа Сүхбаатар аймгийнхан ч орсон шүү, энд. Мааш зөв зүйтэй санал байна гэж хэлсэн шүү. Сүхбаатар аймгийн Хүүхдийн төлөө төвийн дарга Туул гэж орсон шиг санаж байна. Ийм зүйл хийгээд өгөөч ээ гэж хүсээд байж байхад нь өнөөдөр нэг Сангийн яам нь зөвшөөрчхөөд байхад, нэг сонгууль эд нар ярьж тийм нэг элгийн юм битгий болгоод бай. Би зүгээр шулуухан хэлчихье. Тооцооллыг нь ярьж байна би, тийм. Тэгэхээр ер нь зүгээр та нар эхлээд энэ нэг хуулиа уншаад одоо байгаа тогтолцоо дээр хэдэн хүн автоматаар нэмэх гэж байгаа юм шиг битгий андуураад байгаач ээ гэж би хүсэх гэж байгаа юм. Үл хайхрах гэдэг асуудлууд ч наадах чинь орчихсон ингээд явж байгаа.

Нийслэл дээр байгаа энэ хорооны ажилтнууд чинь бол сайн дурын үндсэн дээр гэрээгээр ажиллаж байгаа шүү, гэрээгээр. Энэ ямар нэгэн нарийн мэргэжлийн хүмүүс биш, хог шороо байвал явж л байдаг, нохой гахай байвал явж л байдаг тийм л хүмүүс байгаа. Энэ хороон дээр ажиллуулах гээд байгаа чинь 20 мянган хүүхэд, 20 мянган иргэн дотор хүүхдийн эрсдэл гарахаас урьдчилан сэргийлэх мэргэжлийн нийгмийн ажилтан байлгах гэж л хичээгээд байгаа юм. Ийм юм байхгүйгээс болоод өглөө болгон ийм юм сонсож байгаа шүү дээ, бид нар бүгдээрээ. Өчигдөр гэхэд нэг 5 согтуу нөхөр л хүүхдээ цасанд очоод суучихсан л явж байгаа биз дээ. Яг иймэрхүү юмыг л бас оруулаад байгаа юмаа гишүүд минь. Үүнийг бас та нар маань зөв талаас нь ойлгоорой гэж би бас хэлье.

С.Одонтуяа: Батсуурь гишүүн үг хэлье.

Ж.Батсуурь: Үгүй ээ, ийм шүү дээ. Зүгээр энд санал хураагаад уначихсан. Тэгээд Бейсен гишүүн юу байна гээд босчихсон. Тэгээд ахиж хураалгана л гэсэн болохоос л тэрийг өөр юм руу аваачаад яриад байх юм. Ер нь хүүхдээсээ мөнгө харамлаад байгаа зүйл бол байхгүй. Тэгэхдээ хаагуур өгч, юу хийлгэх үү гэдэг чинь төрийн бодлогын асуудал байх ёстой. Та нар төрийн түшээ байж байж Сангийн яам зөвшөөрчихсөн, та нар зөвшөөр гэж юу юм. Тэр Сангийн яам Улсын Их Хурлын дээгүүр мөнгө мэддэг юу болчихсон юм. Тэгвэл эндээс гуйгаад байх хэрэг юу байсан юм. Та нар Сангийн яамнаасаа очоод авдаг юм байгаа биз. Бөөсөнд хутга, бүлдэгэнд жад гэж та нар ер нь тэгээд шал өөр юм ярьж байх юм. Ер нь ингэдэг. Эсвэл байна аа, эх орон ярьдаг, үндэсний эрх ашиг ярьдаг. Тэгээд яг гарч байгаа зүйл нь яадаг юм. Техник үйл ажиллагаа л байдаг шүү дээ, та нар.

Өнөөдөр та бүхэн яг ийм үйл ажиллагаануудыг ярьж байгаад нутгийн өөрөө удирдах ёсыг ямар ч хуруу, хумсгүй болгосон. Бүх агентлагуудыг хэвтээ тогтолцооноос босоо болгосон. Орон нутагт анхан шатад эрх мэдэлгүй болохоор энэ хүүхдийн хамгааллын асуудал чинь орхигдоод байгаа юм. Тэр доор байгаа юмыг сайд мэддэг болохоор орхигдоод байгаа юм. Тэгэхээр зэрэг мөнгөгүйдээ тэр болгоныг харж ханддаг хүнтэй болохдоо асуудлыг шийдэж байгаа юм биш л дээ. Монгол Улс чинь гэнэт өнөөдөр бий болчихоогүй, зуу зуун жилийн түүхтэй, мянга мянган жилийн түүхтэй. Үүнийг чинь зохицуулаад ирсэн төртэй байсан. Тэгээд хууль оруулж болно, хуулийг батлуулж болно, бялдаж явна гэх юм бол амжихгүй шүү, та нар.

С.Одонтуяа: Санал хураая гишүүд ээ, санал хураая.

Төслийн 9 дүгээр зүйлээр санал хураана. 9. түрүүн төслийг уншаад

танилцуулчихсан. Энэ бол зүгээр санал, дүгнэлт гаргах ийм томъёолол байсан. Санал хураалт.

Энэ саналыг 59,5 хувийн санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал хураалт.

Төслийн 2.10 дугаар зүйлийн 1.2 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 2.2 дахь заалт нэмэх.

1.2. Төсвийн тухай хуулийн 8.5.1-д заасны дагуу тухайн шатны жилийн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ Хүүхэд хамгааллын үйлчилгээ хамтарсан баг болон Хууль зүйн хорооны үйл ажиллагааны зардлыг тусгах.

2.2 Төсвийн тухай хуулийн 8.5.3-д заасны дагуу тухайн шатны жилийн төсвийн төслийг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ хүүхэд хамгааллын үйлчилгээ, хамтарсан баг болон Хууль зүйн хорооны үйл ажиллагааны зардлыг тусгах. Санал гаргасан ажлын хэсэг. Энэ бол саналуудаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаа танилцуулж батлуулах ийм санал байна. Гишүүд ээ, санал хураалт. Санал хураалт зарлачихлаа шүү дээ, тийм.

55,3 хувийн саналаар санал дэмжигдсэнгүй.

Дараагийнхыг нь яах юм, ирцээ бүрдүүлж байгаад хураахгүй юу.

Баярсайхан гишүүн горимын санал гаргая.

Б.Баярсайхан: Монгол Улс цаашидаа ямар үндэстэн байх юм бэ гэдэг, ямар хүнтэй байх юм бэ, ямар иргэдтэй байх юм бэ, ямар улс орон байх юм бэ гэдгийг шийдвэрлэх ийм гол хууль баталж байхад өнөөдөр Улсын Их Хурлын танхимд ирц хүрэхгүй ийм

байдалтай байна. Тийм учраас Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хойшлуулах санал гаргаж байна. Тэгээд ирц бүрэн байхад энэ хурлаа хийе. Хүүхдүүд рүүгээ бүгдээрээ анхааръя гэж ингэж уриалж байна.

С.Одонтуяа: Гишүүд ирцээ бүрдүүлчих ээ. 1, 2 хүн гарч ороод унаад байх шиг байна. Ирцээ бүрдүүлчих ээ. Гишүүд ирцээ бүрдүүлчих ээ. Ирцээ бүрдүүлээд энэ хуулиа өнөөдөр баталчихмаар байна. Ирцээ бүрдүүл. Үгүй ээ, тэгээд Засгийн газрын гишүүд Засгийн газрын гишүүдээ дуудчих л даа. Засгийн газрын өргөн барьсан, гишүүдээ дууд л даа. Энэ 1, 2 хүнээр л унаад байна шүү дээ, энэ чинь. Гишүүд чинь давхар давхар ажил, энэ хажуугийн Байнгын хороо. Үгүй ээ, одоо ирцээ бүрдүүлээд цаашаа батлаад явмаар байна шүү дээ.

Эсвэл танай бүлэг юу авахгүй юу, завсарлага.

АН-ын бүлэг санал гаргах гэж байна. Ганибал гишүүн.

Н.Ганибал: Энэ хүүхэд хамгааллын чухал асуудлыг хэлэлцэж байхад манай МАН-ын гишүүд маань байхгүй байна, 1-д. Тэгээд энэ 2-т нь, Засгийн газрын гишүүд ер нь асуудал дээрээ яг үнэхээр кабинетын зарчмаа жоохон барьж ажилламаар байна. Дандаа тусдаа тусдаа асуудалтай орж ирэх юм, тэгээд тийм. Тийм учраас энэ асуудлаа Булгантуяа сайд аа, нөгөө сайд нартайгаа сайхан яриад, бүгдээрээ сууж байгаад энэ асуудлаа хэлэлцье ээ, тэгээд.

Ийм учраас Ардын намын гишүүд байхгүй учраас энэ асуудал дээр завсарлага авч, бүрэн бүрэлдэхүүнээр нь хэлэлцсэн үед нь энэ асуудлыг ярилцъя гэсэн саналтай байна.

С.Одонтуяа: Тэгээд үгүй ээ, тэгээд АН-ын бүлгээс завсарлага авч байгаа юм уу? Ганибал гишүүнийг

завсарлага авах гэж байна гэж хэлсэн, зөв үү?

АН-ын бүлэг хугацаагаа хэл дээ, та микрофонд.

Н.Ганибал: Ажлын 5 хоногийн завсарлага хүсэж байна.

С.Одонтуяа: Тэгэхээр АН-ын бүлгийн гишүүд бас Засгийн газрын гишүүдийг тодруулах асуудлууд нэлээн байна. Хоорондоо зөвшилцөх энэ ажлуудаа хийе ээ гэж санал гаргасан. Ажлын 5 хоногийн завсарлага өглөө.

16.15 цаг

Дараагийн хэлэлцэх асуудалдаа оръё.

Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газар 2023 оны 11 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Болорчулуун дарга аа, сайд чинь удахаар бол дараагийн асуудал хэлэлцчихье. Ирж байгаа юм уу?

Төсөл санаачлагч түр байхгүй байгаа учраас түр хойшлуулъя.

Одоо Чинбүрэн даргын нэг асуудал байгаа. Үүнийг оруулъя даа. Болорчулуун дарга аа, яасан, танайх. Тэгвэл энэ Чинбүрэн гишүүний асуудлын дараа оруулъя.

Түр хойшлууллаа.

16.22 цаг

“Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцье.

Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Хянан шалгах түр хорооны дарга Жигжидсүрэнгийн Чинбүрэн танилцуулна. Индэрт урьж байна.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын дэд дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 60 дугаар тогтоолоор байгуулагдсан Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах Түр хорооны 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн хуралдаанаар түр хорооны ажиллах хугацааг сунгах асуудлыг хэлэлцээд, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн тул Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны дарга Чинбүрэнгээс Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах саналыг ирүүлснийг Нийгмийн бодлогын байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Төсөл санаачлагч Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооноос хянан шалгагч, шинжээч нарыг томилон ажиллуулж байгаа бөгөөд хянан шалгагчдын явцад нотлох баримт цуглуулах, газар дээр нь хяналт шалгалт явуулах болон зарим эмийн чанар, стандартыг мэргэжлийн лабораторид шинжлүүлэхэд тодорхой хугацаа шаардлагатай гэж үзэж Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай тогтоолын төслийг боловсруулжээ.

Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.8 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.1 дэх хэсэгт заасны дагуу Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах асуудлыг хэлэлцэх үед Улсын Их

Хурлын гишүүд асуулт асууж, санал хэлээгүй болно.

Байнгын хороо тогтоолын төслийн хэлэлцүүлгийг явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Хянан шалгах түр хорооны ажиллах хугацааг сунгах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж тогтоолын төслийг баталж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

С.Одонтуяа: Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух гишүүдийн нэрсийг бүртгэе.

Булгантуяа гишүүнээр тасаллаа. Сарангэрэл гишүүн. Асуулт асууж үг хэлэх хамт шүү.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Энэ эмийн чанар, аюулгүй байдлын асуудал бол их чухал аа. Ялангуяа одоо томуу, томуу төст өвчин ид их байгаа ийм үед бол эм тарианы асуудлыг бид нар илүүтэй ярих ёстой гэж ингэж бодож байна. Яах вэ, бид нар эм хангамжийн асуудлыг хуучин төр хариуцдаг байхад бол бас төрд асуудлаа тавьдаг байсан бол одоо бол ерөөсөө эм хангамжийн асуудал 100 хувь хувийн өмчийн байгууллагын нуруун дээр ирсэн байгаа. Үүний үр дүнд эмийн хүртээмжийн асуудал бид ярихаа больсон. Харин эмийн чанар, аюулгүй байдал, үр дүн энэ асуудлыг бид нар өнөөдөр хурцаар тавьж ярихаас өөр аргагүй болж байна л даа.

Одоо хүмүүс хэлээд байна л даа. Гадаадад яваад ганц нэг эм аваад ирэхээр

зэрэг илүүтэй хурдан үйлчлээд энэ ханиад томуу их хурдан эдгээд байх юм. Монголдоо эм аваад, тариа тариулаад хэдэн сараар ханиад томуу эдгэхгүй ужгираад байна гэдэг ийм асуудлыг бол ярьж байгаа. Энэ тухай хүн болгон л сонсож байгаа байх. Тухайлбал энэ 4 дүгээр эмнэлэг дээр гарсан асуудал Чинбүрэн гишүүн ээ, тийм ээ, эрүүл мэндийн ажилтнууд бол бидэнд буруу байхгүй. Антибиотик, тэр ампициллинийг бол угаасаа усаар найруулаад, 09-өөр найруулаад ингээд хүүхдүүдэд хуваагаад хийдэг. Тэгэхээр энэ дээр бол энэ 4 дүгээр эмнэлэгт нийлүүлсэн тэр ампициллин болон 09 энэ дээр бол асуудал байна гэдэг ийм зүйлийг яриад байгаа юм билээ. Тэгээд одоогийн байдлаар зөвхөн мэдэгдэж байгаа жишээ нь энэ. Мэдэгдэхгүй өөр ямар зүйлүүд ер нь болж байгаа юм. Эмнэлэг дээр, гэр оронд айл өрхөд өвчин зовлонтой холбоотойгоор хэрэглэж байгаа эм тариа нь үйлчлээд байна уу, түүнээс харшил үүсэж байна уу, юу болж байна, үйлчилж байгаа юм уу гэсэн бүх юм ойлгомжгүй ийм болчихоод байгаа юм л даа. Тэгээд энэ асуудлыг л бас нэг харьцангуй арай өөр түвшинд гаргая, эмийн чанар, аюулгүй байдал дээр хяналт тавья гэдэг ийм хороо яг үнэндээ байгуулагдаж байгаа нь маш зөв. Үүний хугацааг сунгаад ингээд үргэлжлүүлээд үр дүнд хүрэх ёстой гэж бодож байна.

Тэгээд би Чинбүрэн гишүүн, ажлын хэсгийн ахлагчаас асуух гээд байгаа нь энэ 4 дүгээр эмнэлэг дээр болсон энэ байдал юу болсон бэ? Хаанаа буруутай байсан, эм тариандаа байсан уу, эмнэлгийн ажилтантай холбоотой байсан уу, нэг шуугиад өнгөрч байгаа юм уу, үгүй бол үүний учир начир нь олдож байгаа юм уу, судлагдаж байгаа юм уу энэ талаар нэг хариулт аваад тэгээд тодруулъя.

С.Одонтуяа: Чинбүрэн дарга хариулъя.

Ж.Чинбүрэн: Баярлалаа. Бас Эрүүл мэндийн сайд байсан хүн бас чухал

зүйлүүдийг ярьж байна. Ер нь бол эрүүл мэндийн салбарт нэг тодорхойгүй болж байгаа, ард иргэдийн итгэлийг алдагдуулж байгаа зүйл бол энэ эмийн чанарт итгэх асуудал байгаа юм. Ер нь бол хүн өвчтэй хүн итгэл байхад эмчлэгдэх магадлал бараг 50 хувь байхгүй юу. Тийм учраас энэ салбарыг итгэлтэй болгох, ард иргэд Монгол Улсад борлуулагдаж байгаа эм болгон үнэхээр бүртгэгдсэн л бол чанартай байна гэдгийг тийм итгэл төрөх нь өөрөө чухал. Тэгэхээр тэр итгэлийг хэн бүрдүүлэх вэ гэхээр энэ зах зээл дээр тусгай зөвшөөрөл өгөөд, бүртгээд, борлуулж болно гэхээд буцаагаад зах зээлээсээ татаж аваад, чанарыг нь шалгадаг энэ тогтолцоо чинь Монгол Улсад ажиллахгүй байна.

Шалгалт хянан шалгагч нарын нотлох баримт цуглуулах явцад бол ерөөсөө чанар алдагдсан, чанарыг хянах тогтолцоо өөрөө байхгүй байна гэдэг нотолгоотой. Жишээлэх юм бол, гаалиас гүний гааль руу орж ирээд, импортоор орж ирж байгаа эмүүдийнхээ чанарыг бүрэн шалгаж чадаж байна уу? Тэнд байгаа тоног төхөөрөмжүүд нэлээн тийм нарийн шалгалт, омометрийн үзүүлэлтээр тэр тодорхой тэр үзүүлэлтүүдийг нь үздэг аппаратууд гэхээд л ажиллахгүй байх жишээтэй. Тэгээд нэгэнт ингээд зах зээлээс гаалиас хяналтгүй ороод ирэхээр энэ чинь нөгөө цацсан шагай шиг бүх аймгуудаар цацагдаад л тэгээд л тэр эмийг одоо дахиад татаад шалгадаг тогтолцоо өнөөдөр байхгүй ээ.

Бид 2020 оны энэ эрүүл мэнд болон Эрүүл мэндийн даатгалын хууль, Эмийн хуульд өөрчлөлт оруулахдаа энэ эмийн агентлаг байгууллага байгуулаад энэ эмийн агентлагаар дамжуулаад энэ Монгол Улсын зах зээл дээр байгаа эмийн зохицуулалт, чанарыг хянадаг ийм тогтолцоо хийхийг хүсэж энэ хууль баталсан. Тэгтэл одоо энэ эмийн агентлаг нь түр орлон гүйцэтгэгчтэй, одоо хүртэл ажлаа хийж чадахгүй л байж байна шүү дээ. Тийм учраас бид

энэ асуудлыг бол онцгой, бүр Их Хурлаараа түр хороо байгуулан энэ системд болохгүй байгаа, эрүүл мэндийн салбарын итгэлийг алдагдуулж байгаа энэ зүйлүүдийг засах, сайжруулах, мөн хууль, эрх зүйн актуудыг хүртэл гаргах асуудал үүнтэй шууд хамааралтай, холбоотой. Тийм учраас бид энэ хугацаа сунгаад байгаа асуудал бол ерөөсөө нотлох баримтуудыг илүү сайжруулах, илүү баримттай болгох. Одоо ингээд л ганцхан жишээ хэлэхэд л зайлиггүй шаардлагатай 500 гаруй төрлийн эм Их Хурлаас 27 тэрбум байсан өртөгтэй төсвийг өнөөдөр бид 2024 онд, одоо гарлаа 2024 он. 140 тэрбум төгрөг болгож байна, 5 дахин төсвийг нь нэмж өгөөд байхад ард иргэдэд очиж байгаа эмийн чанар дээрдэх юм уу, эсвэл бид хэдхэн цөөхөн компаниудыг мөнгөөр угжаад байгаа юм уу гэдэг асуулт гарч ирж байна. Энд бид хариулт өгөх хэрэгтэй. Энэ хариултыг түр хороо хянан шалгаж гаргаж өгнө.

Тийм учраас бидэнд бас ажиллах нотолгоо бүрдүүлэх энэ цаг хугацаа дэндүү бачуу байгаа учраас сунгуулах талаар бас та бүгдэд энэ хүсэлт гаргаж та бүгдээр тогтоолын төслөө батлуулахаар энд хэлэлцүүлж байна. Тэгэхээр дэмжиж өгөөсэй гэж хүсэж байна.

Өнөөдөр эрүүл мэндийн салбарын гүйцэтгэлийн санхүүжилтийн гол дутагдалтай зүйл юу байна вэ гэхээр эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүндээ хамаг өртөг нь шингэчхээд, нөгөө хийсэн бүтээсэн эмнэлгийн ажилчдадаа нөгөө өртөг нь шингэж чадахгүй, зөвхөн нэг лангууны борлуулалтын, дамжуулан өнгөрөөдөг ийм систем ноёлох хандлагатай болоод байгааг бас судалгааны явцад бол ажиглагдаж байна. Тэгэхээр бид үүнийг бол бас нотолно, нотлох баримтууд цуглуулна.

Сарангэрэл гишүүний бас асуусан 2 дахь асуулт энэ Яармагийн эмнэлэг дээр гарсан тохиолдол байгаа. Энэ дээр Жаргалмаа гишүүн бид 2 бүр өөрсдөө

очиж нөхцөл байдал яг гарсан тохиолдол дээр нь 2 хоногийн дараа очиж, нөхцөл байдалтай танилцсан. Ер нь яг эмч хүний хувьд бол бодоход ерөөсөө л энэ найруулдаг уусмалын алдаа л гарсан гэж бодож байгаа. Тэгэхдээ тухайн дүүргийн цагдаагийн албанаас бүх материалуудыг хурааж авч, тэгээд чанарын шаардлага хангаж байсан уу, үгүй юу гэдгийг шалгах аар судалгаа хийж байгаа юм байна лээ. Тэгэхээр бас нэг зүйл энэ эмийн чанар аюулгүй байдал.../минут дуусав/

С.Одонтуяа: Тодруулахаар тодруулгад хэлчихье. Сарангэрэл гишүүн тодруулъя.

Д.Сарангэрэл: Чинбүрэн дарга аа, энэ иргэдтэй уулзаж байхад эмийн үнийн асуудлыг нэлээн ярьж байна. Та бүхэн маань одоо ингээд ажлын хэсэг маань Түр хороо маань үргэлжлээд ажиллахдаа энэ эмийн үнийн асуудал дээр анхаарч өгөөч ээ гэж. Хамгийн гол нь би бас өнгөрсөн хугацаанд манай энэ Хянан шалгах түр хороо маань ямар ямар ажлыг амжуулав, энэ сунгалтынхаа хугацаанд яг юу юу хийхээр төлөвлөж байгаа гэдгийг бас тодруулах хүсэлтэй байна.

С.Одонтуяа: Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Тэгэхээр би гүйцээгээд хэлэхэд бол Яармагийн эмнэлэг дээр болсон явдал дээр энэ цагдаагийн байгууллага авч шалгаж байгаа. Тэгэхээр нөгөө би түрүүн хэллээ, чанарыг шалгах процесс нь өөрөө нэлээн цаг хугацаа ордог юм байна. Тэгэхээр нөгөө лаборатори олон дээж байгаа, тэр дээж болгон дээр судалгаа хийнэ, шинжилнэ, дээрээс нь тэнд янз бүрийн бактериуд байсан уу, халдвар хамгааллын аюулгүй байдал хангагдсан уу, үгүй юу гээд олон асуудлууд шалгаж байгаа учраас одоогоор яг албан ёсоор хариулт ирээгүй байна. Тэгээд ирэхээр нь бас танд уламжилъя.

Үнийн асуудал бол ерөөсөө л гол асуудал. Өнөөдөр дэлхий дахинд жишээлбэл ухаалаг утаснууд нэг үнээр зарагдаж байхад өнөөдөр Монгол Улсын зах дээр эмийн үнүүд аймаг хооронд, Улаанбаатар аймгуудын хооронд үнэтэй байх төдийгүй улсын эмнэлгүүдийн тендерээр худалдаж авч байгаа эм хүртэл өөр байна. Энэ юуг хэлж байна вэ гэхээр энэ ерөөсөө ямар ч зохицуулалт байхгүй, энэ ерөөсөө л төрийн хулгай энэ... /минут дуусав/

С.Одонтуяа: Баярлалаа. Одоо Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултаа асууна.

Х.Булгантуяа: Би бас үүнийг дэмжиж байгаа юм аа. Одоо томуу, томуу төст өвчин ч ер нь жилжсингээ л гардаг болчхож. Бид нар ер нь эмийг бараг л хоол хүнс шиг л ер нь хэрэглэдэг болчхож дээ. Тэгээд хэрэглээд хэрэглээд өвчин эмгэг нь сайжирсан ч зүйл байхгүй. Тэгээд анх бид нар 2018 онд Эрүүл мэндийн даатгалын санг Эрүүл мэндийн яаманд хариуцуулж өгч байхад энэ 376 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан, Эрүүл мэндийн сан. Энэ бол иргэдийн өөрснөө сайн дураараа төлж байгаа, дээрээс нь нэмээд өөрсдийнх нь цалингаас нь суутгаад авч байгаа энэ Эрүүл мэндийн даатгалын сан 376 тэрбум төгрөг. 2022 онд 1,5 их наяд болсон, сая 2024 онд 2 их наяд төгрөгийн төсөвтэй болох гэж байна. Ийм их төсөвтэй эндээс санхүүжилтүүд нь ихэнх нь улсын эмнэлэг рүү явж байгаа. Улсын эмнэлэг рүү яг ингээд харахаар бараг 5,3 дахин 2018-2024 оны хооронд нэмэгдсэн мөртөө эрүүл мэндийн салбарын ажилтнуудын цалин 5,3 дахин нэмэгдсэн үү гэвэл үгүй. Үүний ихэнх нь бодвол эм тариа руу явж байгаа байх, эм тариа руу. Тэгсэн мөртөө бид нар 5,3 дахин сайн эм, тариа хэрэглэж байгаа юу гэвэл үгүй.

Тэгэхээр бид нар энэ юуг 1 дүгээрт, энэ хүмүүс бүр аргаа бараад жилд бид нар бараг 400 орчим сая ам доллароор, америк доллароор гадагшаа

эмчилгээнд явж байна. Тэгээд үүнийгээ зогсоомоор байна.

2 дугаарт, дээрээс нь нэмээд 3,4-хөн сая хүн бид нар. Сайн чанартай эм хэрэглэмээр байна. Одоо энэ дэлхийн хамгийн сайн Жи эм Пи гээд Гүүд мануфактуринг практисын эмийг бид нар хэрэглэмээр байна гээд ярихаар Монгол эмийн стандарт гээд ингээд ийм юм батална гээд ингээд яриад байх юм. Би одоо ерөөсөө ойлгохгүй юм. Манайх хэдхэн л эм бодвол үйлдвэрлэж байгаа байлгүй дээ. Тэгэхээр бид нар гадаадаас хамгийн сайн эм авахын оронд яагаад Эрүүл мэндийн даатгалын сан 2018 оноос 5,3 дахин төсөв нь эхэлчхээд нэмэгдчихээд байхад бид нар өнөөдөр муу эм өнөөдрийг болтол хэрэглээд байгаа юм бэ? Хэрвээ Эрүүл мэндийн даатгалын сан нь ингэж их сайн нэмэгдчихээд байгаа юм бол эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ яагаад төдийгөөс сайн нэмэгдэхгүй байгаа юм бэ? Энд хэн нэгэн дунд нь шамшигдуулаад байна уу, үгүй юү гэдэг энэ асуудал л яригдаж байна.

Тэгэхээр би үүнийг Чинбүрэн эмчийг мэргэжлийн хүний хувьд та маш сайн дүгнэлт гаргаад, энэ агентлагийн үйл ажиллагааг нэг эрчимжүүлээд, эмийн чанарын асуулт нэг дэлхийн түвшинд гаргаад өгөөч ээ. Тэгвэл бид нар байнга өвддөггүй, өвдөхөөрөө хамаг цалин шиг мөнгөөрөө хоол унд шиг ингэж эм, тариа хэрэглэдэггүй нэг ийм улстай, нэг тогтолцоотой, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээтэй болох юм сан гэж бас олон ээж нар, эмэгтэйчүүд, эцэг эхчүүд хүсэж байгаа байх. Тэгээд энэ сунгах саналыг бол дэмжиж байна.

С.Одонтуяа: Чинбүрэн гишүүн хариулъя.

Ж.Чинбүрэн: Тийм ээ, ер нь 2018 онд эрүүл мэндийн даатгалд Эрүүл мэндийн даатгалын сан тусдаа гардаг бол маш том амжилттай үйл явц болсон. Үүнтэй холбоотойгоор ердөө 380 тэрбум байсан төсөв өнөөдөр бид Их Хурлаас 2 их наяд төгрөг орлогыг нь

ингээж бүрдүүлэхээр төсөвлөж чадаж байна. Энэ бол эрүүл мэндийн салбарыг дэмжиж байгаа том бодлого. Харамсалтай нь, иргэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ чанартай болж уу гээд бодохоор сэтгэл ханамж тийм хэмжээнд биш байна.

2-т, нөгөө тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн салбарын ажилчдын цалин хөлс өнөөдөр ийм хэмжээгээр нэмэгдэж чадаж байна уу? Бас судалгаагаар энэ тийм биш байгаа юм. Үүний ерөөсөө гол шалтгаан бол эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүн түүний үнийн өсөлттэй шууд хамааралтай. Одоо хянан шалгах үйл явцад бол зарим нэг ганц зүйлүүдийг би танд хэлье гэж бодож байна, зориудаар. Жишээлбэл ЭМЯ зарим нэг эмийн компаниуд эм борлуулах эксклюзив гэрээ гэж өгч байна. Эксклюзив гэрээ, эксклюзив гэдэг маань тухайн нийлүүлэгч, үйлдвэрлэгч компани Монгол Улсын дистрибьютер компанид нь ганцхан та манай эмийг борлуулна гэдэг зөвшөөрөл өгдөг. Түүнийг нь ЭМЯ баталж өөр өрсөлдөгч байхгүйгээр ийм барааг нь нийлүүлэх боломж олгож байна. Энэ бараагаа ганцаараа нийлүүлэх боломжтой байна гэдэг бол үнийг хэд дахин өсгөхөд хэн ч өрсөлдөхгүй, маргалдахгүй л гэсэн санаа шүү дээ. Энэ бол ерөөсөө л одоо давуу эрх олгож байгаа энэ үнэтэй болгож байгаа бас нэг жижигхэн жишээ. Үүнтэй ижил төстэй зөндөө олон жишээ би ярьж болно. Даанч бид цаг хугацаа хүрэхгүй байна.

Тийм учраас энэ эмийн түр хороо манай Их Хурлаас өнөөдөр бид энэ нүүрсний хулгайг илрүүлэх, Хөгжлийн банкны энэ хулгайг илрүүлэх, энэ төр давуу эрхээ ашиглан хулгай хийдэг тогтолцоог устгахад мөн ялгаагүй эрүүл мэндийн салбарт байгаа нэг томоохон зүйл бол энэ эмийн үнийн өсөлт юм. Хэр бодитой юм? Өнөөдөр дэлхийн зах зээл дээр байгаа зарим нэг эм Монголд 2 дахин үнэтэй энэ тэр байж байна шүү дээ. Эмийн үнийн өсөлтийг судлаад үзэхэд ерөөсөө нийтээрээ Монголд орж ирж байгаа эм гаальд мэдүүлсэн үнээсээ

1,2-1,6 дахин нэмэгдэж орж ирж байна. Нэмэгдэж орж ирж байна. Энэ юуг хэлж байна гэхээр төр энэ эмийн бодлого дээрээ зохицуулалт хийхгүй бол энэ чинь ерөөсөө болохоо больчихжээ. 100 хувь бид хувийн хэвшилд 30 жил энэ салбарыг хариуцуулаад өгчихсөн. Тэгээд хувийн хэвшлийнхнээ хамгийн хямд үнэтэй эм оруулж ир ээ гэдэг уралдаанд сүүлийн 30 жил мордуулаад ингээд ажиллуулчихсан. Үүний хар балаг нь өнөөдөр эмийн чанар уначихсан, ард иргэд нь эмийнхээ чанартаа итгэхээ больчихсон, тэгээд гаднын эм уухаар зүгээр болдог, Монгол бол эм найдваргүй ээ гэдэг ийм бүр одоо батажсан бэхэжсэн ийм сэтгэл зүйн ийм догма үүсчхээд байна шүү дээ. Гэтэл бас сайн юмнууд бий. Бүх юм хар биш, тийм ээ. Тийм учраас бид энэ тогтолцоог илүү сайн болгох, илүү үр өгөөжтэй болгох явцад энэ түр хорооны ажиллах гол зорилго байгаа юм. Тийм учраас бас таны хэлж байгаа зүйлд итгэл алдахгүйгээр бид бас энэ салбарын булхай, луйврыг илрүүлэх, энэ дээр зохицуулалтгүй байгаа асуудлуудыг ил гаргах, тэгээд бид тогтоол болон шийдвэрүүд мөн хууль, Эмийн хууль бол маш яаралтай бид хэлэлцэх хэрэгтэй байгаа. Энэ асуудлыг ЭМЯ оруулж ирнэ гэдэгт найдаж байна.

Тэгээд энэ асуудлыг бол засахын төлөө хичээж ажиллана. Тэгээд үүний төлөө түр хороо бас нэлээн тийм бие даасан ямар нэгэн нөлөөлөлгүй ажиллаж байгаа гэдгийг бас би энэ индэр дээрээс итгэл төгс хэлж чадна.

С.Одонтуяа: Буланы Бейсен гишүүн асуултаа асууна.

Б.Бейсен: Энэ эмийн үнийн өсөлт, чанарыг хянан шалгах түр хорооны хугацааг сунгах Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжиж байгаа. Учир нь бид эмийнхээ 71 хувийг импорттоор авч байна, 29 хувь дотооддоо үйлдвэрлэж байна. Эмийн салбар үүсэж буй 100 жил болоход булчин юм уу, цутгаргийг антибиотик үйлдвэрлэж чадахгүй байна шүү дээ. Дотоодын эм

үйлдвэрлэлээ хөгжүүлж чадахгүй байна. Энэ импортоор орж ирж байгаа, дотооддоо үйлдвэрлэж байгаа эмийн чанарыг шалгах төв лаборатори маань бас ингээд чанарын шаардлага хангахгүй байна. Энэ үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудал байгаа.

Дараагийн асуудал энэ эмийн үнэ өндөр, үнэхээр их байгаа. Гаалиас орж ирж байгаа гаалийн импортын 10 хувийн татвар байгаа, тэгээд л ханган нийлүүлэх байгууллагын НӨАТ-ын 10 хувь, үнийн өсөлтийн тэгээд 25-30 хувь гээд байгаа. Тэгээд аптекуудын мөн НӨАТ-ын 10 хувь гээд байж байгаа. Бас тэд нар нэг 25-35 хувийг нь нэмж байгаа. Энэ асуудлыг шалгахгүй бол ард иргэд өндөр үнэтэй эмийг авч чадахгүй байна шүү дээ. Даралтын эм диротон 20 гэхэд 26 мянган төгрөгөөр авч байна шүү дээ, 10 хэдэн ширхэг эмийг.

Мөн Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй эмүүд 580 ширхэг гэж байна. Энэ чинь хоёр зуун тавьхан хэдэн ширхэг л эм байгаа. Бусад нь дандаа давхардсан тоогоор бас нэр нь орчихсон. Яах вэ доз нь өөр байж болно л доо. Өөр улсынх байж болно. Үүний цаана бас энэ хөнгөлөлттэй эмийн юунд эм оруулчхаад бас ингээд ашиг хонжоо үзэж байгаа улсууд байна уу? Үүнийг бас шалгах хэрэгтэй. Тендерийн эмийг мөн сая Чинбүрэн гишүүн ярьж байна. Эмнэлэг болгонд өөр өөр байна. Үүнийг бас шалгаад, хөнгөлөлттэй эмийг ч гэсэн жаахан үнэ бууруулаад олгохгүй бол одоо зудын үедээ ч бас өндөр үнэтэй эм авч чадахгүй шүү дээ. Ханиад томууны эм авч чадахгүй байна. Зүрхний өвчтэй юм чинь даралттай улсууд чинь сард 300-500 мянган төгрөгийн эм хэрэглэж байна шүү дээ.

Дараагийн асуудал энэ сумын аптекууд дээр эмийн хангалт муу байна. Аптекуудын энэ эмийн төрлийг олируулах, үнийг нь бууруулах асуудал хөдөөгийн малчдад үнэхээр хүндээр тусаж байна. Энэ эмийн чанар, үнийн асуудлыг бас энэ шалгах хугацааг нь

сунгаж өгөх нь зөв өө гэдгийг дэмжиж үг хэлж байгаа юм аа, би.

С.Одонтуяа: Чинбүрэн гишүүн хариулах уу?

Ж.Чинбүрэн: Бейсен гишүүн бас түр хорооны ажлын хэсэгт орж байгаа, өөрөө эмч мэргэжилтэй хүн байгаа. Тэгээд энэ үнийн өсөлт бол үнэхээр бодитой эсэхийг судлах нь манай түр хорооны ажлын гол үндсэн зорилго.

Тэгэхээр яах вэ, үнэ, чанар 2 бол үнэхээр шууд хоорондоо хамааралтай. Гэхдээ бас энэ үнийн өсөлтөд нөлөөлж байгаа хэд хэдэн зүйлүүдийг Бейсен гишүүн бас зөв хэллээ. Тэгэхээр бас энэ Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас үнийн өсөлтийг бас бодитой бууруулах алхмууд дотор бол энэ татварын асуудлууд ордог, давхардсан татваруудыг үгүй болгох, НӨАТ эд нарыг хасах ч гэдэг юм уу гэх мэтчилэнгийн ийм ард иргэдэд чухал олон нийтийг хамарсан ийм чухал асуудлууд дээр энэ төрөөс барих бодлого дотроо бид бас энэ чанартай юмыг боломжийн үнээр авах гэдэг ийм том бодлого орсон. Энэ ч утгаараа бас ажил үйлчилгээ худалдаж авах, тендерийн хуульд хүртэл энэ шалгуур дээр эмийн худалдан авалт дээр чанарыг 1-д тавих ийм заалт хүртэл оруулж өгсөн нь эрүүл мэндийн салбар дахь эмийн чанарыг бол нэлээн өөрчлөлт авчрахад бас том үүрэг нөлөө үзүүлнэ ээ гэдэгт эргэлзэхгүй байна.

Тэгээд энэ чиглэлээр бид бас түр хороогоороо бодитой нотолгоонууд гаргаж ирж, энэ эмийн үнийн өсөлт бол жинхэнэ зөвхөн хэдхэн компани, байгууллагуудын үйл ажиллагаа байна уу, энэ бодитой юу, биш үү, энэ чанартайгаа уялдаж байгаа юу, үгүй юү гэдгийн чиглэлд илүү их нотлох баримтууд цуглуулж, та бүхэнд танилцуулах болно.

С.Одонтуяа: Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууслаа.

Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 14.12-т хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалтын цагийг урьдчилан зарлана гэсний дагуу Баасан гарагийн үдээс өмнөх хуралдаанаар санал хураая.

16.45 цаг

Одоо түрүүний түр хойшлуулсан Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. Засгийн газар 2023 оны 11 сарын 29-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх.

Болорчулуун сайд орж ирж байна уу? Ирж байна, асуугаад танилцуулгаа хийчихье.

Салбарын сайд нь байхгүй байгаа учраас Хаянгаагийн Болорчулуун гишүүний Засгийн газраас оруулж ирсэн хуулийг түр хойшлууллаа, хэлэлцэхийг.

Өнөөдрийн Пүрэв гарагийн хуралдаанаар хэлэлцэх асуудлууд хэлэлцэж дууслаа.

Чуулганыг хаасныг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ